



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.01.08 № 35-1/07
танай -ны № -т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

П.ОЮУН ЭРДЭНЭ

000254000261



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08.

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас www.cabinet.gov.mn

2025.01.08 № АЭГ/56
танай -ны № -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Төрийн болон орон нутгийн өмчit компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ

000255000350

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлд:

“2.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.01.08 № 01/109

танай 2025.01.08 ны № ХЭГ/55 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн:



9761000025



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025. 01. 08 № 1/73
таний -ны № ХЭГ/55 -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА**

"Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай" хуулийн болон дагалдах бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



151600069
15.01.2025


БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА


Н.УЧРАЛ

БАТЛАВ
САНГИЙН САЙД


Б.ЖАВХЛАН

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД


О.АЛТАНГЭРЭЛ

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН БУТЭЭМЖ,
ИЛ ТОД БАЙДАЛ, ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлэй, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлэлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцуулэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, мөн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,...эрхтэй.” байхаар хуульчилсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.19-д “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн 6.4-т “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтыг тэргүүлэх чиглэл болгон, тус хөтөлбөрийн “ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО”-ын 3.1.2.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.” гэж, “ДӨРӨВ.ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО”-ын 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчтэй аж

ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх..." гэж тус тус заасан.

Түүнчлэн, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас гаргадаг Төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглалын зарчим, аргачлалд "Төрийн өмчит аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөлийн бие даасан байдлыг хүндэтгэн, төлөөлөн удирдах зөвлөл хариуцлагаа үүрэхийг нь зөвшөөрөх, төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос зайлсхийх, төлөөлөн удирдах зөвлөл тодорхойлсон зорилтдоо хүрэхээр хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахыг Засгийн газар зөвшөөрөх нь зүйтэй" гэжээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, одоо ба ирээдүй үеийн иргэн бурд тэгш, шударга хуваарилах, мөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, олон улсын жишиг хандлагыг баримтлан компанийн сайн засаглалыг бүрдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулахтай холбоотой тухайлсан харилцааг зохицуулах анхдагч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

1.2.Практик шаардлага

1.Монгол Улсад эдийн засгийн харилцаанд төр зохицуулагчийн хувиар оролцох бодлогыг баримталдаг хэдий ч зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой улс орнуудад нийтлэг мөрддөг "төрийн зохицуулах болон өмчлөлийн бодлого салангид байх" зарчим зарим талаараа алдагдаж, төрийн болон орон нутгийн өмчийг удирдах ялгаа зааг, ашиглуулах, шилжүүлэх журам тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, төрийн бодлогыг уялдуулах нэрийн дор төрийн өмчит компанийн бизнесийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж оролцох, төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага олон улсад тогтсон шаардлагаас доогуур, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь төрийн захиргааны албан хаагч байх болзлыг хуульчилсантай холбогдуулан төрийн захиргааны албан хаагч, улс төрийн албан тушаал хашиж байсан этгээдийг төлөөлөн удирдах зөвлөлд томилох, томилуулахаар нэр дэвшиүүлж байгаа нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг мэргэжлийн бус болгож, компанийн сайн засаглалын тогтолцоо бүрдэх нөхцөлийг хааж байна.

2.Зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйд үүсэж болох эерэг, сөрөг үр дагаврын талаарх үндэслэл бүхий тооцоо, судалгаагүйгээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг үүсгэн байгуулж, хувийн хэвшилтэй өрсөлдөж зах зээлд оролцох нь нэмэгдэж, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог дэмжихэд сөргөөр нөлөөлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан тоон мэдээллээр Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 99 байгаагаас ТӨХК-48, ТӨХХК-23, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд-11, төрийн өмчит үйлдвэрийн газар-17, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өрхийн эмнэлэг, эм зргэлтийн сан, нөхөрлөл, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд зэргийг багтааж тооцвол нийт 472 хуулийн этгээд байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани гэх ойлголтыг нарийвчлан тодорхойлоогүй, зөвхөн Компанийн тухай хуулийн 2.5-д “Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна” гэж заасан зохицуулалтын хүрээнд энэ төрлийн харилцааг тогтоож байна.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг Иргэний хуульд зааснаас өөрөөр буюу аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн тооцоотой, эсхүл улсын төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар хэлбэрээр байгуулж байгаа нь хуулийн этгээдийн засаглал, зохицуулалтыг ойлгомжгүй болгож байна.

Иймд төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаарх ойлголт, түүнийг үүсгэн байгуулах үндэслэл, шаардлага, шалгуурыг ойлгомжтой болгож, тооцоо судалгаа, үндэслэлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулдаг тогтолцоог өөрчилж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн хамарч зохицуулах шаардлагатай байна.

3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой толгой 99, охин хараат компаниудыг оролцуулаад нийт 123 компани нь 2023 оны жилийн эцсийн байдлаар Эрчим хүч, зам, тээвэр, уул уурхай, банк, санхүү, мэдээлэл, харилцаа холбоо, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилга, хот байгуулалт, байгаль орчин, аялал жуулчлал, биеийн тамир, спорт, соёл урлаг, гадаад харилцаа зэрэг 11 салбарт нийт 58,087 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулсан байна. Мөн хувьцаа эзэмшигчийн 100 хувийн эрхийг хэрэгжүүлж байгаа 42 хуулийн этгээд, Эрчим хүчний яам-27, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар-15 (Эрдэнэс Монгол нэгдэл), Сангийн яам-7, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам-1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-4, Зам, тээврийн хөгжлийн яам-3 хуулийн этгээд байна. Эдгээр компани, үйлдвэрийн газрууд нь 2023 онд нийт 23 их наяд 617 тэрбум төгрөгийн орлого, 16 их наяд 912 тэрбум төгрөгийн зардал, 4 их наяд 983 тэрбум төгрөг буюу 21.1%-ийн цэвэр ашиг, 64 их наяд 200 тэрбум төгрөгийн нийт хөрөнгө, 7.76%-ийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан байна.

Мөн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 43% нь алдагдалтай ажилласан, тайлант оны нийт цэвэр ашгийн дүнгийн 92%-ийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-3.5 их наяд төгрөг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-803 тэрбум төгрөг, “Хөдөө аж ахуйг дэмжих корпораци” ХХК-101 тэрбум төгрөг, “Төрийн банк” ХК-94.7 тэрбум төгрөг, “МИАТ” ТӨХК-52 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан зэрэг цөөн хэдэн компани эзэлж байна.

Харин орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 275 хуулийн этгээдийн хувьд 13 хувьцаат компани 21.6 тэрбум төгрөг, 31 хязгаарлагдмал хариуцлагатай компани 18 тэрбум төгрөг, 200 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 45.9 тэрбум төгрөг, 31 төсөвт үйлдвэрийн газар 1.6 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу нийт 87.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан дүн мэдээ гарсан байна.

Дээрх тоо баримтаас хараад хуулийн этгээдийн зардал өндөр, эзэмшиж байгаа хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй харьцуулахад ашигт ажиллагаа, өгөөжийн түвшин бага, санхүүгийн сахилга бат сул, үр ашиггүй, ихээхэн хэмжээний алдагдалтай ажиллаж, компанийн үйл ажиллагаа, чиг үүрэг, санхүүгийн шийдвэр, худалдан авах ажиллагаа, тайлан мэдээллийн нээлттэй, ил тод байдал хангалтгүй, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын 2024 онд баталсан Төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглалын зарчим, аргачлалд заасан компани дахь төрийн аудитын хяналтаас гадна хөндлөнгийн аудит хийлгэх ажлыг сайжруулах шаардлагатай байна.

4.Компанийн засаглалын олон улсын зарчим, Монголын компанийн засаглалын кодекст зааснаар компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан урт хугацааны ногдол ашгийн бодлоготой байх ёстой гэж үздэг. Тухайлбал, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 2024 онд баталсан Төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглалын зарчим, аргачлалд "Төрийн өмчийн компаниуд нь өгөөжийн хувь, ногдол ашгийн бодлого, мөн капиталын бүтцийн зохистой байдлыг тодорхойлох журам зэргийг баталж, үйл ажиллагаандaa мөрдөж ажиллавал зохино" гэжээ.

2023 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 99 аж ахуйн нэгжээс 449.8 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр төвлөрүүлснээс "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 415.5 тэрбум, "Төрийн банк" ХК 23.6 тэрбум, "Улаанбаатар төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэг 2.4 тэрбум, "Монголросцветмент" ТӨҮГ 2.1 тэрбум, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК 1.1 тэрбум төгрөг буюу нийт 444.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг эдгээр 5 хуулийн этгээд төвлөрүүлсэн тоон мэдээ байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн, өмчийн оролцоотой компаниуд зарим тохиолдолд цэвэр ашигтай ажиллаж байгаа боловч ногдол ашиг төвлөрүүлдэггүй, эсхүл ногдол ашиг төвлөрүүлсэн ч урт хугацааны ногдол ашгийн талаарх компани тус бүрийн онцлогт тохирсон бодлого тодорхойгүйгээс ашгийн хэмжээнээс хамаараад янз бүрийн хувь хэмжээгээр ногдол ашиг хуваарилж байгаа нь компанийд нэмэлт хөрөнгө оруулалт хийх, засан сайжруулалт, шинэ үйл ажиллагаа эхлүүлэх зэрэг бизнесийн үйл ажиллагааг нь хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна.

5.Компанийн тухай хуулийн 75.4 дэх хэсэгт "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна" гэж заасан. Судалгаанаас хараад, орон нутгийн өмчит компанийдын төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 3-9 тооны гишүүнтэй байна. Орон нутгийн жижиг компанийд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо их (9) байх нь удирдлагын зардал нэмэгдэх, орон тооны зохистой түвшин алдагдах зэрэг серег үр дагавартай байна.

Мөн орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах, дүрэм батлах эрхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд тусгаагүй учир аймаг, нийслэлийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын хүрээнд уг асуудлыг зохицуулж байна. Орон нутгийн өмчит компани, аж ахуйн нэгж бүрийн дүрэм харилцан адилгүй, төлөөлөл хэрэгжүүлэгч этгээд болон гүйцэтгэх захирлыг томилох, гэрээ байгуулах, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах, бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг дүгнэх, үйл ажиллагаа, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах асуудал нь харилцан адилгүй янз бүрийн байдлаар хэрэгжиж байна.

Тухайлбал, хувьцаа эзэмшигчдийн хурал, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, эсхүл Засаг даргын шийдвэрээр орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, эдгээр хуулийн этгээдийн ихэнх буюу 231 байгууллагын гүйцэтгэх захирлыг Засаг дарга томилж, гэрээ байгуулан дүгнэх, эдгээрийн 130 байгууллагын бизнес төлөвлөгөөг Засаг дарга баталж, дүгнэх, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газарт төлөөлөн удирдах зөвлөл томилон ажиллуулах, үүнд нийслэл болон 13 аймгийн нийт 52 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь төлөөлөн удирдах зөвлөлтэй бөгөөд нийт 308 хүн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, даргаар томилогдон ажиллаж, нэг талдаа хувьцаа эзэмшигчийн хувиар компанийн үйл ажиллагаанд зарцуулах төсвийг баталж, нөгөө талд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хувиар уг төсвийн төсөл боловсруулж, танилцуулж байгаа нь хяналт тавих боломжгүй, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөлийг бүрдүүлж байна.

Эдгээр практик нөхцөл шалтгааны улмаас төр болон орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхээ ил тод, шударга, хариуцлагатай, өрсөлдөөнд саад учруулахгүй хэрэгжүүлэх, төр болон орон нутаг бизнесийн үйл ажиллагаа эрхэлж зах зээлд оролцох оновчтой загварчлалыг бий болгосон хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журам, ангилал, компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, хяналт, удирдлага, зохион байгуулалт болон төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж, компанийн сайн засаглал, ил тод байдлыг сайжруулж, санхүүгийн ашигт ажиллагаа, өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино.

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана:

➤ Хуулийн төслийн нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэлд хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төрөл, хэлбэр, төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийг тогтооно;

➤ Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журмыг тусгана;

- Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, алтан хувьцаа гаргах нөхцөл, компанийн хөрөнгө оруулалтыг сайжруулах зорилгоор үнэт цаас гаргах, зээл авах, ногдол ашиг хуваарилах бодлоготой зохицуулалтыг тусгана;
- Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх, төрийн өмчит компанийн талаарх Засгийн газрын болон орон нутгийн өмчит компанийн талаарх аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын болон орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын чиг үүргийг тогтооно;
- Хуулийн төслийн тавдугаар бүлэгт хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, хүлээх үүрэг хариуцлага, томилох, чөлөөлөх үндэслэл, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагаар ажиллаж буй этгээдэд олгох цалин, урамшуулалтай холбогдох зохицуулалтыг тусгана;
- Хуулийн төслийн зургаадугаар бүлэгт компанийн дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоотой холбоотой харилцааг тусгана;
- Хуулийн төслийн долоодугаар бүлэгт компанийн бизнес төлөвлөгөө болон төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлах, түүний гүйцэтгэлийг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна;
- Хуулийн төслийн наймдугаар бүлэгт компанийг өөрчлөн байгуулах, нэмэлт хувьцаа гаргаж, үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох, компанийг татан буулгах, татан буугдах үеийн эд хөрөнгийн зохицуулалттай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ;
- Хуулийн төслийн есдүгээр бүлэгт компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, нөөц сан, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой журмыг тогтооно;
- Хуулийн төслийн аравдугаар бүлэгт хууль хүчин төгөлдөр болох, хариуцлага хүлээлгэх болон шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг баталснаар Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн хөгжилд чухал ач холбогдол бүхий бодлогын чанартай дараах үр дагавар бий болно:

- ✓ Төр нь эдийн засгийн харилцаанд зохицуулагчийн хувиар оролцох Үндсэн хуулийн үзэл санаа болон ардчилсан үзэл санаа бүхий зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой улс орнуудад нийтлэг мөрддөг “төрийн зохицуулах болон өмчлөлийн бодлого салангид байх” зарчим хууль тогтоомжид тусгалаа олж, бодитойгоор хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

✓ Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшилтэй тэгш нөхцөл, ижил дүрмээр аж ахуй эрхлэх замаар баялгийг бий болгох, баялгийг оновчтойгоор дахин хуваарилах тогтолцоог бий болгох суурь нөхцөл бүрдэнэ.

✓ Иргэний хууль дахь хуулийн этгээдийн хэлбэрийг зөрчиж байгуулсан төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн статусыг тодорхой болгоно.

✓ Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой, төрийн оролцоо шаардлагагүй, зах зээлийн зарчмаар хөгжих боломжтой тодорхой салбарт төр хутгалдан орж, өрсөлдөөнийг хязгаарлах, алдагдал учруулах бизнесийн эрсдэлээс зайлсхийх боломж олгоно.

✓ Компанийн засаглалыг сайжруулж, хяналтын тогтолцоо, ил тод байдал, үүрэг хариуцлага, ашигт ажиллагаа нэмэгдэж, санхүүгийн үр ашиг, компанийн үнэ цэн ёсөж, татварын орлого, төрийн эзэмшлийн ногдол ашиг сайжирна.

✓ Төр болон орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхээ ил тод, шударга, хариуцлагатай, өрсөлдөөнд саад учруулахгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй уялдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтооолын төслийг боловсруулна.

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН
БҮТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДАЛ, ЗАСАГЛАЛЫГ
САЙЖРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

(Дэлгэрэнгүй танилцуулга)

Нэг. Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтыг тэргүүлэх чиглэл болгон, тус хөтөлбөрийн “ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО”-ын 3.1.2.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.” гэж, “ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО”-ын 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх...” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.19-д “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашигийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн 6.4-т “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлэй, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлэйн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, мөн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хурээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,...эрхтэй.” байхаар хуульчилсан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашигийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, мөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, олон улсын жишиг хандлагыг баримтлан компанийн сайн засаглалыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Энэ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасны дагуу холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгалаа:

1.Төр, орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхийг ард түмнийг төлөөлөн хэрэгжүүлж байгаагийн хувьд энэхүү онцлог байдалд нь нийцсэн, ил тод, хяналттай, эдийн засгийг зохицуулагчийн чиг үүргээ хувьцаа эзэмшигчийн чиг үүргээсээ салангид хэрэгжүүлэх боломжийг олгосон эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг зорилоо.

Төрийн болон орон нутгийн өмчит компани хариуцлага, эрх, үүргийн хувьд улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх, үр ашигтай байх, хараат бус хөндлөнгийн хяналттай байх, компанийн үйл ажиллагаа ил тод байх, компани төр, эсхүл орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх зарчмыг хуулийн төсөлд тусгасан. Мөн төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд үр ашиггүй зардал гаргахгүй байх, мэргэжлийн байх, санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллах, хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх зарчмыг хэрэгжүүлэхээр төсөлд тусгалаа.

2.Төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулах үндэслэл, журмыг тусгалаа. Ингэснээр төр, орон нутаг эдийн засгийн тооцоо, судалгаагүйгээр хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой салбарт компани үүсгэн байгуулах боломжгүй болох юм.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан 2023 оны тоон мэдээллээс үзэхэд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 99 байгаагаас ТӨХК-48, ТӨХХК-23, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд-11, төрийн өмчит үйлдвэрийн газар-17 байна. Харин орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өрхийн эмнэлэг, эм эргэлтийн сан, нөхөрлөл, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд зэргийг багтааж тооцвол нийт 472 хуулийн этгээд байна.

Иймд цаашид хувийн хэвшил хийх боломжгүй, ашиггүй, төрөөс үзүүлэх зайлшгүй шаардлагатай үйлчилгээ буюу нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулахаар тусгасан.

Мөн үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор стратегийн ач холбогдолтой салбарт зайлшгүй үйл ажиллагаа явуулах, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор төрийн өмчийн компани байгуулахаар хуулийн төсөлд нарийвчлан тусгасан.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг Иргэний хуулийг зөрчиж тогтоосон нь тухайн төрлийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үйлчилж байгаа бусад эрх зүйн зохицуулалтад хийдэл үүсэх шалтгаан болж, улмаар

хууль хэрэглээний практикт төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон хувийн хэвшлийн хуулийн этгээдэд ялгамжтай, тэгш бус хандах нөхцөлийг бүрдүүлж байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит компаниас гадна аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн тооцоотой, эсхүл улсын төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар хэлбэртэй хуулийн этгээд байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг болсон нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжгүй, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд эдгээр үйлдвэрийн газрыг зохицуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгааг цаг алдалгүй шийдвэрлэх шаардлага үүссэн.

Хуулийн төсөлд эдгээр үйлдвэрийн газруудаас ашгийн төлөө хуулийн этгээдийг компани хэлбэрт оруулж, цаашид үйлдвэрийн газар статустай хуулийн этгээд байгуулахгүй байхад чиглэнэ. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчит компанийг эзэмшлийн хувь хэмжээгээр нь буюу төр, эсхүл орон нутаг компанийн гаргасан энгийн хувьцааг бүхэлд нь эзэмшдэг бол төрийн болон орон нутгийн өмчийн компани, төр, эсхүл орон нутаг компанийн гаргасан энгийн хувьцааны тодорхой хувийг эзэмшдэг бол төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани гэсэн хоёр төрлөөр компанийг ангилахаар тусгасан.

4. Төрийн өмчит нэг компанид төрийн хэд хэдэн байгууллага хувьцаа эзэмшигчийн эрхийг хувааж хэрэгжүүлдэг явдлыг таслан зогсоож, Засгийн газрын шийдвэрээр тогтоосон нэг этгээд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Түүнчлэн, хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, компанийн засаглалд оролцох хүрээ, хязгаарыг нарийвчлан тусгасан. Тухайлбал, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох, чөлөөлөх, төрийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хувьцааг худалдах, шилжүүлэх, төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар Засгийн газарт санал оруулах, төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүү тооны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх санал гаргах зэрэг бүрэн эрхтэй байхаар тусгалаа.

5. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавих шаардлагыг олон улсад тогтсон шаардлагаас доогуур тогтоож, төрийн захиргааны албан хаагч, эсхүл улс төрийн албан тушаал хашиж байсан этгээдийг төлөөлөн удирдах зөвлөлд томилох, томилуулахаар нэр дэвшүүлж байгаа нь компанийн засаглалыг сулруулах, мэргэжлийн бус томилгоо, улс төрийн нөлөөлөл бий болох боломжийг бүрдүүлж байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд улс төрийн албан тушаалтан, нутгийн захиргааны байгууллагын дарга, мэргэжилтнийг оруулж байна. Тухайлбал, аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүний бие төлөөлөгч гэх зэрэг албан тушаалтыг томилох байдал нийтлэг байна.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас гаргадаг Төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглалын зарчим, аргачлалд “Төрийн өмчит аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөлийн бие даасан байдлыг хүндэтгэн, төлөөлөн удирдах зөвлөл хариуцлагаа үүрэхийг нь зөвшөөрөх, төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос зайлсхийх, төлөөлөн удирдах зөвлөл тодорхойлсон зорилтдоо хүрэхээр хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахыг Засгийн газар зөвшөөрөх нь зүйтэй” гэж, мөн 7 дугаар бүлэгт “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг, үүнд төрийн албан хаагч эсэхээс үл хамааран мэдлэг, чадварын мерит зарчимд үндэслэн нэр дэвшиүүлж, томилох, бүх гишүүд хуулийн адил хариуцлагатай байх нь зүйтэй” гэжээ. Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны албан хаагчийг албан тушаалын хувьд төлөөлөн удирдах зөвлөлд томилох бус, мерит зарчимд тулгуурлан тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиүүлж, сонгон шалгаруулах нь компанийн засаглал сайжрах, төлөөлөн удирдах зөвлөл мэргэжлийн, чадварлаг болоход зерэг нөлөө үзүүлэх болно.

Энэ хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, хүлээх үүрэг хариуцлага, томилох, чөлөөлөх үндэслэлийг нарийвчлан тусгасан.

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, сонгон шалгаруулалт, цалин, урамшуулалтай холбоотой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Тухайлбал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд мерит зарчмын үндсэн дээр олон улсын стандартад нийцсэн шаардлага тавихын сацуу нэр дэвшиүүлж, сонгон шалгаруулах процессыг ил тод, шударга, хараат бус, мэргэжлийн, өрсөлдөөнт болгох талаар зохицуулалтыг төсөлд тусгасан болно.

Төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 хүртэлх гишүүнтэй байх бөгөөд тусгай шаардлагыг хангасан нэр дэвшигчийг нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтын үндсэн дээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгож, томилох зохицуулалтыг тусгасан.

Судалгаанаас харахад, орон нутгийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 3-9 тооны гишүүнтэй байна. Орон нутгийн жижиг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо их (9) байх нь удирдлагын зардлыг нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байгаа тул тухайн компанийн хэмжээ, нөхцөл байдлаас хамаарч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог тодорхойлох, жижиг хэмжээний компанийд 5 хүртэлх сондгой тооны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхаар тусгалаа.

Түүнчлэн, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд аливаа хэлбэрийн тэтгэмж олгохгүй байхаар хуулийн төсөлд тусгав.

7. Төрийн болон орон нутгийн өмчит компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаагаа тайлагнах үүргийг хуульчилж, гүйцэтгэлийг үнэлэх, үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний талаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэхдээ системийн ач холбогдол бүхий дулаан, эрчим хүчний зэрэг компанийн хувьд удирдлагын хариуцлагыг уян хатан байдлаар шийдвэрлэх онцлог зохицуулалтыг тусгалаа.

8. Гүйцэтгэх удирдлагыг төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж, гэрээ байгуулах, түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр цалин хэлс олгох, компанийн зорилгод нийцсэн ашигт ажиллагаа бий болсон, компанийн зах зээлд эзлэх байр суурь ёсөн нэмэгдсэн бол нэмэгдэл урамшуулалт олгооор гэрээнд зааж болохоор тусгасан болно.

9. Ногдол ашиг хуваарилах зарчмыг тодорхойллоо. Компанийн засаглалын олон улсын зарчим, компанийн засаглалын кодекст зааснаар компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан урт хугацааны ногдол ашгийн бодлоготой байх ёстой гэж үздэг. Тухайлбал, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 2024 онд баталсан Төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглалын зарчим, аргачлалд “Төрийн өмчийн компаниуд нь өгөөжийн хувь, ногдол ашгийн бодлого, мөн капиталын бүтцийн зохицой байдлыг тодорхойлох журам зэргийг баталж, үйл ажиллагаандaa мөрдөж ажиллавал зохино” гэжээ.

2023 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 99 аж ахуйн нэгжээс 449.8 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр төвлөрүүлснээс “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 415.5 тэрбум, “Төрийн банк” ХК 23.6 тэрбум, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг 2.4 тэрбум, “Монголросцветмент” ТӨҮГ 2.1 тэрбум, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК 1.1 тэрбум төгрөг буюу нийт 444.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг эдгээр 5 хуулийн этгээд төвлөрүүлсэн тоон мэдээ байна. Төрийн болон орон нутгийн өмчийн, өмчийн оролцоотой компаниуд зарим тохиолдолд цэвэр ашигтай ажиллаж байгаа боловч ногдол ашиг төвлөрүүлдэггүй, эсхүл ногдол ашиг төвлөрүүлсэн ч урт хугацааны ногдол ашгийн талаарх компани тус бүрийн онцлогт тохирсон бодлого тодорхойгүйгээс ашгийн хэмжээнээс хамаараад харилцан адилгүй хувь хэмжээгээр ногдол ашиг хуваарилж байгаа нь компанийд нэмэлт хөрөнгө оруулалт хийх, шинэ техник, технологи нэвтрүүлэх зэрэг бизнесийн үйл ажиллагааг нь хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана:

➤ Хуулийн төслийн нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэлд хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, төрийн болон орон нутгийн өмчийн компанийн ангилал, хэлбэр, төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийн талаар тусгалаа. Хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журмыг тогтоох, компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлага, зохион байгуулалт, хяналт, ил тод байдал, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийг Засгийн газар өргөн мэдуулснээр Улсын Их Хурал батлах бөгөөд үндсэн чиглэлд төрийн өмчит компанийн хувьцаа эзэмших, хянах зорилго, үндэслэл, төрийн өмчит компанийн жагсаалт, хөрөнгийн багц мэдээлэл, төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, төрийн өмчит компани шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах бүтцийн өөрчлөлт, шинэтгэлийн төлөвлөгөө зэргийг тусгахаар орууллаа.

➤ Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журмыг тусгах бөгөөд нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулах, үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор стратегийн ач холбогдолтой салбарт зайлшгүй үйл ажиллагаа явуулах, тодорхой салбарт зүй ёсны монополь үйл ажиллагаа эрхлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжих, эсхүл хууль болон олон улсын хувийн эрх зүйн гэрээнд заасны дагуу төрийн өмчит компани байгуулахаар хүрээ, хязгаарыг тогтоов.

➤ Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, алтан хувьцаа гаргах нөхцөл, компанийн хөрөнгө оруулалтыг сайжруулах зорилгоор үнэт цаас гаргах, зээл авах, ногдол ашиг хуваарилах бодлоготой холбоотой зохицуулалтыг тусгасан;

➤ Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх, төрийн өмчит компанийн талаарх Засгийн газрын болон орон нутгийн өмчит компанийн талаарх аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын болон орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын чиг үүргийг хуульчлан тогтоосон;

➤ Хуулийн төслийн тавдугаар бүлэгт хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, хүлээх үүрэг хариуцлага, томилох, чөлөөлөх үндэслэл, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд олгох цалин, урамшуулалтай холбогдох зохицуулалтыг тусгасан;

➤ Хуулийн төслийн зургаадугаар бүлэгт компанийн дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоотой холбоотой харилцааг тусгаж, төрийн болон орон нутгийн өмчийн компанийн аудитын тогтолцоо нь төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, дотоод аудитын нэгж, дотоод аудитор, хөндлөнгийн аудитаас бүрдэхээр тогтоосон;

➤ Хуулийн төслийн долоодугаар бүлэгт компанийн бизнес төлөвлөгөө болон төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлах, түүний гүйцэтгэлийг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гүйцэтгэх захирлын гэрээний хэрэгжилтийн тайланд үндэслэн компанийн гүйцэтгэл, төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайланг жил бүр үнэлж дүгнэх, хангалтгүй үнэлэгдсэн бол гүйцэтгэх захирлын гэрээг сунгахгүй байх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан томилохгүй байх, хариуцлага хүлээлгэж чөлөөлөх хүртэл арга хэмжээ авах талаар тодорхой тусгав;

➤ Хуулийн төслийн наймдугаар бүлэгт компанийг өөрчлөн байгуулах, нэмэлт хувьцаа гаргаж, үнэт цаасны зах зээлд нийтэд санал болгох, компанийг татаан буулгах, татаан буугдах үеийн эд хөрөнгийн зохицуулалттай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр тусгасан бөгөөд Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан нийтлэг журмыг баримтлахыг зааж өгсөн;

➤ Хуулийн төслийн есдүгээр бүлэгт компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, нөөц сан, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой журмыг тогтоож, төрийн болон орон нутгийн өмчит компани үйл ажиллагаандаа компанийн засаглалын зарчим, кодексыг хэрэгжүүлдэггүй, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан ил тод бус, мэдээлэл нээлттэй биш байна. Иймд төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд хамааралтай нийт 74 мэдээллийг цахим хуудсандaa ил тод, нээлттэй байлагах үүргийг хуульчилж, мэдээлэх үүргээ биелүүлэх талаар тусгав;

➤ Хуулийн төслийн аравдугаар бүлэгт хууль хүчин төгөлдөр болох, хариуцлага хүлээлгэх болон шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгалаа. Энэ хүрээнд хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд компани, эсхүл нийтийн үйлчилгээний байгууллага хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах арга хэмжээ авахаар заасан.

Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн хөгжилд чухал ач холбогдол бүхий бодлогын чанартай дараах үр дагавар бий болно гэж үзэж байна:

- ✓ Төр нь эдийн засгийн харилцаанд зохицуулагчийн хувиар оролцох Үндсэн хуулийн үзэл санаа болон ардчилсан үзэл санаа бүхий зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой улс орнуудад нийтлэг мөрддөг “төрийн зохицуулах болон өмчлөлийн бодлого салангид байх” зарчим хууль тогтоомжид тусгалаа олж, бодитойгоор хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
- ✓ Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшилтэй тэгш нөхцөл, ижил дүрмээр аж ахуй эрхлэх замаар баялгийг бий болгох, баялгийг оновчтойгоор дахин хуваарилах тогтолцоог бий болгох суурь нөхцөл бүрдэнэ.
- ✓ Иргэний хууль дахь хуулийн этгээдийн хэлбэрийг зөрчиж байгуулсан төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн статусыг тодорхой болгоно.
- ✓ Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой, төрийн оролцоо шаардлагагүй, зах зээлийн зарчмаар хөгжих боломжтой тодорхой салбарт төр хутгалдан орж, өрсөлдөөнийг хязгаарлах, алдагдал учруулах бизнесийн эрсдэлээс зайлсхийх боломж олгоно.
- ✓ Компанийн засаглалыг сайжруулж, хяналтын тогтолцоо, ил тод байдал, үүрэг хариуцлага, ашигт ажиллагаа нэмэгдэж, санхүүгийн үр ашиг, компанийн үнэ цэн ёсөж, татварын орлого, төрийн эзэмшлийн ногдол ашиг сайжирна.
- ✓ Төр болон орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхээ ил тод, шударга, хариуцлагатай, өрсөлдөөнд саад учруулахгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН
БҮТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДАЛ, ЗАСАГЛАЛЫГ
САЙЖРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

(Товч танилцуулга)

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтыг тэргүүлэх чиглэл болгон, тус хөтөлбөрийн "ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО"-ын 3.1.2.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ." гэж, "ДӨРӨВ.ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО"-ын 4.1.4.2-т "Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх..." гэж тус тус заасан.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.19-д "Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна." гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ийн 6.4-т "Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна." гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлэй, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлэйн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно." гэж, мөн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,...эрхтэй." байхаар хуульчилсан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, мөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, олон улсын жишиг хандлагыг баримтлан компанийн сайн засаглалыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Энэ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасны дагуу холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгалаа:

1.Төр, орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхийг ард түмнийг төлөөлөн хэрэгжүүлж байгаагийн хувьд энэхүү онцлог байдалд нь нийцсэн, ил тод, хяналттай, эдийн засгийг зохицуулагчийн чиг үүргээ хувьцаа эзэмшигчийн чиг үүргээсээ салангид хэрэгжүүлэх боломжийг олгосон эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг зорилоо.

Төрийн болон орон нутгийн өмчит компани хариуцлага, эрх, үүргийн хувьд улс төрийн нэлөөллөөс ангид, хараат бус байх, үр ашигтай байх, хараат бус хөндлөнгийн хяналттай байх, компанийн үйл ажиллагаа ил тод байх, компани төр, эсхүл орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх зарчмыг хуулийн төсөлд тусгасан. Мөн төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд үр ашиггүй зардал гаргахгүй байх, мэргэжлийн байх, санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллах, хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх зарчмыг хэрэгжүүлэхээр төсөлд тусгалаа.

2.Төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулах үндэслэл, журмыг тусгалаа. Ингэснээр төр, орон нутаг эдийн засгийн тооцоо, судалгаагүйгээр хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой салбарт компани үүсгэн байгуулах боломжгүй болох юм.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан 2023 оны тоон мэдээллээс үзэхэд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 99 байгаагаас ТӨХК-48, ТӨХХК-23, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд-11, төрийн өмчит үйлдвэрийн газар-17 байна. Харин орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өрхийн эмнэлэг, эм эргэлтийн сан, нөхөрлөл, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд зэргийг багтааж тооцвол нийт 472 хуулийн этгээд байна.

Иймд цаашид хувийн хэвшил хийх боломжгүй, ашиггүй, төрөөс үзүүлэх зайлшгүй шаардлагатай үйлчилгээ буюу нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулахаар тусгасан.

Мөн үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор стратегийн ач холбогдолтой салбарт зайлшгүй үйл ажиллагаа явуулах, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор төрийн өмчийн компани байгуулахаар хуулийн төсөлд нарийвчлан тусгасан.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг Иргэний хуулийг зөрчиж тогтоосон нь тухайн төрлийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үйлчилж байгаа бусад эрх зүйн зохицуулалтад хийдэл үүсэх шалтгаан болж, улмаар

хууль хэрэглээний практикт төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон хувийн хэвшлийн хуулийн этгээдэд ялгамжтай, тэгш бус хандах нөхцөлийг бүрдүүлж байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит компаниас гадна аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн тооцоотой, эсхүл улсын төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар хэлбэртэй хуулийн этгээд байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг болсон нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжгүй, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд эдгээр үйлдвэрийн газрыг зохицуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгааг цаг алдалгүй шийдвэрлэх шаардлага үүссэн.

Хуулийн төсөлд эдгээр үйлдвэрийн газруудаас ашгийн төлөө хуулийн этгээдийг компани хэлбэрт оруулж, цаашид үйлдвэрийн газар статустай хуулийн этгээд байгуулахгүй байхад чиглэнэ. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчит компанийг эзэмшлийн хувь хэмжээгээр нь буюу төр, эсхүл орон нутаг компанийн гаргасан энгийн хувьцааг бүхэлд нь эзэмшдэг бол төрийн болон орон нутгийн өмчийн компани, төр, эсхүл орон нутаг компанийн гаргасан энгийн хувьцааны тодорхой хувийг эзэмшдэг бол төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани гэсэн хоёр төрлөөр компанийг ангилахаар тусгасан.

4.Төрийн өмчит нэг компанийд төрийн хэд хэдэн байгууллага хувьцаа эзэмшигчийн эрхийг хувааж хэрэгжүүлдэг явдлыг таслан зогсоож, Засгийн газрын шийдвэрээр тогтоосон нэг этгээд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Түүнчлэн, хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, компанийн засаглалд оролцох хүрээ, хязгаарыг нарийвчлан тусгасан. Тухайлбал, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох, чөлөөлөх, төрийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хувьцааг худалдах, шилжүүлэх, төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар Засгийн газарт санал оруулах, төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүү тооны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх санал гаргах зэрэг бүрэн эрхтэй байхаар тусгалаа.

5.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавих шаардлагыг олон улсад тогтсон шаардлагаас доогуур тогтоож, төрийн захиргааны албан хаагч, эсхүл улс төрийн албан тушаал хашиж байсан этгээдийг төлөөлөн удирдах зөвлөлд томилох, томилуулахаар нэр дэвшүүлж байгаа нь компанийн засаглалыг сулруулах, мэргэжлийн бус томилгоо, улс төрийн нөлөөлөл бий болох боломжийг бүрдүүлж байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд улс төрийн албан тушаалтан, нутгийн захиргааны байгууллагын дарга, мэргэжилтнийг оруулж байна. Тухайлбал, аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүний бие төлөөлөгч гэх зэрэг албан тушаалтыг томилох байдал нийтлэг байна.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас гаргадаг Төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглалын зарчим, аргачлалд “Төрийн өмчит аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөлийн бие даасан байдлыг хүндэтгэн, төлөөлөн удирдах зөвлөл хариуцлагаа үүрэхийг нь зөвшөөрөх, төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос зайлсхийх, төлөөлөн удирдах зөвлөл тодорхойлсон зорилтдоо хүрэхээр хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахыг Засгийн газар зөвшөөрөх нь зүйтэй” гэж, мөн 7 дугаар бүлэгт “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг, үүнд төрийн албан хаагч эсэхээс үл хамааран мэдлэг, чадварын мерит зарчимд үндэслэн нэр дэвшүүлж, томилох, бүх гишүүд хуулийн адил хариуцлагатай байх нь зүйтэй” гэжээ.

Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны албан хаагчийг албан тушаалын хувьд төлөөлөн удирдах зөвлөлд томилох бус, мерит зарчимд тулгуурлан тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, сонгон шалгаруулах нь компанийн засаглал сайжрах, төлөөлөн удирдах зөвлөл мэргэжлийн, чадварлаг болоход эерэг нөлөө үзүүлэх болно.

Энэ хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, хүлээх үүрэг хариуцлага, томилох, чөлөөлөх үндэслэлийг нарийвчлан тусгасан.

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, сонгон шалгаруулалт, цалин, урамшуулалтай холбоотой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Тухайлбал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд мерит зарчмын үндсэн дээр олон улсын стандартад нийцсэн шаардлага тавихын сацуу нэр дэвшүүлж, сонгон шалгаруулах процессыг ил тод, шударга, хараат бус, мэргэжлийн, өрсөлдөөнт болгох талаар зохицуулалтыг төсөлд тусгасан болно.

Төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 хүртэлх гишүүнтэй байх бөгөөд тусгай шаардлагыг хангасан нэр дэвшигчийг нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтын үндсэн дээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгож, томилох зохицуулалтыг тусгасан.

Судалгаанаас харахад, орон нутгийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 3-9 тооны гишүүнтэй байна. Орон нутгийн жижиг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо их (9) байх нь удирдлагын зардлыг нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байгаа тул тухайн компанийн хэмжээ, нөхцөл байдлаас хамаарч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог тодорхойлох, жижиг хэмжээний компанийд 5 хүртэлх сондгой тооны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхаар тусгалаа.

Түүнчлэн, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд аливаа хэлбэрийн тэтгэмж олгохгүй байхаар хуулийн төсөлд тусгав.

7. Төрийн болон орон нутгийн өмчит компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаагаа тайлагнах үргийг хуульчилж, гүйцэтгэлийг үнэлэх, үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний талаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэхдээ системийн ач холбогдол бүхий дулаан, эрчим хүчний зэрэг компанийн хувьд

удирдлагын хариуцлагыг уян хатан байдлаар шийдвэрлэх онцлог зохицуулалтыг тусгалаа.

8. Гүйцэтгэх удирдлагыг төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж, гэрээ байгуулах, түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр цалин хөлс олгох, компанийн зорилгод нийцсэн ашигт ажиллагаа бий болсон, компанийн зах зээлд эзлэх байр суурь өсөн нэмэгдсэн бол нэмэгдэл урамшуулал олгооор гэрээнд зааж болохоор тусгасан болно.

9. Ногдол ашиг хуваарилах зарчмыг тодорхойллоо. Компанийн засаглалын олон улсын зарчим, компанийн засаглалын кодекст зааснаар компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан урт хугацааны ногдол ашгийн бодлоготой байх ёстой гэж үздэг. Тухайлбал, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 2024 онд баталсан Төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглалын зарчим, аргачлалд “Төрийн өмчийн компаниуд нь өгөөжийн хувь, ногдол ашгийн бодлого, мөн капиталын бүтцийн зохистой байдлыг тодорхойлох журам зэргийг баталж, үйл ажиллагаандaa мөрдөж ажиллавал зохино” гэжээ.

2023 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 99 аж ахуйн нэгжээс 449.8 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр төвлөрүүлснээс “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 415.5 тэрбум, “Төрийн банк” ХК 23.6 тэрбум, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг 2.4 тэрбум, “Монголпросцветмент” ТӨҮГ 2.1 тэрбум, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК 1.1 тэрбум төгрөг буюу нийт 444.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг эдгээр 5 хуулийн этгээд төвлөрүүлсэн тоон мэдээ байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн, өмчийн оролцоотой компаниуд зарим тохиолдолд цэвэр ашигтай ажиллаж байгаа боловч ногдол ашиг төвлөрүүлдэггүй, эсхүл ногдол ашиг төвлөрүүлсэн ч урт хугацааны ногдол ашгийн талаарх компани тус бүрийн онцлогт тохирсон бодлого тодорхойгүйгээс ашгийн хэмжээнээс хамаараад харилцан адилгүй хувь хэмжээгээр ногдол ашиг хуваарилж байгаа нь компанийд нэмэлт хөрөнгө оруулалт хийх, шинэ техник, технологи нэвтрүүлэх зэрэг бизнесийн үйл ажиллагааг нь хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн хөгжилд чухал ач холбогдол бүхий бодлогын чанартай дараах үр дагавар бий болно гэж үзэж байна:

✓ Төр нь эдийн засгийн харилцаанд зохицуулагчийн хувиар оролцох Үндсэн хуулийн үзэл санаа болон ардчилсан үзэл санаа бүхий зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой улс орнуудад нийтлэг мөрддөг “терийн зохицуулах болон өмчлөлийн бодлого салангид байх” зарчим хууль тогтоомжид тусгалаа олж, бодитойгоор хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

✓ Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшилтэй тэгш нөхцөл, ижил дүрмээр аж ахуй эрхлэх замаар баялгийг бий болгох, баялгийг оновчтойгоор дахин хуваарилах тогтолцоог бий болгох суурь нөхцөл бүрдэнэ.

✓ Иргэний хууль дахь хуулийн этгээдийн хэлбэрийг зөрчиж байгуулсан төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн статусыг тодорхой болгоно.

✓ Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой, төрийн оролцоо шаардлагагүй, зах зээлийн зарчмаар хөгжих боломжтой тодорхой салбарт төр хутгалдан орж, өрсөлдөөнийг хязгаарлах, алдагдал учруулах бизнесийн эрсдэлээс зайлсхийх боломж олгоно.

✓ Компанийн засаглалыг сайжруулж, хяналтын тогтолцоо, ил тод байдал, үүрэг хариуцлага, ашигт ажиллагаа нэмэгдэж, санхүүгийн үр ашиг, компанийн үнэ цэн өсөж, татварын орлого, төрийн эзэмшлийн ногдол ашиг сайжирна.

✓ Төр болон орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхээ ил тод, шударга, хариуцлагатай, өрсөлдөөнд саад учруулахгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав.

-----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН БҮТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДАЛ, ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журмыг тогтоох, компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлага, зохион байгуулалт, хяналт, ил тод байдал, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах хууль тогтоомж

2.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль², Иргэний хууль, Компанийн тухай хууль³, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бурдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.

3.2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн өмчтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

3.3.Тухайлсан хуулийн дагуу байгуулагдсан төрийн өмчит компанийн үйл ажиллагааг тухайн хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 3.1, 3.2-т заасны дагуу зохицуулна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

³ Компанийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

3.4.Хот, тосгоны өмчит компанийн үйл ажиллагаанд энэ хуульд заасан орон нутгийн өмчит компанийн зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төрийн өмчит компани” гэж төр энэ хуульд заасны дагуу хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл хяналт хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг;

4.1.2.“орон нутгийн өмчит компани” гэж орон нутаг энэ хуульд заасны дагуу хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл хяналт хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг;

4.1.3.“төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани” гэж компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг төр, эсхүл орон нутаг эзэмшдэг хуулийн этгээдийг;

4.1.4.“нийтийн зориулалттай дэд бүтэц” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д заасныг;

4.1.5.“нийтийн үйлчилгээ” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.13-т заасныг.

5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.ил тод, нээлттэй байх;

5.1.2.үр ашигтай байх;

5.1.3.зах зээлд шударга өрсөлдөх, аливаа хэлбэрээр давуу эрх эдлэхгүй байх;

5.1.4.монополь, эсхүл давамгай байдлаа урвуулан ашиглахгүй байх;

5.1.5.компанийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;

5.1.6.улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх;

5.1.7.компани төрийн болон орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх;

5.1.8.тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжих;

5.1.9.шинэ технологи, инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах.

5.2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд энэ хуулийн 5.1-д зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.2.1.Засгийн газрын бүрэн эрх, орон нутгийн эрх хэмжээ компанийн удирдлагын бүрэн эрхээс тусгаарлагдсан байх;

- 5.2.2.бүх хувьцаа эзэмшигч тэгш нөхцөлөөр хангагдах;
- 5.2.3.хараат бус хөндлөнгийн хяналттай байх;
- 5.2.4.мэргэжлийн байх;
- 5.2.5.ур ашиггүй зардал гаргахгүй байх;
- 5.2.6.эрх бүхий этгээдийн баталсан санхүүгийн болон бизнесийн төлөвлөгөөний дагуу ажиллах;
- 5.2.7.хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх;
- 5.2.8.цаг хугацаандаа, үнэн зөв тайлагнах.

6 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн ангилал, хэлбэр

6.1.Төрийн өмчит компанийг тухайн компанийн хувьцааны төрийн эзэмшлийн хувь хэмжээнээс хамааруулан дараах байдлаар ангилна:

6.1.1.компанийн нийт гаргасан энгийн хувьцааг бүхэлд нь төр дангаараа эзэмшдэг бол төрийн өмчийн компани;

6.1.2.компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг төр эзэмшдэг бол төрийн өмчийн оролцоотой компани.

6.2.Орон нутгийн өмчит компанийг тухайн компанийн хувьцааны орон нутгийн эзэмшлийн хувь хэмжээнээс хамааруулан дараах байдлаар ангилна:

6.2.1.компанийн нийт гаргасан энгийн хувьцааг бүхэлд нь орон нутаг дангаараа эзэмшдэг бол орон нутгийн өмчийн компани;

6.2.2.компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг орон нутаг эзэмшдэг бол орон нутгийн өмчийн оролцоотой компани.

6.3.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Компанийн тухай хуулийн 3.4-т заасан хэлбэртэй байна.

7 дугаар зүйл.Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэл

7.1.Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

7.2.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газрын гишүүдийн саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.8-д заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.

7.3.Үндсэн чиглэлд дараах зүйлийг тусгана:

7.3.1.төрийн өмчит компанийн хувьцаа эзэмших, хянах зорилго, үндэслэл;

7.3.2.төрийн өмчит компанийн жагсаалт, хөрөнгийн багц мэдээлэл;

7.3.3.төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага;

7.3.4.үндсэн чиглэлийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн;

7.3.5.төрийн өмчит компани шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах бүтцийн өөрчлөлт, шинэтгэлийн төлөвлөгөө.

7.3.6.төрийн өмчит компанийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах төлөвлөгөө.

7.4.Үндсэн чиглэлд энэ хуулийн 8.1-д заасан төрийн өмчит компани байгуулах үндэслэлийг компани тус бүрээр тодорхойлж тусгана.

7.5.Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газарт хүргүүлнэ.

7.6.Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлсэн энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг Улсын Их Хуралд танилцуулна.

7.7.Үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн жил бүрийн тайланг Засгийн газар болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ

8 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл

8.1.Төрийн өмчит компанийг дараах үндэслэлээр үүсгэн байгуулна:

8.1.1.нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулах;

8.1.2.үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор стратегийн ач холбогдолтой салбарт зайлшгүй үйл ажиллагаа явуулах;

8.1.3.тодорхой салбарт зүй ёсны монополь үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжих;

8.1.5.хууль болон олон улсын хувийн эрх зүйн гэрээнд заасны дагуу.

8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт компани үүсгэн байгуулахад хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй, зах зээлийн төвлөрөл өндөртэй байх нөхцөлийг хангасан байна.

8.3.Орон нутаг зөвхөн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 8.1.1-д заасан үндэслэлээр орон нутгийн өмчит компанийг үүсгэн байгуулна.

8.4.Энэ хуулийн 8.1.4-т заасан үндэслэлээр зөвхөн төрийн өмчийн компани байгуулна.

8.5.Энэ хуульд зааснаас өөр үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулахыг хориглоно.

9 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах санал, шийдвэр

9.1.Төрийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт хүргүүлнэ.

9.2.Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

9.3.Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах саналд дараах баримт бичгийг хавсаргана:

9.3.1.компанийн дүрмийн төсөл;

9.3.2.энэ хуулийн 8.1-д заасан компани байгуулах үндэслэл болон энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлд нийцсэн талаарх төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын гаргасан дүгнэлт.

9.4.Энэ хуулийн 9.3.2-т заасан дүгнэлтийг дараах мэдээлэлд үндэслэн гаргана:

9.4.1.компани үүсгэн байгуулах хэрэгцээ, шаардлага, зах зээлийн эрэлт, хүлээлт, компаниас гаргах бараа, ажил, үйлчилгээний жагсаалт, тэдгээрийг борлуулах чадамж, бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх байдлын талаарх зах зээлийн судалгаа, байршил;

9.4.2.хөрөнгө оруулалтын хэмжээ, төр, эсхүл орон нутгаас оруулах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, хөрөнгө оруулалтыг бүрэн хийж дуусах хугацаа, түүнийг нөхөн болон эргэлтийн эх үүсвэр бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд тавигдах шаардлага;

9.4.3.бараа, ажил, үйлчилгээнд шаардагдах түүхий эд, эрчим хүч, ажиллах хүч болон бусад шаардлагатай хүчин зүйлийг хангах эх үүсвэр, чадамж;

9.4.4.салбарын хөгжлийн төлөвлөгөө, бодлогод нийцсэн байдал, нийгэм, эдийн засгийн үр ашгийн тооцоолол;

9.4.5.компанийн үйл ажиллагаа явуулах хугацаа, түүний үндэслэл.

9.5.Төрийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийг Засгийн газар, төрийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах шийдвэрийг Засгийн газрын

зөвшөөрлийг үндэслэн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, бусад хувьцаа эзэмшигч хамтран Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргана.

9.6.Орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргах бөгөөд орон нутгийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлийг үндэслэн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, бусад хувьцаа эзэмшигч хамтран Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргана.

9.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг хугацаатай байгуулах бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацаа дууссан тохиолдолд хугацааг сунгах, эсхүл компанийг татан буулгах асуудлыг энэ хуулийн 9.5, 9.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн дүрэм

10.1.Засгийн газар төрийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэр гаргахдаа компанийн дүрмийг батална.

10.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэр гаргахдаа компанийн дүрмийг батална.

10.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна компанийн зорилго, хүрэх үр дүн, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн талаарх мэдээллийг тодорхой тусгана.

10.4.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 89.4-т заасан зохицуулалт хамаарахгүй.

10.5.Энэ хуулийн 10.1-д заасан компанийн дүрмийн төслийг боловсруулахад төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, энэ хуулийн 10.2-т заасан компанийн дүрмийн төслийг боловсруулахад орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын саналыг авсан байна.

11 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн охин компани, салбар, төлөөлөгчийн газар

11.1.Төрийн өмчийн компани охин компани байгуулах тохиолдолд Засгийн газар, орон нутгийн өмчийн компани охин компани байгуулах тохиолдолд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 9.3-т заасан баримт бичгийг үндэслэн тус тус шийдвэр гаргана.

11.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА,
НОГДОЛ АШИГ**

12 дугаар зүйл.Хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө, түүний хэмжээг өөрчлөх

12.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрт компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг тусгасан байна.

12.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл энэ тухай санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын таван өдрийн дотор хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид мэдэгдэнэ.

12.3.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 12.2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг өөрчлөн байгуулах, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах тухай саналаа төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газарт, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, шийдвэрлүүлэх үүрэгтэй.

13 дугаар зүйл.Алтан хувьцаа

13.1.Засгийн газар төрийн өмчит компанийн төрд ногдох хувьцааг бүхэлд нь худалдах тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд компанийн удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй алтан хувьцаа эзэмшихээр зааж болно.

13.2.Алтан хувьцаатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын дараах шийдвэр нь үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт харшилсан гэж үзвэл Засгийн газар хориг тавина:

13.2.1.өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэл, үндсэн үйл ажиллагааг өөрчлөх;

13.2.2.хувьцаа эзэмшигчийн эрхийг өөрчилсөн дүрэм, журам батлах;

13.2.3.компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;

13.2.4.их хэмжээний хэлцэл байгуулах;

13.2.5.бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох.

13.3.Энэ хуулийн 13.2-т заасан шийдвэрийг хүлээн авснаас хойш Засгийн газар ажлын 15 өдрийн дотор хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

13.4.Засгийн газар хориг тавих шийдвэр гаргаагүй бол энэ хуулийн 13.2-т заасан хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

13.5.Засгийн газар энэ хуулийн 13.2-т заасны дагуу хориг тавих тухай шийдвэртээ хориг тавьж байгаа үндэслэлээ заана.

13.6.Нээлттэй хувьцаат компани болсны дараа алтан хувьцаа эзэмшихийг хориглоно.

13.7.Алтан хувьцааг бусдад шилжүүлэхийг хориглоно.

13.8.Энэ хуулийн 13.1-д заасан хугацаа дуусмагц алтан хувьцаа хүчингүй болох бөгөөд хугацааг дахин сунгахгүй.

14 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийд хөрөнгө олж авах

14.1.Үндэсний баялгийн сангийн тухай, Ашигт малтмалын тухай болон бусад хуульд заасан үндэслэл, журмын дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа компанийн хувьцааг эзэмших замаар төр хөрөнгө олж авч болно.

14.2.Дараах тохиолдолд төр, эсхүл орон нутаг нь компанийн энгийн хувьцааг олж авч болно:

- 14.2.1.бэлэглэл, өв залгамжлалаар эзэмшилдээ олж авсан;
- 14.2.2.Иргэний хуульд заасан арилжааны гэрээний дагуу;
- 14.2.3.шүүх, арбитрын шийдвэрийн дагуу.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасны дагуу компанийн энгийн хувьцаа 34-өөс доош хувийг олж авсан бол төр, эсхүл орон нутаг тухайн хувьцааг олж авахад зарцуулсан хөрөнгийн зардал болон хувьцааны бодит үнэлгээг тооцон, түүнээс доошгүй үнээр тухайн хувьцааг худалдана.

14.4.Энэ хуулийн 14.3-т заасан компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, эсхүл хаалттай хувьцаат компани бол тухайн олж авсан хувьцааг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу бусад хувьцаа эзэмшигчид тэргүүн зэлжид худалдаж авахыг санал болгоно.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасны дагуу санал болгосон хувьцааг тэргүүн зэлжид худалдаж аваагүй тохиолдолд нээлттэй дуудлага худалдаагаар худалдана. Нээлттэй дуудлага худалдаагаар худалдах хувьцааны үнэ энэ хуулийн 14.3-т зааснаас доошгүй байна.

14.6.Энэ хуулийн 14.3-т заасан компани нь нээлттэй хувьцаат компани бол тухайн олж авсан хувьцааг арилжаа эрхлэх байгууллагаар дамжууллан худалдана.

14.7.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу төр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа компанийн хувьцааны 34-өөс доош хувийг олж авсан тохиолдолд тухайн компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл.Үнэт цаас гаргах, зээл авах

15.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу үнэт цаас гаргаж болно.

15.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн зээл авч болно.

15.3.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан зөвшөөрөлд тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр авах үнэт цаас, зээл хамаarahгүй.

15.4.Гүйцэтгэх захирал зээлийн гэрээний дагуу төлбөл зохих хуваарь болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг төлж барагдуулах төлөвлөгөө, хуваарийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлнэ.

16 дугаар зүйл.Ногдол ашиг

16.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани ногдол ашиг хуваарилахад Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

16.1.1.өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн жилийн эцсийн тайлан дахь татвар төлсний дараах цэвэр ашгийн тодорхой хувиар;

16.1.2.төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тодорхой хувиар.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн нийт дүнгийн доод хэмжээг Улсын Их Хурал, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсөвт тусган батална.

16.3.Тухайн төсвийн жилд баримтлах энэ хуулийн 16.1-д заасан хувь болон ногдол ашиг төлөх үүргээс чөлөөлөгдөх компанийн жагсаалтыг Улсын Их Хурал, тухайн шатны Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсөвтэй хамт батална.

16.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасны дагуу тооцсон дүнгийн аль өндөр дүнгээр төсөвт ногдол ашиг хуваарилна.

16.5.Энэ хуулийн 16.1-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 16.4-т заасныг баримтлан ногдол ашгийн дунг тооцсоныг тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлд санал өгөх чиглэл гэж үзнэ.

16.6.Ногдол ашиг хуваарилах асуудлаар энэ хуулийн 16.5-д заасан чиглэлийг баримтлаагүй, эсхүл ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газар, эсхүл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

16.7.Энэ хуулийн 16.6-д заасны дагуу Засгийн газар, эсхүл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг оролцуулж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

17 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч

17.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигч нь Засгийн газар байна.

17.2.Төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг Засгийн газрын шийдвэрээр тогтооно.

17.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь нэг этгээд байна.

17.4.Орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигч нь аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна.

17.5.Орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга байна.

18 дугаар зүйл.Төрийн өмчит компанийн талаарх Засгийн газрын бүрэн эрх

18.1.Засгийн газар төрийн өмчит компанийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг тогтоох;

18.1.2.энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

18.1.3.энэ хуульд заасан үндэслэлээр төрийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах;

18.1.4.төрийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох;

18.1.5.төрийн өмчийн компанийн үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах;

18.1.6.энэ хуулийн 13.2-т заасны дагуу хориг тавих;

18.1.7.хуульд заасан бусад.

19 дүгээр зүйл.Орон нутгийн өмчит компанийн талаарх аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

19.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчит компанийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, орон нутгийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах;

19.1.2.орон нутгийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох;

19.1.3.орон нутгийн өмчийн компанийн үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах;

19.1.4.хуульд заасан бусад.

20 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн бүрэн эрх

20.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаар төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хувьцааг худалдах, шилжүүлэх, төрийн эсхүл орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар Засгийн газар, эсхүл иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал хүргүүлэх;

20.1.2.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хуульд заасан журмын дагуу томилох, чөлөөлөх;

20.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх талаар санал гаргах;

20.1.4.төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, компанийд хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлөхийг шаардах, шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд уг асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал хүргүүлэх;

20.1.5.төрийн болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирал хууль болон дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх саналаа төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх;

20.1.6.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн бизнес төлөвлөгөө болон төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх;

20.1.7.хуульд заасан бусад.

21 дүгээр зүйл.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын чиг үүрэг

21.1.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулан

зохицуулах, энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг ханггуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

21.2.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.2.1.төрийн өмчит компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлаар дүгнэлт гаргаж, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;

21.2.2.төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх;

21.2.3.төрийн өмчийн компанийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх;

21.2.4.төрийн өмчийн компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг ханггуулах талаар шаардлага, зөвлөмж өгөх, хуульд заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, хариуцлага хүлээлгэх саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;

21.2.5.төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт тайлагнах;

21.2.6.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

21.2.7.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацаа, гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

21.2.8.төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг жил бүр хүлээн авч хянах;

21.2.9.төрийн өмчийн компанийн төрийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих;

21.2.10.төрийн өмчит компаниас төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг энэ хуульд заасан зарчмыг баримталж, тухайн жилийн төсвийн тухай хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

21.2.11.хуульд заасан бусад.

21.3.Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар нь орон нутгийн өмчит компанийн талаар энэ хуулийн 21.2-т заасан чиг үүргийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлнэ.

**ТАВДУГААР БҮЛЭГ
КОМПАНИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

22 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурал

22.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Компанийн тухай хуульд зааснаар зохицуулна.

22.2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг энэ хуулийн 17.2, 17.5-д заасан этгээд хэрэгжүүлнэ.

22.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдлийн хараат, охин компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг тухайн компанийн дүрэмд заасан этгээд хэрэгжүүлнэ.

23 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

23.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1.компанийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

23.1.2.компанийн гүйцэтгэлийн үнэлгээний санхүүгийн ба санхүүгийн бус шалгуур үзүүлэлтийг тогтоож, хэрэгжилтийг үнэлэх;

23.1.3.компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гадна хүний эрх, авлига, тэгш боломж, хөдөлмөр, мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээлэл хамгаалалт, өрсөлдөөн, байгаль орчин, татвар, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийн удирдлага болон хянан нийцүүлэлтийн нэгдсэн бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

23.1.4.компанийн гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг үнэлж, хянах;

23.1.5.компанийн удирдах ажилтны залгамж халааны бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

23.2.Энэ хуулийн 24.4-т заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 81.2-т заасан хороодтой байх бөгөөд хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байна.

23.3.Энэ хуулийн 24.7-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ аудитын хороотой байна.

24 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага

24.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

24.1.1.Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчлөх эрхийн, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй;

24.1.2.компанийн үйл ажиллагаа хамаарах салбарын болон санхүүгийн мэдлэг, туршлагатай, тухайн салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, хууль, санхүү, аудит, нягтлан бодох бүртгэл, бизнесийн удирдлага, эдийн засаг, эсхүл тухайн компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн;

24.1.3.сүүлийн хоёр жил улс төрийн намын удирдах албан тушаал хashiж байгаагүй, эсхүл улс төрийн албан тушаал хашдаггүй байх;

24.1.4.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд телбөрийн чадваргүй болж дампуурсан нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

24.1.5.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгосон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

24.1.6.доор дурдсан ашиг сонирхлын зөрчилтэй этгээд биш байх:

24.1.6.а.тухайн компанийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн тав болон түүнээс дээш хувийг өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй дангаараа болон хамтран эзэмшигч;

24.1.6.б.тухайн компанийтай адил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн эрх бүхий албан тушаалтан;

24.1.6.в.төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн ажил, үйлчилгээг хүлээн авах, бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, эсхүл тус компанийд ажил, үйлчилгээ үзүүлэх, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдах үйл ажиллагаа явуулах байдлаар компанийтай их хэмжээний хэлцэл байгуулсан аливаа этгээдийн эрх бүхий албан тушаалтан;

24.1.6.г.төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчтэй хамаарал бүхий, эсхүл нэгдмэл сонирхолтой.

24.1.7.Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг хангасан байх;

24.1.8.компанийн дүрэмд заасан бусад шаардлага.

24.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажилладаг компани нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани бол энэ хуулийн 24.1.6.б-д заасан нөхцөл хамаарахгүй.

24.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирал тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болохгүй.

24.4.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь есөн гишүүнтэй байна.

24.5.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгээс дээшгүй нь төрийн захиргааны албан хаагч байна.

24.6.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна.

24.7.Энэ хуулийн 37.7-д заасан шалгуураас доош үзүүлэлттэй, эсхүл нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарын төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл таваас илүүгүй сондгой тооны гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр хүртэлх гишүүн нь төрийн захиргааны албан хаагч, хоёроос доошгүй нь мэргэжлийн хараат бус гишүүн байж болно.

24.8.Энэ хуулийн 24.5, 24.6, 24.7-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс томилсон этгээд байна.

24.9.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангагүй этгээдийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилох, томилуулахаар нэр дэвшүүлэх, эсхүл дэмжиж санал өгөхийг хориглоно.

25 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт

25.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилно.

25.2.Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах шийдвэр гарсан, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сул орон тоо гарснаас хойш ажлын таван өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах захиалгыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

25.3.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг 30 хоногийн дотор зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид санал болгоно.

25.4.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус байгууллага, мэргэжлийн нэгдсэн холбооны төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулна.

25.5.Энэ хуулийн 25.3-т заасны дагуу санал болгосон нэр дэвшигчээс бусад нэр дэвшигчийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэр дэвшигчийн нөөцийн сан үүсгэн бүртгэнэ.

25.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн нөөцөд байх хугацаа 2 жил байна.

25.7. Энэ хуулийн 25.5-д заасан нөөцийн санд бүртгэгдсэн нэр дэвшигчээс төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний шаардлага хангаж байгаа хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд санал болгож болно.

25.8. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон нэр дэвшигчийн нөөц сангийн журмыг Засгийн газар батална.

25.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нэр дэвшигч тус бүрийн үнэлгээний оноо, нэр дэвшигчийн нөөцийн сангийн мэдээллийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудаст нээлттэй, ил тод байршуулна.

26 дугаар зүйл. Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт

26.1. Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар зохион байгуулна.

26.2. Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулах үйл ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасныг баримтална.

27 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээс шаардах мэдээлэл

27.1. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 25.2-т заасан захиалга ирүүлснээс хойш ажлын таван өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг өөрийн цахим хуудас, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

27.2. Энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтыг нийтэд зарласнаас хойш 14 хоногийн дотор дараах мэдээллийг нотолсон баримт бичгийг бүрдүүлэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт нэр дэвших тухай хүсэлтээ хүргүүлсэн байна:

27.2.1. Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, боловсролын байдлын талаарх баримт бичиг, холбоо барих мэдээлэл;

27.2.2.сүүлийн таван жилийн ажил эрхлэлт, хувийн эрх зүйн хуулийн этгээдэд эрх бүхий албан тушаал эрхэлж байсан мэдээллийг агуулсан ажлын туршлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

27.2.3.нэр дэвшигч өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь дангаараа болон хамтран тав, түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тухайн компанийн сүүлийн таван жилд үйл ажиллагаа эрхэлсэн салбарын жагсаалт, санхүүгийн үзүүлэлт зэрэг мэдээлэл.

27.3.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн шүүхээр гэм буруутай нь тогтоогдож байсан эсэх талаарх лавлагааг эрх бүхий байгууллагаас гаргуулан авна.

28 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох

28.1.Энэ хуулийн 25.3, 25.6-д заасны дагуу санал болгосон нэр дэвшигчийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 24.1-д заасан шаардлага хангасан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилно.

28.2.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал болгоно.

28.3.Энэ хуулийн 28.1, 28.2-т заасны дагуу томилогдсон төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх томилогдсон өдрөөс эхэлж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөнөөр дуусгавар болно.

28.4.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг энэ хуулийн 24.1-д заасан шаардлага хангаагүй үндэслэлээр томилохоос татгалзсан тохиолдолд ажлын таван өдрийн дотор төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар дараагийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг санал болгоно.

28.5.Энэ хуулийн 28.4-т заасан хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн томилогдоогүйн улмаас төрийн болон орон нутгийн өмчит компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, компани болон хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна.

28.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилох, эсхүл томилуулахаар санал болгоходо жендерийн эрх тэгш байдал буюу төлөөлөн удирдах зөвлөл дэх хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалзана.

28.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жилээс хэтрэхгүй байх бөгөөд нэг удаа улируулан томилж болно. Улируулан томилох тохиолдолд энэ

хуулийн 42.1-д заасны дагуу тухайн гишүүний ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хангалттай гэж үнэлэгдсэн байна.

28.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг албан тушаалаар томилохгүй.

29 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэг хариуцлага

29.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй:

29.1.1.эрх, үүргээ компанийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх;

29.1.2.хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд заавал оролцож, шийдвэр гаргахад саналаа өгөх;

29.1.3.шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээлэлтэй танилцаж, үндэслэл бүхий шийдвэр гаргах;

29.1.4.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглах, компанийн хөрөнгө, компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууцыг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

29.1.5.албаны чиг үүрэг нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний чиг үүргээс тусгаарлагдсан байх;

29.1.6.өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд дангаараа, эсхүл хамтран тухайн компани, эсхүл ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг бусад компанийн хувьцаа эзэмшигч болсон даруйд мэдэгдэх;

29.1.7.компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үл хамаарах их хэмжээний хэлцэл хийх төлөвлөгөөг тухай бүр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид мэдэгдэх;

29.1.8.энэ хуулийн 29.6-д заасан асуудлаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс өгсөн удирдамж, чиглэлийг биелүүлэх;

29.1.9.Банкны тухай хуулийн 31.4.3, 31.4.4, 31.4.5-д заасан болон компанийн дүрэмд заасан бусад.

29.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр бүх гишүүдийн дийлэнх олонхын саналаар хүчин төгөлдөр болно.

29.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурал болсноос хойш нэг сараас доошгүй хугацааны дотор хурлаар хэлэлцсэн асуудал, хурлаас гарсан шийдвэрийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

29.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хууль, Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд төлөөлөн удирдах

зөвлөлийн дарга энэ тухай нотлох баримтын хамт бичгээр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид мэдэгдэл хүргүүлж, холбогдох арга хэмжээ авна.

29.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний буруутай үйл ажиллагааны улмаас компанийд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг компанийн дүрэмд тусгасан байна.

29.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч доор дурдсанаас бусад тохиолдолд оролцож, удирдамж, чиглэл өгөхийг хориглоно:

29.6.1.ногдол ашгийг нэмэгдүүлэх;

29.6.2.бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;

29.6.3.компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, эрсдэлийг зохистой удирдах.

30 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшуулал

30.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн цалин, урамшуулал авч болно.

30.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах журмаар тогтооно:

30.2.1.нийтийн дэд бүтцийн болон нийтийн үйлчилгээний салбарын төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал болон төрийн албан хаагчийн цалингийн жишигийг харгалзан;

30.2.2.энэ хуулийн 30.2.1-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал болон тухайн компанийн хөрөнгийн хэмжээ, ашигт ажиллагаа, зах зээл дэх хувийн хэвшлийн цалингийн жишигийг харгалзан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын хорооны саналаар.

30.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ адил байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь аудитын хороо болон төлөөлөн удирдах зөвлөлийн бусад хороонд ажилласан бол нэмэгдэл урамшуулал авч болно.

30.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хуульд заасан цалин, урамшууллаас бусад тусгайлсан хангамж эдлэхгүй.

30.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд нөхөн төлбөр, олговор зэрэг аливаа хэлбэрийн тэтгэмж олгохыг хориглоно.

30.6.Энэ хуулийн 29.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол урамшуулал тогтоох эрх бүхий этгээдээс төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд урамшуулал олгохыг

зогсоох, эсхүл үүргээ биелүүлээгүй, эсхүл хуралдаанд оролцоогүй тухайн хугацаанд хамаарах хувь хэмжээгээр урамшууллын хэмжээг бууруулна.

30.7.Энэ хуулийн 30.6-д заасны дагуу урамшуулал олгохыг зогсоох, эсхүл бууруулах арга хэмжээ нь урамшуулал тогтоох эрх бүхий этгээдээс компанийн гүйцэтгэх захиралд хандан энэ тухай бичгээр гаргасан мэдэгдэлд үндэслэнэ.

30.8.Төрийн болон орон нутгийн өмчийт компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж, урамшуулал олгох аргачлалыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

30.9.Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллын талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байна.

31 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх

31.1.Төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх, эсхүл чөлөөлөх санал гаргана:

31.1.1.энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангахгүй болох нь нотлогдсон;

31.1.2.хууль, компанийн дүрэмд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, үүргээ ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэл гаргасан, эсхүл ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр удаа дараа хангальгүй үнэлэгдсэн;

31.1.3.гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

31.1.4.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашигласан, компанийн хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашигласан;

31.1.5.эрх бүхий байгууллагаас тухайн албан тушаалыг эрхлэхтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрхийг хүчингүй болгосон;

31.1.6.үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл байдал бий болсон, өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.

31.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн энэ хуулийн 31.1.1, 31.1.2, 31.1.3, 31.1.4-д заасан үйлдлийн улмаас компанийд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

32 дугаар зүйл.Гүйцэтгэх захирал, түүнд нэр дэвшигчид тавих шаардлага

32.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захиралд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:

32.1.1.энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангасан байх;

32.1.2.бизнесийн удирдлага, хууль, санхүү, аudit эсхүл компанийн үйл ажиллагаанд хамаарах салбарын мэдлэг, туршлагатай байх;

32.1.3.өөрийн буруутай үйл ажиллагаанаас төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, захирал, дэд захирлын албан тушаалаас чөлөөлөгдөөгүй байх;

32.1.4.бусад компанийд гүйцэтгэх удирдлагын албан тушаал давхар эрхэлдэггүй байх;

32.1.5.компанийн дүрэмд заасан бусад шаардлага.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигч нь гүйцэтгэх захирлын хэрэгжүүлэх зорилтот түвшний мэдэгдэл боловсруулж, сонгон шалгаруулах комисст хүргүүлнэ.

32.3.Энэ хуулийн 32.2-т заасан зорилтот түвшний мэдэгдэл дараах агуулгатай байна:

32.3.1.нээлттэй өгөгдөл, мэдээлэлд үндэслэсэн компанийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, бүрэн эрхийн хугацаанд хүргэхээр зорьж байгаа үр дүн, түүнтэй уялдсан урамшууллын хувилбар;

32.3.2.компанийн эрхэм зорилго, зорилт, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн хүлээлтийг хэрхэн төсөөлж байгаа болон түүнийг биелүүлэхэд хангалттай ажлын туршлага, ур чадвартай болохоо бататгасан тайлбар, нотолгоо;

32.3.3.компанийн үндсэн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн зорилтот түвшинд хүргэн удирдах, өөрчлөлтийг хэрэгжүүлэх арга хэмжээ, нөөц бололцоо, учирч болзошгүй эрсдэл, хязгаарлалтын талаар.

32.4.Гүйцэтгэх захирлаар томилогдсон тохиолдолд энэ хуулийн 32.2-т заасан зорилтот түвшний мэдэгдэл нь компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө боловсруулах суурь баримт болно.

33 дугаар зүйл.Гүйцэтгэх захирлыг томилох

33.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх захирлыг томилж, нэг жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллуулна. Тухайн жилийн компанийн гүйцэтгэлийн үнэлгээ болон гүйцэтгэх захирлын ажлын үнэлгээг үндэслэн гэрээг сунгана.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан гэрээнд гүйцэтгэх захирлын ажлын зорилт, санхүүгийн болон үйл ажиллагааны хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, цалин хөлс, урамшууллын хэмжээ, түүнийг олгох журам, эрх, үүрэг, хүлээлгэх хариуцлага, түүний эрх хэмжээг түдгэлзүүлэх, чөлөөлөх үндэслэл, журам болон үйл ажиллагааны талаар тайлагнах хуваарийг тусгана.

33.3.Энэ хуулийн 33.1-д заасан гэрээг байгуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 72.1-д заасны дагуу үл өрсөлдөх үүрэг хүлээлгэх гэрээний нэмэлт нөхцөлийг тусган хэрэгжүүлж болно.

34 дүгээр зүйл.Гүйцэтгэх захирлын үүрэг

34.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирал дараах үүрэгтэй:

34.1.1.компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийг урт хугацаанд нэмэгдүүлэх, албаны чиг үүрэг, бүрэн эрхийг хууль, компанийн дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлэх;

34.1.2.компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг шуурхай авах;

34.1.3.төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хүрээнд компанийн үйл ажиллагааг эрхлэн явуулах;

34.1.4.компанийн талаарх мэдээ, мэдээлэл, байгууллагын болон бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй, эсхүл бусдад задруулахгүй байх;

34.1.5.аудитын хороо, дотоод аудитын нэгж, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

34.1.6.компанийн санхүүгийн үзүүлэлт, үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад шаардлагатай бүх арга хэмжээг авах;

34.1.7.санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан журмыг баримтлан бэлтгэж, ил тод тайлагнах;

34.1.8.хууль болон компанийн дүрэмд заасан үйл ажиллагаанд үл хамаарах зардлыг санхүүжүүлэхгүй байх;

34.1.9.энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан мэдээллийг компанийн цахим хуудсанд тухай бүр ил тод, нээлттэй байршуулах, эрх бүхий этгээдэд тайлагнах.

34.2.Гүйцэтгэх захирал хууль, компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн бол төлөөлөн удирдах зөвлөлийн дарга энэ тухай мэдэгдлийг нотлох баримтын хамт хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид бичгээр хүргүүлж, холбогдох арга хэмжээг авна.

35 дугаар зүйл.Гүйцэтгэх захирлын цалин хөлс, урамшуулал

35.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлын цалин хөлс, урамшууллын хэмжээг энэ хуулийн 33.1-д заасан гэрээгээр тохиролцно.

35.2.Компанийн хөрөнгийн өгөөж, ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурь өсөн нэмэгдсэн бол гүйцэтгэх захиралд урамшуулал олгохоор гэрээнд зааж болно.

35.3.Гүйцэтгэх захирал гэрээнд зааснаас бусад чиг үүргийг хэрэгжүүлсэн боловч тухайн чиг үүрэгт тохирсон цалин хөлс, урамшуулал олгохоор гэрээнд заагаагүй бол аливаа цалин хөлс, урамшуулал олгохгүй.

35.4.Гүйцэтгэх захирлын цалин хөлс, урамшууллын талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байна.

36 дугаар зүйл.Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх

36.1.Дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлыг ажлаас нь чөлөөлж, гэрээг хугацаанаас нь өмнө цуцална:

36.1.1.үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд компанийг 3 жил дараалан алдагдал хүлээнлгэсэн, эсхүл гэрээнд заасан санхүүгийн зорилтот үзүүлэлтийг 3 жил дараалан хангаж чадахгүй болсон;

36.1.2.компанийн гүйцэтгэлийн үнэлгээ 3 жил дараалан хангалтгүй гэж үнэлэгдсэн;

36.1.3.компани төлбөрийн чадваргүй болсон талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдээгүй, дампуурлын өргөдөл гаргаагүй;

36.1.4.хууль болон компанийн дүрэм, гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, ноцтой зөрчсөн;

36.1.5.компанийн санхүүгийн байдлын талаар худал мэдээлэл өгсөн;

36.1.6.төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан компанийн төсвийг хүндэтгэн үзүүлэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн;

36.1.7.гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

36.1.8.энэ хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй болох нь нотлогдсон;

36.1.9.компанийн шинэ бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратеги бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, туршлага, чадвар хангалтгүй байх;

36.1.10.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашигласан, компанийн хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашигласан;

36.1.11.эрх бүхий байгууллагаас тухайн гүйцэтгэх захирлын ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрхийг хүчингүй болгосон;

36.1.12.үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл байдал бий болсон, өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

36.1.13.санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 жил дараалан хангалтгүй дүгнэлт авсан;

36.1.14.компанийн олж авсан хөрөнгийг компанийн өмчид бүртгээгүй, бүртгэлгүй ашигласан.

36.2.Гүйцэтгэх захирал нь энэ хуулийн 36.1-д заасан үйлдлийн улмаас компанийд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

36.3.Гүйцэтгэх захирлын буруутай үйл ажиллагааны улмаас компанийд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг тухайн компанийн дүрэмд тусгасан байна.

36.4.Гүйцэтгэх захирлын ажлаас чөлөөлөгдсөн этгээд нь ажлаа бүрэн хүлээлцэх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

36.5.Энэ хуулийн 36.1.1-д заасан тохиолдол хувийн хэвшил гүйцэтгэх боломжгүй, нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээг хангах зайлшгүй шаардлагатай, эсхүл зүй ёсны монополь үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон орон нутгийн өмчийн компанийд хамаарахгүй байж болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

37 дугаар зүйл.Компанийн аудитын тогтолцоо

37.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн аудитын тогтолцоо нь төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, дотоод аудитын нэгж, дотоод аудитор, хөндлөнгийн аудитаас бүрдэнэ.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан аудитын хорооны дарга нь санхүү, аудит, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.

37.3.Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална. Журамд аудитын хороо, дотоод аудитын нэгж, гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийн хооронд мэдээлэл солилцох арга хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг тусгасан байна.

37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа нягтлан шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, санхүүгийн баримтыг хянуулан хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор хөндлөнгийн аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр аудит хийлгүүлнэ.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан хөндлөнгийн аудит хийх хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулна.

37.6.Төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх тохиолдолд тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх компанийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.

37.7.Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр дараах гурван үзүүлэлтийн хоёроос доошгүйг хангаж байвал төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дотоод аудитын нэгжтэй байна:

37.7.1.нийт ашгийн хэмжээ нь 200 сая төгрөгөөс дээш байх;

37.7.2.борлуулалтын орлогын хэмжээ хоёр тэрбум төгрөгөөс дээш байх;

37.7.3.нийт ажилтны тоо 75-аас дээш байх.

37.8.Энэ хуулийн 37.7-д заасан нөхцөлөөс доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын нэгжтэй байх нь эдийн засгийн хувьд оновчтой гэж дүгнэсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн зөвшөөрлөөр энэ тухай шийдвэр гаргаж болно.

37.9.Дотоод аудитын нэгж нь компанийн үйл ажиллагааны цар хүрээ, эдийн засгийн үр ашгаас хамааран төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тооны бүтцэд хамаарах тодорхой тооны аудитороос бурдэнэ.

37.10.Дотоод аудитын нэгж нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан үйл ажиллагааны журмын дагуу компанийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус аудит хийж, дүгнэлт гаргах ба дүгнэлтээ гүйцэтгэх удирдлагад танилцуулж, төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх аудитын хороонд тайлагнана.

37.11.Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, аудиторын эрх, үүрэг, аудитыг зохион байгуулах хэлбэр, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, дүгнэлт, зөвлөмж гаргахтай холбогдсон харилцааг хуульд нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо болон дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

37.12.Энэ хуулийн 37.7-д зааснаас доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компани нь дотоод аудитын нэгжгүй байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн харьяанд дотоод аудитор ажиллана.

37.13.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь дотоод аудитын үйл ажиллагааг хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

38 дугаар зүйл.Компанийн дотоод аудитын чиг үүрэг

38.1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод аудитын нэгж, дотоод аудитор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

38.1.1.компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартад нийцэж байгаа эсэх, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээлэл үнэн зөв эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

38.1.2.компанийн эрхэм зорилго, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, засаглалын үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах замаар компанийг зорилтоо биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

38.1.3.компанийн бүх нэгжийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус шалгалт хийж, дүгнэлт гаргах ба дүгнэлтээ төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захиралд танилцуулах;

38.1.4.компанийн засаглал болон үйл ажиллагаа холбогдох хууль, дүрэм, журамд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

38.1.5.компанийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал, цаг хугацаандаа, үнэн зөв тайлагнаж байгаа эсэхэд хяналт тавих;

38.1.6.төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

38.1.7.компанийн төсөв, хөрөнгө, нөөцийн ашиглалт, зарцуулалт хэмнэлттэй, үр ашигтай, үр өгөөжтэй байгаа эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;

38.1.8.компанийн дүрэм болон компанийн дотоод аудитын дүрэмд заасан бусад.

ДОЛООДУГААР БҮЛЭГ
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН КОМПАНИ,
ТҮҮНИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ

39 дүгээр зүйл.Компанийн бизнес төлөвлөгөө, түүний гүйцэтгэл

39.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор энэ хуулийн 33.1-д заасан хугацаанд хэрэгжүүлэх компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлнэ.

39.2.Гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлийн хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

39.3.Гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

39.4.Энэ хуулийн 39.1-д заасан компанийн бизнес төлөвлөгөөнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах болон компанийн тогтвортой хөгжлийн бодлогын арга хэмжээг тусган хэрэгжүүлнэ.

40 дүгээр зүйл.Компанийн гүйцэтгэлийн үнэлгээ

40.1.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гүйцэтгэх захирлын гэрээний

хэрэгжилтийн тайланд үндэслэн жил бүр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлнэ.

40.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 40.1-д заасны дагуу компанийн гүйцэтгэлийн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг ирүүлэхийг компанийн удирдлагаас шаардах эрхтэй.

40.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, аргачлал, үнэлгээний журмыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар батална.

40.4.Энэ хуулийн 40.3-т заасан үнэлгээний шалгуурт дараах асуудлыг хамааруулна:

40.4.1.компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин;

40.4.2.компанийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн зохистой менежмент;

40.4.3.санхүүгийн менежмент, төсвийн хэмнэлт, хэтрэлт;

40.4.4.гүйцэтгэлийн үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоо;

40.4.5.борлуулалтын орлого, ашгийн хэмжээ, төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдал, хөрөнгийн ашиглалт, өөрийн хөрөнгийн өгөөж, ашигт ажиллагаа, мөнгөн урсгалын зорилтот түвшин;

40.4.6.мэдээллийн ил тод байдал.

40.5.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж, үнэлгээний тайланг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

40.6.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 40.5-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийн үнэлгээний тайланг нэгтгэж, Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

40.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдсэн бол хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, эсхүл төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар гүйцэтгэх захирлыг чөлөөлүүлэхээр төлөөлөн удирдах зөвлөлд санал гаргах эрхтэй.

40.8.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар нь аудитор болон компанийн бусад эрх бүхий албан тушаалтан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол албан тушаалаас чөлөөлүүлэх санал гаргах эрхтэй.

40.9.Энэ хуулийн 36.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн компани үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд 3 жил дараалан санхүүгийн зорилтот үр дүнд хүрээгүй бол

өөрчлөн байгуулах, татан буулгах, эсхүл хувьцааг шилжүүлэх, худалдах арга хэмжээг авна.

41 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл

41.1. Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн бизнес төлөвлөгөө батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор бизнесийн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

41.2. Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн компанийн хувьд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн компанийн хувьд орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт хүргүүлнэ.

41.3. Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөнд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн тухайн жилд хэрэгжүүлэх ажлыг тусгасан байна.

41.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

42 дугаар зүйл. Ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ

42.1. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.

42.2. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд шаардлагатай бусад мэдээллийг ирүүлэхийг шаардах эрхтэй.

42.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлалыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

43 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн компанийг өөрчлөн байгуулах

43.1. Төрийн өмчийн компанийг Засгийн газрын шийдвэрээр, төрийн өмчийн оролцоотой компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх хэлбэрээр өөрчлөн байгуулж болно.

43.2. Орон нутгийн өмчийн компанийг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр, орон нутгийн өмчийн оролцоотой компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу

нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх хэлбэрээр өөрчлөн байгуулж болно.

43.3.Энэ хуулийн 43.1, 43.2-т заасан байгууллагын шийдвэргүйгээр төрийн болон орон нутгийн өмчийн компанийг өөрчлөн байгуулахыг хориглоно.

43.4.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх хэлбэрээр өөрчлөн байгуулахад энэ хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

44 дүгээр зүйл.Нэмэлт хувьцаа гаргаж, үнэт цаасны зах зээлд нийтэд санал болгох

44.1.Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана.

44.2.Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны зах зээлд нийтэд санал болгох үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

44.3.Дараах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчит компани нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны зах зээлд нийтэд санал болгоно:

44.3.1.компани үйлдвэрлэлээ өргөжүүлэх, техник технологийн шинэчлэл хийх, компанийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт татах;

44.3.2.компанийн засаглалыг сайжруулах;

44.3.3.зах зээл дэх төрийн оролцоог багасгах;

44.3.4.компанийн дүрэмд заасан бусад.

44.4.Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны зах зээлд нийтэд санал болгоход шаардлагатай зардлыг тухайн компанийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

45 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийг татан буулгах

45.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийг татан буулгахад энэ хууль, Иргэний хууль, Компанийн тухай хуульд заасан үндэслэл, журмыг баримтална.

45.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийг татан буулгах ажлыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ.

46 дугаар зүйл.Татан буугдах үеийн эд хөрөнгийн зохицуулалт

46.1.Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг Иргэний хууль, Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлан хангана.

46.2.Төрийн өмчийн компанийн тооллого хийж дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн шилжүүлэх, эсхүл дуудлагаар худалдах ажлыг

Засгийн газрын шийдвэрийг үндэслэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН,
МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

47 дугаар зүйл. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

47.1. Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль⁴ болон Компанийн тухай хуульд⁵ заасан журмын дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

47.2. Санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан бүрэлдэхүүнтэй байна.

47.3. Энэ хуулийн 47.1-д заасан үйл ажиллагааны тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

47.3.1. санхүүгийн болон санхүүгийн бус зорилтын хэрэгжилт, батлагдсан ногдол ашгийн бодлого, үйл ажиллагааны зорилго, зорилтын нийцэл;

47.3.2. бизнесийн стратегийн бодлого, зах зээлийн дүн шинжилгээ;

47.3.3. гадаад болон дотоод зах зээлийн эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

47.3.4. бизнесийн хэтийн төлөвийг ойлгоход чухал ач холбогдолтой санхүүгийн бус эрсдэл, тодорхой бус хүчин зүйлсийн тайлбар;

47.3.5. санхүүгийн жилийн хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдан авалт, онцлох үйл явдал;

47.3.6. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн, цалин хөлс, урамшууллын мэдээлэл;

47.3.7. компанийн тогтвортой хөгжил болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын тайлан, санхүүжилт, хөрөнгө оруулалтын дүн;

47.3.8. хүний нөөц, ажиллах хүч, байгууллагын бүтэц.

47.4. Энэ хуулийн 47.3-т заасан үйл ажиллагааны тайландаа төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг хэрхэн чиглүүлсэн, удирдан зохицуулсан, хянаж нийцуулсэн талаарх тайлан, гүйцэтгэх захирлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хүлээн авсан цалин хөлс, урамшууллын хэмжээний талаарх мэдээллийг хавсарган ирүүлнэ.

⁴ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Компанийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

47.5. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийт төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдалд хяналт тавина.

47.6. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт төр болон орон нутгийн хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг жил бүр хүргүүлнэ. Илтгэл бэлтгэх загварыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

47.7. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ зүйлд заасан тайлан, илтгэлийг нэгтгэн жилд нэг удаа төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн эзэмшиж байгаа хувьцааг шилжүүлэх үр дүнтэй хувилбарын талаарх нэгдсэн тайлан бэлтгэж, саналын хамт Засгийн газарт танилцуулна.

47.8. Энэ хуулийн 47.7-д заасан нэгдсэн тайлан, саналыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд олон нийтэд ил тод, нээлттэй байршуулна.

48 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн нөөц сан

48.1. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн компани жил бүр татварын дараах цэвэр ашгийн 10 хувь хүртэл хэмжээний хөрөнгийг ногдол ашиг хуваарилахаас өмнө компанийн нөөц сан байгуулан төвлөрүүлж болно.

48.2. Энэ хуулийн 48.1-д заасан нөөц сан байгуулахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

48.3. Энэ хуулийн 48.1-д заасан нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

48.3.1. компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, технологийг шинэчлэх;

48.3.2. компанийн алдагдлыг нөхөх;

48.3.3. компанийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөнд хамаарахгүй учирч болох эрсдэлийг бууруулах;

48.3.4. компанийн дүрэмд заасан бусад.

48.4. Энэ хуулийн 48.1-д заасан компанийн нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгийн нийт хэмжээ нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 50 хувиас хэтэрсэн тохиолдолд компани нөөц санд хөрөнгө төвлөрүүлэхгүй байж болно.

49 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдал

49.1. Төрийн болон орон нутгийн өмчит компани Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн

тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ:

49.1.1.компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;

49.1.2.компанийн зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ, биет, биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;

49.1.3.компанийн сүүлийн таван жилд хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;

49.1.4.компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;

49.1.5.компанийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

49.1.6.компанийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гэрээ, түүний гүйцэтгэлийг дүгнэсэн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;

49.1.7.компанийн эсрэг, эсхүл компанийтай холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;

49.1.8.компанийн дүрэм, компанийн үйл ажиллагааны болон засаглалын дотоод журам;

49.1.9.тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын мэдээлэл, хэрэгжилтийн явц болон хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээний талаарх мэдээлэл;

49.1.10.бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын болон нийлүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал, хэрэгжилтийн явц;

49.1.11.Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

49.1.12.байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;

49.1.13.тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;

49.1.14.төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан дэмжлэг, хандив, тусламж.

49.2.Энэ хуулийн 49.1-д заасан мэдээлэлд хяналт шалгалт хийх зорилгоор холбогдох баримт бичгийг хуулбарлахыг зөвшөөрнө.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД

50 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

50.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль⁶, эсхүл Зөрчлийн тухай хуульд⁷ заасан хариуцлага хүлээлгэнэ.

51 дүгээр зүйл.Дагаж мөрдөх журмын зохицуулалт

51.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд компани, эсхүл нийтийн үйлчилгээний байгууллага хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах арга хэмжээ авна.

51.2.Энэ хуулийн 51.1-д заасны дагуу өөрчлөн байгуулагдах компанийн дүрмийг Засгийн газрын шийдвэрээр тогтоосон тухайн компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч батална.

51.3.Энэ хуулийн 51.1-д заасан үйлдвэрийн газарт эмнэлэг, сургууль, цэцэрлэг хамаarahгүй.

52 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

52.1.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

⁶ Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2016 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН, НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Аж ахуй, нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчит компани” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.7 дахь заалтын “аж ахуйн нэгжүүдээс” гэснийг “компаниас” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтын “хуулийн этгээд” гэснийг “компани” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.17 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.4.3 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.1.4 дэх заалтын “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.5.4 дэх заалтын “хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.6.4.төрийн өмчит хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн архивын баримт;”

2 дугаар зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11 дэх хэсгийн “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “албан газар, төрийн өмчийн компани” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Дампуурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын "үйлдвэрийн газар" гэснийг "компани" гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн "үйлдвэрийн газрын" гэснийг "компанийн" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчit компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Зөрчлийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн 50.2-т "Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж заасантай уялдуулан тус хуульд заасны дагуу тайлан тэнцэл, мэдээ, мэдээллийг нийтэд болон эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчид танилцуулах, тайлагнах, мэдээлэх үүргээ биелүүлээгүй, түүнчлэн хууль зөрчиж төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирлыг томилсон, томилуулахаар санал болгосон, цалин, урамшуулал олгосон зэрэг үйлдлийг зөрчилд хамааруулж, тorgох шийтгэл оногдуулах зохицуулалтыг бий болгохоор Зөрчлийн тухай хууль л нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн Аравдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 10.31 дүгээр зүйл нэмсүгэй:

“10.31 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль зөрчих

1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуульд заасан тайлан тэнцэл, мэдээ, мэдээллийг:

- 1.1. нийтэд, эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчид танилцуулах;
- 1.2. тайлагнах;

1.3. мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуульд заасныг зөрчиж:

2.1. төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилсон, томилуулахаар нэр дэвшүүлж, санал болгосон, гүйцэтгэх захирлыг томилсон;

2.2. төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг олгосон, гүйцэтгэлийн үнэлгээ хийгээгүй;

2.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирлаар ажиллаж болохгүй нөхцөл байдал бий болсон талаар мэдээлээгүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуульд заасныг зөрчиж:

- 3.1. алтан хувьцаа гаргасан, хугацааг сунгасан, бусдад шилжүүлсэн;

3.2. алтан хувьцаатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын шийдвэрт тавьсан Засгийн газрын хоригийг биелүүлээгүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн "төрийн өмчит, эсхүл төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж" гэснийг "төрийн өмчит компани" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 18.5 дахь заалтын "этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн" гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн 50.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасантай уялдуулан тус хуульд заасны дагуу тайлан тэнцэл, мэдээ, мэдээллийг нийтэд болон эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчид танилцуулах, тайлагнах, мэдээлэх үүргээ биелүүлээгүй, түүнчлэн хууль зөрчиж төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирлыг томилсон, томилуулахаар санал болгосон, цалин, урамшуулал олгосон зэрэг үйлдлийг зөрчилд хамааруулж, тorgох шийтгэл оногдуулах зохицуулалтыг бий болгохоор Зөрчлийн тухай хууль л нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Үүнтэй уялдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг Засгийн газрын тохируулагч агентлаг статустай болгон, тус агентлагт улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллуулахаар тусгасан.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг шалган шийдвэрлэх асуудлыг харьяаллын дагуу төрийн өмчийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлэх талаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах зохицуулалтыг тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дараах агуулгатай 6.66 дахь заалт нэмсүгэй:

"6.66. Төрийн өмчийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.31 дүгээр зүйлд заасан зөрчил."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Инновацийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэснийг “төрийн өмчит компани” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтын “болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэснийг “компани” гэж, 27 дугаар зүйлийн 27.10.3 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газарт” гэснийг “төрийн өмчит компанид” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Компанийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалтай холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулехтай холбогдуулан Компанийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулах, тухайлсан хуульд зааснаас бусад нийтлэг харилцаанд тус хууль үйлчлэхээр тусгалаа. Түүнчлэн, Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчлах замаар байгуулагдсан компанийн үйл ажиллагааг энэ хуулиар, түүнийг үүсгэн байгуулах болон төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийд төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын талаарх зохицуулалтыг хүчингүй болгохоор тусгасан.

Мөн төрийн өмчийн оролцоотой компанийн хувьд Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу эзэмшигчдийн хурлын ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах асуудлыг тодорхой болгох, мөн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 5-9 байхаар тусгасантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 75.4 дэх хэсэгт холбогдох өөрчлөлт оруулах зохицуулалтыг тус тус боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

"61.11.Төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 61.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар шийдвэрлэнэ."

2 дугаар зүйл.Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг тухайлсан хуулиар, уг хуульд өөрөөр заагаагүй бол компанийн нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна."

3 дугаар зүйл.Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсгийн "компани болон төрийн өмчийн" гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4, 2.5, 2.6 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг, 36 дугаар зүйл, 79 дүгээр зүйлийн 79.2, 79.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалтын "төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын" гэснийг "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3.3 дахь заалтын “хуулийн этгээд” гэснийг “компани” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.18 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4.3 дахь заалт, 56 дугаар зүйлийн 56.1.4 дэх заалтын “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэснийг, 48 дугаар зүйлийн 48.5.4 дэх заалтын “хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж” гэснийг “төрийн өмчит компани” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Өрийн удирдлагын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн 15.1, 15.2-т төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн үнэт цаас гаргах, зээл авч болохоор заасантай холбогдуулан тухайн компанийн зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах, түүнийг бүртгэхээс бусад тохиолдолд тухайн компанийн өр төлбөрийн харилцаанд Өрийн удирдлагын тухай хууль үйлчлэхгүй байх зохицуулалтыг тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.4. Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компанийн зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах, түүнийг бүртгэхээс бусад тохиолдолд тухайн компанийн өр төлбөрийн харилцаанд энэ хууль хамаарахгүй".

2 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.6.2 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.2.11 дэх заалтын "өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн" гэснийг "өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компанийн" гэж, 33 дугаар зүйлийн 33.4.1 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.4.4 дэх заалтын "өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд" гэснийг "өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрсөлдөөний тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.4 дэх хэсгийг нэмсүгэй.

“5.4. Зах зээлийн төвлөрлийг тогтоох аргачлал, түүнтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монополийн эсрэг газрын саналыг үндэслэн Засгийн газар батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/34 дүгээр зүйлийн 34.25.2 дахь заалт:

"34.25.2. төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл."

2/34 дүгээр зүйлийн 34.27 дахь хэсэг:

"34.27. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани шаардлагатай мэдээллийг татварын албаны шаардсан даруйд гаргаж, хүргүүлнэ."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын ", төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой" гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн ", тэдгээрийн оролцоотой" гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулахтай холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулахтай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компанийтай холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулах талаар тус хуулийн үйлчлэх хүрээнд нэмэлт оруулж, давхардсан зохицуулалтыг хүчингүй болгоо тусгалаа.

Түүнчлэн, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхой болгох хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх Засгийн газрын тохируулагч агентлаг байхаар тусгаж, үүнтэй холбогдуулан төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь улсын өрөнхий байцаагчийн эрхтэй байх, улсын ахлах болон улсын байцаагчийн эрхийг олгох тухай зохицуулалтыг нэмж тусгав.

Түүнчлэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан төрийн өмчит үйлдвэрийн газрын статусыг тодорхой болгох, Иргэний хуульд нийцүүлэх зорилгоор аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт шилжүүлэх, улсын төсөвт үйлдвэрийн газрын нийтийн үйлчилгээний байгууллага болгон өөрчлөхтэй холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Энэ хүрээнд нийтийн үйлчилгээний байгууллагын удирдлага, түүнийг байгуулах үндэслэлийг "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах нийтийн үйлчилгээ болон төрийн болон орон нутгийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг хувийн хэвшил, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй, эсхүл үр ашиггүй нөхцөлд байгуулах"-аар төсөлд тусгаж, нийтийн үйлчилгээний байгууллагын санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгийг эрхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Энэ хуулиар зохицуулснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компанийтай холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

2/13 дугаар зүйлийн 5 дахь заалт:

5/төрийн болон орон нутгийн өмчит компани."

2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дараах зүйл, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1/9¹ дүгээр зүйл:

9¹ дүгээр зүйл. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэх бөгөөд Засгийн газрын тохируулагч агентлаг байна.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, төрийн захиргааны байгууллагын төлөөлөл бүхий орон тооны бус найман гишүүнтэй байна.

3. Засгийн газар нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, дарга, гишүүнийг томилж, чөлөөлнө.

4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааны шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна.

5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

6.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь улсын ерөнхий байцаагчийн эрхтэй байх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно. Улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах болон улсын байцаагчийн эрхийг олгоно.

7.Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана. Улсын байцаагчийн эрхийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга олгоно.

2/13 дугаар зүйлийн 2 дахь заалт:

“2/нийтийн үйлчилгээний байгууллага;”

3/15 дугаар зүйл:

15 дугаар зүйл.Нийтийн үйлчилгээний байгууллага, түүний эд хөрөнгийн эрх

1.Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах нийтийн үйлчилгээ болон төрийн болон орон нутгийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг хувийн хэвшил, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй, эсхүл үр ашиггүй нөхцөлд нийтийн үйлчилгээний байгууллагыг байгуулна.

2.Нийтийн үйлчилгээний байгууллага нь төсвийн хөрөнгөөр санхүүжих бөгөөд эд хөрөнгийн талаар энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй.

3.Хуульд өөрөөр заагаагүй бол нийтийн үйлчилгээний байгууллага байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах болон түүний дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох эрх хэмжээг дараах эрх бүхий этгээд хэрэгжүүлнэ:

1/төрийн өмчит нийтийн үйлчилгээний байгууллагыг Засгийн газар;

2/орон нутгийн өмчит нийтийн үйлчилгээний байгууллагыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал.

4.Засгийн газрын гишүүн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн өмчит нийтийн үйлчилгээний байгууллагын, аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутгийн өмчит нийтийн үйлчилгээний байгууллагын даргыг томилж, чөлөөлнө.

5.Дараах нийтийн үйлчилгээний байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах, дүрмийг батлах болон бүтэц, зохион байгуулалт, хяналттай холбоотой тухайлсан хуулиар зохицуулна:

1/Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг болон Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын харьяанд ажиллах нийтийн үйлчилгээний байгууллага;

2/боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх нийтийн үйлчилгээний байгууллага;

3/хуульд тусгайлан заасан бусад.

6. Нийтийн үйлчилгээний байгууллагын дарга нь Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлага болон холбогдох хууль, дүрэмд заасан тусгай шаардлагыг хангасан байна.

7. Нийтийн үйлчилгээний байгууллага нь хуульд заасан чиг үүргийн дагуу гаргасан өмчийн тайлан мэдээ, бүртгэл, тооллогын дүнгээс гадна дараах мэдээллийг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулах үүрэгтэй:

1/байгууллагын дүрэм, удирдлагын талаарх мэдээлэл;

2/байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн тайлан;

3/их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

4/тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;

5/төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан хөрөнгө, бусдад өгсөн дэмжлэг, хандив, тусламж;

6/байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;

7/дүрэмд заасан бусад."

3 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "үйлдвэрийн газарт" гэснийг "нийтийн үйлчилгээний байгууллагад" гэж, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "үйлдвэрийн газраас" гэснийг "нийтийн үйлчилгээний байгууллагаас" гэж, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Төрийн байгууллагаас" гэснийг "Төрийн байгууллага болон нийтийн үйлчилгээний байгууллагаас" гэж, 79 дүгээр зүйлийн "16, 17, 21 дүгээр зүйл, 21¹ дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт" гэснийг "15 дугаар зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын "төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл," гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16, 17, 18, 19, 20, 21, 21¹, 22 дугаар зүйл, 24 дүгээр зүйлийн 1 хэсэг, 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 55 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлд заасан "21, 21¹, 22 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай" зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс, энэ хуулийн 2 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 3 дугаар зүйл, 5 дугаар зүйлд заасан "16, 17, 18, 19, 20, 24 дүгээр зүйлийн 1 хэсэг, 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 55 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцох тухай" зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг

сайжруулах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасан хугацаа дуусгавар болсон өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9.б дэх дэд заалтын "хуулийн этгээд" гэснийг "компани" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсгийн "өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар" гэснийг "өмчийн компаниар" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс, энэ хуулийн 2 дугаар зүйлийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасан хугацаа дуусгавар болсон өдрөөс эхлэн тус тус дагаж мөрднө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай

“8.9.8.төрийн болон орон нутгийн өмчит компани жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагад хүргүүлэх.”

2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн” гэснийг “төрийн өмчит компанийн” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд дараах агуулгатай 7.1.13 дахь заалт нэмсүгэй:

"7.1.13.орон нутгийн өмчит компани."

2 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтын "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг" гэсний дараа ", төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компанийн хувьд тухайн компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээдийг" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1/7.1.9.нийтийн үйлчилгээний байгууллага;

2/7.1.10.төрийн өмчит компани;"

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д заасан хугацаа дуусгавар болсон өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан өргөн мэдүүлэх;

2/хуульд заасан шаардлагад нийцүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу байгуулагдсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах зохион байгуулалтын арга хэмжээ авах, дүнг нэгтгэн танилцуулах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо (Р.Сэддорж)-нд даалгасугай.

3. Энэ тогтоолыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТУХАЙ”
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР

2024

Гарчиг	
Оршил	3
Нэг. Шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал	3
Хоёр. Үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал	4
2.1. Зорилгод хүрэх байдал	4
2.2. Практикт хэрэгжих боломж	16
2.3. Ойлгомжтой байдал	17
2.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал	18
2.5. Харилцан уялдаа	22
Гурав. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал	22
3.1. Зорилгодоо хурсэн байдал шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	22
Төрийн зохицуулах, компанийн удирдлагын чиг үүрэг салангид байх	22
Зах зээлийн эдийн засгийг бэхжүүлж, чөлөөт өрсөлдөөнийг хангах	25
Дотоот хяналтыг бэхжүүлэх	26
Ногдол ашгийн бодлогыг хэрэгжүүлэх	27
Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх	30
3.2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	33
Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн бүрэн эрх	33
Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын чиг үүрэг	35
Хувьцаа эзэмшигч ба хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн эрх	37
ТУЗ-ийн дэргэдэх хороод	37
3.3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	39
3.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	41
Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим	41
Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэл	45
Үнэт цаас гаргах, зээл авах	47
ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага	48
3.5. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	50
Дөрөв. Дүгнэлт, санал	63
Эх сурвалж	64

Оршил

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу үнэлнэ” гэж заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу гүйцэтгэв.

Энэ хүрээнд дараах дараах үе шаттайгаар хийсэн болно. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох аргын дагуу үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, дүгнэлт санал гаргах;

Нэг. Шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг төрийн болон орон нутгийн өмчит компанийд хамаарах зохицуулалтыг тодорхой болгох, компанийн удирдлага, сайн засаглал, хяналт, ил тод байдлыг сайжруулах санхүүгийн үйл ажиллагаа, өгөөжийг сайжруулах зорилгоор нийт 10 бүлэг, 52 зүйлтэйгээр боловсруулсан байна. Хуулийн төсөл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэг:	Нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг:	Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах
Гуравдугаар бүлэг:	Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа, ногдол ашиг
Дөрөвдүгээр бүлэг:	Хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх
Тавдугаар бүлэг:	Компанийн удирдлага, зохион байгуулалт
Зургаадугаар бүлэг:	Компанийн хяналтын тогтолцоо
Долоодугаар бүлэг:	Төрийн болон орон нутгийн өмчит компани, түүний албан тушаалтны гүйцэтгэлийг үнэлэх
Наймдугаар бүлэг:	Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах
Есдүгээр бүлэг:	Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээллийн ил тод байдал
Аравдугаар бүлэг:	Бусад

¹Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

Хоёр. Үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
5. Харилцан уялдаа зэрэг болно.

Зардлын тооцоо шалгуур үзүүлэлтийн хувьд төрийн болон орон нутгийн өмчitt компанийн тухай хуулийн төслийн зардлын тооцооны талаарх бие даасан үнэлгээг хийгдсэн болно /*Зардлын тооцооны тайлангаас үзнэ үү/*.

2.1. Зорилгод хүрэх байдал

2.1. "Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж буй байдлыг авч үздэг. Ингэхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төслийн суурь зохицуулалтыг сонгон авч, үнэлсэн болно. Үүнд:

№	Хуулийн төслийн үзэл баримтлал	Хуулийн төслийн зүйл заалт
1.	Төрийн зохицуулах чиг үүрэг, өмчлөгчийн бодлого, болон компанийн удирдлагын чиг үүрэг салангид байх	29.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй: 29.1.1. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүргийг компанийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх; 29.1.2. төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд оролцож, шийдвэр гаргахад саналаа өгөх; 29.1.3. шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээлэлтэй танилцаж, үндэслэл бүхий шийдвэр гаргах; 29.1.4. албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглах, компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

29.1.5.албаны чиг үүрэг нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний чиг үүргээс тусгаарлагдсан байх;

29.1.6.өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд дангаараа, эсхүл хамтран компанийн хувьцаа эзэмшигч болсон даруйд мэдэгдэх;

29.1.7.компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үл хамаарах их хэмжээний хэлцэл хийх төлөвлөгөөг тухай бүр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид мэдэгдэх;

29.1.8.энэ хуулийн 29.6-д заасан асуудлаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс өгсөн удирдамж, чиглэлийг биелүүлэх.

29.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр бүх гишүүдийн дийлэнх олонхын саналаар хүчин төгөлдөр болно.

29.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурал болсноос хойш нэг сараас доошгүй хугацааны дотор хурлаар хэлэлцсэн асуудал, хурлаас гарсан шийдвэрийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

...29.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний буруутай үйл ажиллагааны улмаас компанийд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг компанийн дүрэмд тусгасан байна.

29.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч доор дурдсанаас бусад тохиолдолд оролцож, удирдамж, чиглэл өгөхийг хориглоно:

29.6.1.ногдол ашгийг нэмэгдүүлэх;

29.6.2.бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;

29.6.3.компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, эрсдэлийг бууруулах.

25 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт

25.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилно.

25.2.Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах шийдвэр гарсан, эсхүл сул орон гарснаас хойш ажлын таван өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг

сонгон шалгаруулах захиалгыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

25.3. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг 30 хоногийн дотор зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид санал болгоно.

25.4. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус байгууллага, мэргэжлийн нэгдсэн холбооны төлөөлөл бүхий ажлын хэсгийг байгуулна.

25.5. Энэ хуулийн 25.3-т заасны дагуу санал болгосон нэр дэвшигчээс бусад нэр дэвшигчийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэр дэвшигчийн нөөцийн сан үүсгэн бүртгэнэ. Нөөцийн санд орсон нэр дэвшигчийг 2 жил тутам шинэчилнэ.

25.6. Энэ хуулийн 25.5-д заасан нөөцийн санд бүртгэгдсэн нэр дэвшигчээс төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний шаардлага хангаж байгаа хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд санал болгож болно.

25.7. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон нэр дэвшигчийн нөөц сангийн журмыг Засгийн газар батална.

25.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нэр дэвшигч тус бүрийн үнэлгээний оноо, нэр дэвшигчийн нөөцийн сангийн мэдээллийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудаст нээлттэй, ил тод байршуулна.

26 дугаар зүйл. Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт

		<p>26.1.Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар зохион байгуулна.</p> <p>26.2.Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасныг баримтална.</p>
2.	Чөлөөт зах зээлийг бэхжүүлж, шударга өрсөлдөөнийг хангах	<p>8 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл</p> <p>8.1.Төрийн өмчит компанийг дараах үндэслэлээр үүсгэн байгуулна:</p> <p>8.1.1.хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй зах зээлд оролцох;</p> <p>8.1.2.тодорхой салбарт зүй ёсны монополь үйл ажиллагаа явуулах;</p> <p>8.1.3.нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулах;</p> <p>8.1.4.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бараа, үйлчилгээг бэлтгэн нийлүүлэх;</p> <p>8.1.5.хувийн эрх зүйн гэрээнд заасны дагуу;</p> <p>8.1.6.стратегийн ач холбогдол бүхий хөрөнгийг удирдах;</p> <p>8.1.7.хуульд тусгайлан заасан.</p> <p>8.2.Орон нутаг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлаа шийдвэрлэх зорилгоор энэ хуулийн 8.1.1, 8.1.3-т заасан үндэслэлээр орон нутгийн өмчит компанийг үүсгэн байгуулна.</p> <p>8.3.Энэ хуулийн 8.1.6-д заасан стратегийн ач холбогдол бүхий хөрөнгийг холбогдох хууль болон энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлээр тодорхойлно.</p>
3.	Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	<p>37 дугаар зүйл.Компанийн аудитын тогтолцоо</p> <p>37.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн аудитын тогтолцоо нь төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, дотоод аудитын нэгж, дотоод аудитор, хөндлөнгийн аудитаас бүрдэнэ.</p> <p>37.2.Энэ хуулийн 37.1-д заасан аудитын хорооны дарга нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.</p> <p>37.3.Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална. Журамд аудитын хороо, гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийн хороонд</p>

тогтмол мэдээлэл солилцох арга хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг тусгасан байна.

37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бурийн санхүүгийн тайлангаа нягтлан шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, санхүүгийн баримтыг хянуулан хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор хөндлөнгийн аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр аудит хийлгүүлнэ.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан хөндлөнгийн аудит хийх хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулна.

37.6.Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр дараах гурван үзүүлэлтийн хоёроос доошгүйг хангаж байвал төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дотоод аудитын нэгжтэй байна:
37.6.1.нийт ашгийн хэмжээ нь 200 сая төгрөгөөс дээш байх;
37.6.2.борлуулалтын орлогын хэмжээ хоёр тэрбум төгрөгөөс дээш байх;

37.6.3.нийт ажилтны тоо 75-аас дээш байх.

37.7.Энэ хуулийн 37.6-д заасан нөхцөлөөс доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын нэгжтэй байх нь эдийн засгийн хувьд оновчтой гэж дүгнэсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн зөвшөөрлөөр энэ тухай шийдвэр гаргаж болно.

37.8.Дотоод аудитын нэгж нь компанийн үйл ажиллагааны цар хүрээ, эдийн засгийн үр ашгаас хамааран төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тооны бүтцэд хамаарах тодорхой тооны аудитороос бүрдэнэ.

37.9.Дотоод аудитын нэгж нь тухайн компанийн нэгжийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус шалгалт хийж, дүгнэлт гаргах ба дүгнэлтээ гүйцэтгэх удирдлагад танилцуулж, төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх аудитын хороонд тайлагнана.

37.10.Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, аудиторын эрх, үүрэг, шалгалт зохион байгуулах хэлбэр, авч хэрэгжүүлэх

		<p>арга хэмжээ, дүгнэлт гаргахтай холбогдсон харилцааг хуульд нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын журмаар тогтооно.</p> <p>37.11.Энэ хуулийн 37.6-д зааснаас доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компани нь дотоод аудитын нэгжгүй байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн харьяанд дотоод аудитор ажиллана.</p> <p>38 дугаар зүйл.Компанийн дотоод аудитын чиг үүрэг</p> <p>38.1.Компанийн дотоод аудитын нэгж, дотоод аудитор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>38.1.1.компанийн няглан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартад нийцэж байгаа эсэх, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээлэл үнэн зөв эсэхийг хянан шалгаж, дүгнэлт өгөх;</p> <p>38.1.2.компанийн хэтийн зорилго, бизнес төлөвлөгөө, урт хугацааны төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, засаглалын үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах замаар компанийг зорилтоо биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>38.1.3.компанийн бүх нэгжийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус шалгалт хийж, дүгнэлт гаргах ба дүгнэлтээ төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захиралд танилцуулах;</p> <p>38.1.4.төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>38.1.5.компанийн төсөв, хөрөнгө, нөөцийн ашиглалт, зарцуулалт хэмнэлттэй, үр ашигтай, үр өгөөжтэй байгаа эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;</p> <p>38.1.6.компанийн дүрэм болон компанийн дотоод аудитын дүрэмд заасан бусад.</p>
4.	Ногдол ашгийн бодлогыг хэрэгжүүлэх	<p>16 дугаар зүйл.Ногдол ашиг</p> <p>16.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани ногдол ашиг хуваарилахад Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:</p> <p>16.1.1.өмнөх жилийн эцсийн аудит хийгдсэн санхүүгийн тайлан дахь татвар төлсний дараах цэвэр ашгийн тодорхой хувиар;</p>

		<p>16.1.2.төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тодорхой хувиар.</p> <p>16.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан зарчмын дагуу тооцсон дунгийн аль өндөр дүнгээр төсөвт ногдол ашиг төвлөрүүлнэ.</p> <p>16.5.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 16.4-т заасныг баримтлан ногдол ашгийн дүнг тооцсоныг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлд санал өгөх чиглэл гэж үзнэ.</p> <p>16.6.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани ногдол ашиг хуваарилах асуудлаар энэ хуулийн 16.5-д заасан чиглэлийг баримтлаагүй, эсхүл ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар, эсхүл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, эцэслэн шийдвэрлэнэ.</p> <p>48 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн нөөц сан</p> <p>48.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн компани жил бүр татварын дараах цэвэр ашгийн 10 хувь хүртэл хэмжээний хөрөнгийг ногдол ашиг хуваарилахаас өмнө компанийн нөөц сан байгуулан төвлөрүүлж болно.</p> <p>48.2.Энэ хуулийн 48.1-д заасан нөөц сан байгуулахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.</p> <p>48.3.Энэ хуулийн 48.1-д заасан нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:</p>
5.	Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх	<p>Долоодугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийт компани, түүний албан тушаалтны гүйцэтгэлийг үнэлэх 39 дүгээр зүйл. Компанийн бизнес төлөвлөгөө, түүний гүйцэтгэл</p> <p>39.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор энэ хуулийн 33.1-д заасан хугацаанд хэрэгжүүлэх компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлнэ.</p> <p>39.2.Гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлийн хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг төрийн болон орон</p>

	<p>нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.</p> <p>39.3.Гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.</p> <p>39.4.Энэ хуулийн 39.1-д заасан компанийн бизнес төлөвлөгөөнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах болон компанийн тогтвортой хөгжлийн бодлогын арга хэмжээг тусган хэрэгжүүлнэ.</p> <p>40 дүгээр зүйл.Компанийн гүйцэтгэлийн үнэлгээ</p> <p>40.1.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гүйцэтгэх захирлын гэрээний хэрэгжилтийн тайландаа үндэслэн жил бүр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлнэ.</p> <p>40.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 40.1-д заасны дагуу компанийн гүйцэтгэлийн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг ирүүлэхийг компанийн удирдлагаас шаардах эрхтэй.</p> <p>40.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, аргачлал, үнэлгээний журмыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар батална.</p> <p>40.4.Энэ хуулийн 40.3-т заасан үнэлгээний шалгуурт дараах асуудлыг хамааруулна:</p> <p>40.4.1.компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин;</p> <p>40.4.2.компанийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн зохицой менежмент;</p> <p>40.4.3.санхүүгийн менежмент, төсвийн хэмнэлт, хэтрэлт;</p> <p>40.4.4.гүйцэтгэлийн үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоо;</p>
--	---

40.4.5. борлуулалтын орлого, ашгийн хэмжээ, төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдал, хөрөнгийн ашиглалт, өөрийн хөрөнгийн өгөөж, ашигт ажиллагаа, мөнгөн урсгалын зорилтот түвшин.

40.5. Компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн компанийтай ижил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бусад компанийн гүйцэтгэлтэй харьцуулж болно.

40.6. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж, үнэлгээний тайланг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

40.7. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 40.6-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийн үнэлгээний тайланг нэгтгэж, Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

40.8. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдсэн бол хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, эсхүл төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар гүйцэтгэх захирлыг чөлөөлүүлэхээр төлөөлөн удирдах зөвлөлд санал гаргах эрхтэй.

40.9. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар нь аудитор болон компанийн бусад эрх бүхий албан тушаалтан үүргээ зохих ёсоор гүйцэтгэгүй бол албан тушаалаас чөлөөлүүлэх санал гаргах эрхтэй.

40.10. Энэ хуулийн 36.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн компани 3 жил дараалан санхүүгийн зорилтот үр дүнд хүрээгүй бол өөрчлөн байгуулах, татан буулгах, эсхүл хувьцааг шилжүүлэх, худалдах арга хэмжээг авна.

41 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл

	<p>41.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн бизнес төлөвлөгөө батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор бизнесийн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.</p> <p>41.2.Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн компанийн хувьд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн компанийн хувьд орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт хүргүүлнэ.</p> <p>41.3.Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөнд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн тухайн жилд хэрэгжүүлэх ажлыг тусгасан байна.</p> <p>41.4.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.</p> <p>42 дугаар зүйл.Ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ</p> <p>42.1.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.</p> <p>42.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд шаардлагатай бусад мэдээллийг ирүүлэхийг шаардах эрхтэй.</p> <p>42.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлалыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.</p> <p>Есдүгээр бүлэг. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээллийн ил тод байдал</p> <p>47 дугаар зүйл.Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан</p> <p>47.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь Няглан бодох бүртгэлийн тухай хууль² болон Компанийн тухай</p>
--	--

² Няглан бодох бүртгэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

хуульд³ заасан журмын дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлнэ.

47.2. Санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан бүрэлдэхүүнтэй байна.

47.3. Энэ хуулийн 47.1-д заасан үйл ажиллагааны тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

47.3.1. санхүүгийн болон санхүүгийн бус зорилтын хэрэгжилт, батлагдсан ногдол ашгийн бодлого, үйл ажиллагааны зорилго, зорилтын нийцэл;

47.3.2. бизнесийн стратегийн бодлого, зах зээлийн дүн шинжилгээ;

47.3.3. гадаад болон дотоод зах зээлийн эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

47.3.4. бизнесийн хэтийн төлөвийг ойлгоход чухал ач холбогдолтой санхүүгийн бус эрсдэл, тодорхой бус хүчин зүйлсийн тайлбар;

47.3.5. санхүүгийн жилийн хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдан авалт, онцлох үйл явдал;

47.3.6. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн, цалин хөлс, урамшууллын мэдээлэл;

47.3.7. компанийн тогтвортой хөгжил болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын тайлан;

47.3.8. хүний нөөц, ажиллах хүч, байгууллагын бүтэц;

47.3.9. холбогдох оролцогч талууд болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс өгсөн чиглэлийн үр нөлөө.

47.4. Энэ хуулийн 47.3-т заасан үйл ажиллагааны тайландаа төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг хэрхэн чиглүүлсэн, удирдан зохицуулсан, хянаж нийцүүлсэн талаарх тайлан, гүйцэтгэх захирлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хүлээн авсан цалин хөлс, урамшууллын хэмжээний талаарх мэдээллийг хавсарган ирүүлнэ.

47.5. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийт төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдалд хяналт тавина.

³ Компанийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

47.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт төр болон орон нутгийн хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг жил бүр хүргүүлнэ. Илтгэл бэлтгэх загварыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

47.7.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн энэ зүйлд заасан тайлан, илтгэлийг нэгтгэн жилд нэг удаа төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн эзэмшиж байгаа хувьцааг шилжүүлэх үр дүнтэй хувилбарын талаарх нэгдсэн тайлан бэлтгэж, саналын хамт Засгийн газарт танилцуулна.

47.8.Энэ хуулийн 47.7-д заасан нэгдсэн тайлан, саналыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд олон нийтэд ил тод, нээлттэй байршуулна.

49 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдал

49.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8-д заасан болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг өөрийн цахим хуудсанд ил тод байршуулна:

49.1.1.хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;

49.1.2.хуулийн этгээдийн зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ, биет, биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;

49.1.3.хуулийн этгээдийн сүүлийн таван жилд хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;

49.1.4.хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;

49.1.5.хуулийн этгээдийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

49.1.6.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны

	<p>шалгуур үзүүлэлт, гэрээ, түүний гүйцэтгэлийг дүгнэсэн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;</p> <p>49.1.7.хуулийн этгээдийн эсрэг, эсхүл хуулийн этгээдтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;</p> <p>49.1.8.хуулийн этгээдийн дүрэм, хуулийн этгээдийн үйл ажиллагааны болон засаглалын дотоод журам;</p> <p>49.1.9.тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын мэдээлэл, хэрэгжилтийн байдал;</p> <p>49.1.10.бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын болон нийлүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал, хэрэгжилтийн явц;</p> <p>49.1.11.Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;</p> <p>49.1.12.байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;</p> <p>49.1.13.тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;</p> <p>49.1.14.төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан дэмжлэг, хандив, тусламж.</p> <p>49.2.Энэ хуулийн 49.1-д заасан мэдээлэлд хяналт шалгалт хийх зорилгоор холбогдох баримт бичгийг хуулбарлахыг зөвшөөрнө.</p>
--	--

2.2. Практикт хэрэгжих боломж

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдүүлэх боломж, хуулийн зохицуулалтыг нийгмийн харилцаан дээр бодитоор хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх эсэхийг тооцон судлахаар сонгов.

Мөн хуулийн төслийн хүрээнд шинээр бий болж байгаа тогтолцоо, байгууллага, этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах зохицуулалтыг сонгон үзлээ.

№	Хуулийн төслийн зүйл, заалт
---	-----------------------------

1	<p>20.1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаар төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>20.1.4. төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд уг асуудлаар хувьцаа эзэмшигчийн хуралд санал хүргүүлэх;</p> <p>20.1.5. төрийн болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирал хууль болон дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх саналаа төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх;</p>
2	<p>21 дүгээр зүйл. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын чиг үүрэг</p> <p>21.1. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>
3	<p>21.2. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>21.2.4. ... хуульд заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, хариуцлага хүлээлгэх саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;</p>
4	<p>23 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл</p> <p>23.2. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 82.1-д заасан хороодтой байх бөгөөд хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байна.</p>

2.3. Ойлгомжтой байдал

2.3. “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтай томьёологдсон эсэхийг шалган авч үздэг. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл нь Компанийн тухай хуулийн тусгай хууль болохын хувьд агуулга, нэр томьёоны хувьд Компанийн тухай хуультай нийцэж байх ёстой.

Иймээс төслийн ойлгомжтой байдлыг Компанийн тухай хуультай харилцааг холбоог сайжруулах үүднээс авч үзлээ.

№	Хуулийн зүйл заалт
1	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

	3.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.
2	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.1.“төрийн өмчит компани” гэж төр хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл хяналтын эрхийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг; 4.1.2.“орон нутгийн өмчит компани” гэж орон нутаг хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл хяналтын эрхийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг;
3	6 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрөл, хэлбэр 6.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь хувьцааны эзэмшлээс хамаарч дараах төрөлтэй байна:
4	8.4.Энэ хуулийн 8.1.4-т заасан үндэслэлээр үйл ажиллагаа явуулах компани нь төрийн өмчийн компани байна.
5	10 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн дүрэм 10.1.Засгийн газар төрийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийн хамт компанийн дүрмийг батална. 10.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийн хамт компанийн дүрмийг батална.
6	13 дугаар зүйл.Алтан хувьцаа 13.1.Засгийн газар төрийн өмчит компанийн төрд ногдох хувьцааг бүхэлд нь худалдах тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй алтан хувьцааг гаргахаар зааж болно.
7	21.2.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 21.2.8.төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг жил бүр хүлээн авч хянах;

2.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуурын хувьд хуулийн төсөл батлагдснаар түүнийг дагаж мөрдөх чиг үүрэг бүхий субъектүүд хүлээн зөвшөөрөх, хуулийн төслийн зүйл заалт нь үндсэн зорилгодоо нийцэж хэрэгжих эсэхийг үнэлэнэ. Энэ хүрээнд хуулийн төслөөс дараах зүйлүүдийг сонгон авч үнэлгээг хийв.

№	Хуулийн төслийн зүйл, заалт
1	5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

	<p>5.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:</p> <p>5.1.1.хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх;</p> <p>5.1.2.монополь, эсхүл давамгай байдлаа урвуулан ашиглахгүй байх;</p> <p>5.1.3.бусад аж ахуйн нэгжээс давуу эрх эдлэхгүй байх;</p> <p>5.1.4.компанийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;</p> <p>5.1.5.улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх;</p> <p>5.1.6.компани төрийн болон орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх;</p> <p>5.1.7.санхүүгийн үр ашигтай байх;</p> <p>5.1.8.ил тод, нээлттэй байх.</p> <p>5.2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд энэ хуулийн 5.1-д зааснаас гадна дараах зарчмыг баримтална:</p> <p>5.2.1.Засгийн газрын бүрэн эрх, орон нутгийн эрх хэмжээ компанийн удирдлагын бүрэн эрхээс тусгаарлагдсан байх;</p> <p>5.2.2.компанийн бүх хувьцаа эзэмшигч эрх тэгш байх;</p> <p>5.2.3.хараат бус хөндлөнгийн хяналттай байх;</p> <p>5.2.4.мэргэжлийн байх;</p> <p>5.2.5.үр ашиггүй зардал гаргахгүй байх;</p> <p>5.2.6.санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллах;</p> <p>5.2.7.хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх.</p>
2	<p>7 дугаар зүйл.Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэл</p> <p>7.5.Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газар,</p> <p>7.6.Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлсэн энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг Улсын Их Хурлын төсвийн болон эдийн засгийн асуудал эрхэлсэн Байнгын хороонд хүргүүлж танилцуулна.</p> <p>7.7.Үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн тайланг Засгийн газар болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулна.</p>
3	<p>14 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийд хөрөнгө олж авах</p> <p>14.1.Ашигт малтмалын тухай хууль болон Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл бүхий компанийн хувьцааг эзэмших замаар төр хөрөнгө олж авч болно.</p>

	<p>14.2.Дараах тохиолдолд төр, эсхүл орон нутаг нь компанийн энгийн хувьцааны 34, түүнээс доош хувийг олж авч болно:</p> <p>14.2.1.бэлэглэл, өв залгамжлалаар эзэмшилдээ олж авсан;</p> <p>14.2.2.хууль тогтоомжид заасны дагуу;</p> <p>14.2.3.арилжааны гэрээний дагуу;</p> <p>14.2.4.шүүх, арбитрын шийдвэрийн дагуу.</p> <p>14.3.Энэ хуулийн 14.2-т заасны дагуу хувьцааг олж авсан бол төр, эсхүл орон нутаг тухайн хувьцааг олж авахад зарцуулсан хөрөнгийн зардлын бодит үнэ цэнийг тооцон, түүнээс доошгүй үнэлгээтэй байхаар тухайн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах арга хэмжээ авна.</p>
5	<p>15 дугаар зүйл.Үнэт цаас гаргах, зээл авах</p> <p>15.1.Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу үнэт цаас гаргана.</p> <p>15.2.Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр урт хугацааны зээл авч болно.</p> <p>15.3.Гүйцэтгэх захирал зээлийн гэрээний дагуу төлбөл зохих хуваарь болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг төлж барагдуулах төлөвлөгөө, хуваарийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан төлөөлөн удирдах зөвлөлд, төлөөлөн удирдах зөвлөл байхгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.</p>
6	<p>24 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага</p> <p>24.1.4.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болж дампуурсан нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;</p> <p>24.1.5.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгосон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;</p> <p>28 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох</p> <p>28.5.Энэ хуулийн 28.4-т заасан хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн томилогоогүйн улмаас төрийн болон орон нутгийн өмчйт компанийн</p>

	хэвийн үйл ажиллагаа алдагдаж, компани болон хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна. 28.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилох, эсхүл томилулахаар санал болгоходо жэндэрийн эрх тэгш байдал буюу төлөөлөн удирдах зөвлөл дэх хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалзана.
7	32 дугаар зүйл.Гүйцэтгэх захирал, түүнд нэр дэвшигчид тавих шаардлага 32.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захиралд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна: 32.1.1.энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангасан байх; 32.1.2.бизнесийн удирдлага, хууль, санхүү эсхүл компанийн үйл ажиллагаанд хамаарах салбарын мэдлэг, туршлагатай байх; 32.1.3.өөрийн буруутай үйл ажиллагаанаас төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, захирал, дэд захирлын албан тушаалаас чөлөөлөгдөөгүй байх; 32.1.4.бусад компанийд гүйцэтгэх удирдлагын албан тушаал давхар эрхэлдэггүй байх; 32.1.5.компанийн дүрэмд заасан бусад шаардлага.
8	39 дүгээр зүйл.Компанийн бизнес төлөвлөгөө, түүний гүйцэтгэл 39.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор энэ хуулийн 33.1-д заасан хугацаанд хэрэгжүүлэх компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлнэ. 39.2.Гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлийн хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ. 39.3.Гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ. 39.4.Энэ хуулийн 39.1-д заасан компанийн бизнес төлөвлөгөөнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах болон компанийн тогтвортой хөгжлийн бодлогын арга хэмжээг тусган хэрэгжүүлнэ.
9	41 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл

	<p>41.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн бизнес төлөвлөгөө батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор бизнесийн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.</p> <p>41.2.Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн компанийн хувьд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн компанийн хувьд орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт хүргүүлнэ.</p> <p>41.3.Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөнд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн тухайн жилд хэрэгжүүлэх ажлыг тусгасан байна.</p> <p>41.4.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.</p>
--	--

2.5. Харилцан уялдаа

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Үндсэн хууль холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

Гурав. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

3.1. Зорилгодоо хүрсэн байдал шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Төрийн зохицуулах, компанийн удирдлагын чиг үүрэг салангид байх

Төр болон орон нутаг нь төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчийн хувиар компанийн удирдлага буюу Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТҮЗ” гэх/ дэх өөрийн төлөөллийг сонгож, чөлөөлөхөд оролцох нь мэдээжийн зүйл юм. Энэ нь төрийн болон орон нутгийн өмчит компанийн ТҮЗ-д төрийн төлөөллийг хэрэгжүүлж буй ТҮЗ-ийн гишүүний хувьд төрийн эрх ашгийг буюу өөрийг нь сонгосон хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг бусад хувьцаа эзэмшигч болон компанийн эрх ашгаас тэргүүн ээлжид байна утга санааг илэрхийлэхгүй. Өөрөөр хэлбэр, компанийн ТҮЗ нь компанийн эрх ашгийн төлөө ажиллах замаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг эрх ашгийг хангаж ажиллах орган байдаг. Энэ ч утгаараа, ТҮЗ нь мэргэшсэн этгээдийн хувиар тодорхой хувьцаа эзэмшигчийн өмнө бус компанийн өмнө итгэл даах үүрэг (fiducury duties)-ийг хүлээж, зөрчсөн тохиолдолд компанийн өмнө хариуцлага хүлээдэг⁴.

⁴ Г.Давааням, Компанийн эрх зүйн онол, практик, 83-84 (Соёмбо., 2023).

Улмаар хууль тогтоомжоор ТУЗ-ийн гишүүнд тодорхой хувьцаа эзэмшигчийн удирдамж, чиглэлийн баримтлах үүргийг хүлээлгэх нь түүний компанийн өмнө хүлээсэн итгэл даах үүргийн агуулгад харшилхаас гадна ТУЗ-ийн гишүүний мэргэшсэн удирдлага болохын хувьд хэрэгжүүлэхээр Компанийн тухай хулиар олгогдсон бүрэн эрхийг үгүйсгэнэ. Хуулийн төслийн 29.1.8-д төр болон орон нутгийн өмчийг төлөөлж буй ТУЗ-ийн гишүүн нь “энэ хуулийн 29.6-д заасан асуудлаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс өгсөн удирдамж, чиглэлийг биелүүлэх”-ээр зохицуулсан хуулийн төслийн үзэл баримтлалд нийцэхгүй байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалын 1-т “Монгол Улсад эдийн засгийн харилцаанд төр зохицуулагчийн хувиар оролцох бодлогыг баримталдаг хэдий ч зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой улс орнуудад нийтлэг мөрддөг “төрийн зохицуулах болон өмчлөлийн бодлого салангид байх” зарчим зарим талаараа алдагдаж, төрийн болон орон нутгийн өмчийг удирдах ялгаа зааг, ашиглуулах, шилжүүлэх журам тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, төрийн бодлогыг уялдуулах нэрийн дор төрийн өмчит компанийн бизнесийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж оролцох, төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага олон улсад тогтсон шаардлагаас доогуур, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь төрийн захиргааны албан хаагч байх болзлыг хуульчилсантай холбогдуулан төрийн захиргааны албан хаагч, улс төрийн албан тушаал хашиж байсан этгээдийг төлөөлөн удирдах зөвлөлд томилох, томилуулахаар нэр дэвшиүүлж байгаа нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг мэргэжлийн бус болгож, компанийн сайн засаглалын тогтолцоо бүрдэх нөхцөлийг хааж байна” хэмээн заасан нь төрийн зохицуулах чиг үүрэг, төрийн өмчлөгчийн бодлого, компанийн мэргэшсэн удирдлага тус тусдаа байх үзэл санааг илэрхийлжээ.

Иймээс хуулийн төслийн 29.1.8 болон 29.6-т ТУЗ-ийн гишүүнд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс удирдамж, чиглэл өгөх зохицуулалтын хийсэн нь төрийн өмчлөгчийн бодлого болон мэргэшсэн удирдлага салангы (*separation of ownership and management of company*)-д байх зарчимд нийцэхгүй хэмээн дүгнэж болно. Энэхүү үзэл санаа нь компанийн ТУЗ нь мэргэшсэн удирдлагын хувиар зөвхөн хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг бус, компанийн харилцагч, хэрэглэгч, ажилтан, бус нутаг зэрэг компанийн оролцогч талууд(*stakeholder*)-ын ашиг сонирхлыг хангахад чиглэсэн тогтвортой хөгжил, урт хугацааны ашигт суурилж байдаг.⁵

⁵ Г.Давааням, М.Түвшинжаргал, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөл: олон улсын туршлага ба Монгол улс, 42-43 (ННФ., 2022).

Судлаачийн санал

- 29.1.8-энэ хуулийн 29.6-д заасан асуудлаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс өгсөн удирдамж, чиглэлийг биелүүлэх.
- 29.6-Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дөөр дурдсанаас бусад төхиөлдөл оролцож, удирдамж, чиглэл өгөхийг хөригяюно:
- 29.6.1. ногдол ашгийг нэмэгдүүлэх;
- 29.6.2. бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;
- 29.6.3. компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, эрсдэлийг бууруулах.

Компанийн хууль тогтоомж нь хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг хүртэх сонирхол болон ТУЗ-ийн гишүүний ногдол ашиг хуваарилахгүй байх сонирхол хоордын зөрчил зэргийг хувьцаа эзэмшигчийн ТУЗ-ийн гишүүнийг сонгож, чөлөөлөх бүрэн эрхэд тулгуурлан зохицуулдаг. Ингэснээр ТУЗ-ийн гишүүн нь ногдол ашиг хуваарилах эсэхийг шийдвэрлэхдээ гагцхүү хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс хараат бус, компанийн ашиг сонирхол, үйл ажиллагааны тогтвортой байдал, бизнесийн тэлэлтийг харгалзах, ногдол ашиг хуваарилах нөхцөл журмыг мөрдөж ажиллах үргээ биелүүлэх нөхцөл бүрдэнэ. Энэхүү асуудал нь компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, эрсдэлийг бууруулах хүрээнд ч яригдах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлөх бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчдийн хуралд олгосон байдаг.

Бизнесийн практикт хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилуулах өөрийн сонирхлыг ТУЗ дэх өөрийн төлөөллийн гишүүнд илэрхийлэх, компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахыг шаардах, зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх шаардах зэрэг нь чөлөөтэй байдлаар явагдана.

Харин хууль тогтоомжоор ТУЗ-ийн гишүүнд үүрэг хүлээлгэх байдлаар тусгайлан зохицуулах нь компанийн засаглалын суурь зарчимд харшилна. Учир нь ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогсдон, мэргэшсэн этгээдийн хэн нэгэн хувьцаа эзэмшигчийн эрх ашиг бус, компанийн нийтлэг эрх ашгийг төлөөл ажиллах үүрэг бүхий этгээд байдаг.

Иймээс хуулийн төслийн 29.1.8-т заасны дагуу хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн удирдамж, чиглэлийг заавал даган мөрдөх үүргийг хуулиар зөвшөөрөх нь ТУЗ-ийн гишүүний компанийн өмнө хүлээх итгэл даах буюу үнэнч байх, хариуцлагатай байх суурь үүргийн агуулгад харшилна.

Зах зээлийн эдийн засгийг бэхжүүлж, чөлөөт өрсөлдөөнийг хангах

Монгол улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна" хэмээн тусгаж, зах зээлийн эдийн засаг, чөлөөт өрсөлдөөний эрх зүйн үндсийг тавьсан. Энэ хүрээнд 1993 онд Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг баталсан. Түүнчлэн олон улсын нийтлэг чиг хандлагад нийцүүлэх, олон улсын өрсөлдөөний эрх зүйн дэвшилтэд зохицуулалтыг нутагшуулах зорилгоор 2010 онд Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж мөрдүүлсэн.

Зах зээлийн эдийн засгийн бэхжүүлж, чөлөөт өрсөлдөөнийг хангах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн үйл ажиллагаа, эдгээрийг үүсгэн байгуулах асуудлыг хязгаарлах шаардлагатай тулгарсан. Энэ ч утгаараа Хуулийн төслийн үзэл баримтал 2-т "зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйд үүсэж болох зерэг, сөрөг үр дагаврын талаарх үндэслэл бүхий тооцоо, судалгаагүйгээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг үүсгэн байгуулж, хувийн хэвшилтэй өрсөлдж зах зээлд оролцох нь нэмэгдэж, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог дэмжихэд сөргөөр нөлөөлж байна" хэмээн үзэж, дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

8 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл

8.1.Төрийн өмчит компанийг дараах үндэслэлээр үүсгэн байгуулна:

- 8.1.1.хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй зах зээлд оролцох;
- 8.1.2.тодорхой салбарт зүй ёсны монополь үйл ажиллагаа явуулах;
- 8.1.3.нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулах;
- 8.1.4.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бараа, үйлчилгээг бэлтгэн нийлүүлэх;
- 8.1.5.хувийн эрх зүйн гэрээнд заасны дагуу;
- 8.1.6.стратегийн ач холбогдол бүхий хөрөнгийг удирдах;
- 8.1.7.хуульд тусгайлан заасан.

8.2.Орон нутаг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлаа шийдвэрлэх зорилгоор энэ хуулийн 8.1.1, 8.1.3-т заасан үндэслэлээр орон нутгийн өмчит компанийг үүсгэн байгуулна.

8.3.Энэ хуулийн 8.1.6-д заасан стратегийн ач холбогдол бүхий хөрөнгийг холбогдох хууль болон энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлээр тодорхойлно.

Өөрөөр хэлбэл, хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй зах зээлд оролцох, нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт үйл

ажиллагаа явуулах, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бараа үйлчилгээ эрхлэхээс бусад салбарт төрийн өмчит компани үүсгэн байгуулахыг хориглосон байна.

Энэхүү төслийн зохицуулалтын агуулга нь хуулийн төслийн үзэл баримтлалыг практикт хэрэгжих боломжийг бурдүүлсэнээс гадна Үндсэн хууль дахь чөлөөт зах зээлийн үзэл санаанд бүрэн нийцэж байна.

Дотоот хяналтыг бэхжүүлэх

Компанийн дотоод хяналт нь товчхондоо хамгийн алдагдсан боломжийг доод хэмжээнд барьж, ашиг ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн тогтолцоо хэмээн хэлж болно.⁶ Хуулийн үзэл баримтлалын 3-т төрийн болон орон нутгийн өмчит компанийн хяналтын тогтолцоог бэхжүүлнэ гэжээ. Үүнийг улс болон орон нутгийн төсвийн хяналтаас гадуур төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны хүрээнд их хэмжээний хөрөнгө /орлого, зардал/ эргэлдэж байгаа боловч, үр ашиг хангалтгүй байгаа асуудалтай холбон авч үзэж болон. Тухайлбал, 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого 23, зарлага 16 их наяд төгрөг, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 87.1 тэрбум төгрөгийн алдагдалд хамаарах тоо баримтыг авч үзжээ.

Дэлгэрэнгүй байдлаар авч үзвэл *Нэгдүгээрт*, 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой толгой 99, охин хараат компаниудыг оролцуулаад нийт 123 компани, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 275 хуулийн этгээдийд нь нийт 23 их наяд 617 тэрбум төгрөгийн орлого, 16 их наяд 912 тэрбум төгрөгийн зардал гаргасан.

Хоёрдугаар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 275 хуулийн этгээдийн хувьд 13 хувьцаат компани 21.6 тэрбум төгрөг, 31 хязгаарлагдмал хариуцлагатай компани 18 тэрбум төгрөг, 200 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 45.9 тэрбум төгрөг, 31 төсөвт үйлдвэрийн газар 1.6 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу нийт 87.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан дүн мэдээ гарсан байна.

Улмаар төрийн болон орон нутгийн өмчийн компаниуд өөрийн цар хүрээнээс хамаарч, дотоод аудитын нэгж байгуулахаар зохицуулжээ. Үүнд:

37.6. Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр дараах гурван үзүүлэлтийн хоёроос доошгүйг хангаж байвал төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дотоод аудитын нэгжтэй байна:

37.6.1. нийт ашгийн хэмжээ нь 200 сая төгрөгөөс дээш байх;

37.6.2. борлуулалтын орлогын хэмжээ хоёр тэрбум төгрөгөөс дээш байх;

⁶ Г.Давааням, Компанийн эрх зүйн онол, практик, 147 (Соёмбо., 2023).

37.6.3.нийт ажилтны тоо 75-аас дээш байх.

37.7.Энэ хуулийн 37.6-д заасан нөхцөлөөс доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын нэгжтэй байх нь эдийн засгийн хувьд оновчтой гэж дүгнэсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн зөвшөөрлөөр энэ тухай шийдвэр гаргаж болно.

37.11.Энэ хуулийн 37.6-д зааснаас доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компани нь дотоод аудитын нэгжгүй байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн харьяанд дотоод аудитор ажиллана.

Мөн дотоод хяналтын нэгж нь гүйцэтгэх удирдлагын бүтцэд хамаарах өнөөгийн Монгол улсын компанийн муу практикыг халж, ТУЗ-ийн бүтцэд харьяалагдахаар зохицуулсан нь компанийн засаглалын зарчимд бүрэн нийцсэн байна.⁷ Үүнд:

37.9.Дотоод аудитын нэгж нь тухайн компанийн нэгжийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус шалгалт хийж, дүгнэлт гаргах ба дүгнэлтээ гүйцэтгэх удирдлагад танилцуулж, төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх аудитын хороонд тайлагнана.

37.10.Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, аудиторын эрх, үүрэг, шалгалт зохион байгуулах хэлбэр, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, дүгнэлт гаргахтай холбогдсон харилцааг хуульд нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын журмаар тогтооно.

Ийнхүү хуулийн төслийн зохицуулалт нь компанийн дотоод хяналтыг бэхжүүлэх хүрээнд компанийн засаглалын зарчимд бүрэн нийцсэнээс гадна хуулийн зорилгын үүднээс авч үзсэн зохистой байна.

Ногдол ашгийн бодлогыг хэрэгжүүлэх

Өмчийн хэлбэрээс үл хамаарч компанийн үйл ажиллагаа нь эцсийн дүндээ хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахад чиглэдэг хэмээн хэлж болно. Харин төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд засаглал, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа тул ашигт ажиллагаа тааруу явж иржээ. Тухайлбал, 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой толгой 99, охин хараат компаниудыг оролцуулаад нийт 123 компани байгаа бол эдгээрийн 43% нь алдагдалтай ажиллажээ. Мөн орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 275 хуулийн этгээдийн нийтдээ 87.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан дүн мэдээ гарсан байна.

⁷ Г.Давааням, Компанийн эрх зүйн онол, практик, 150 (Соёмбо., 2023).

Энэхүү нөхцөл байдал нь 1) засаглал, зохицуулалт хангалтгүй, 2) ногдол ашгийн бодлого байхгүйн улмаас төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны зардал өндөр, ашиг ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой хэмээн ойлгож болно. Улмаар хуулийн төслийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах нийтлэг зарчмуудынг нутагшуулсанаас гадна ногдол ашгийн бодлогыг тодорхой тусгаж өгсөн байна. Үүнд:

16 дугаар зүйл.Ногдол ашиг

16.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани ногдол ашиг хуваарилахад Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

16.1.1.өмнөх жилийн эцсийн аудит хийгдсэн санхүүгийн тайлан дахь татвар төлсний дараах цэвэр ашгийн тодорхой хувиар;

16.1.2.төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тодорхой хувиар.

16.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан зарчмын дагуу тооцсон дүнгийн аль өндөр дүнгээр төсөвт ногдол ашиг төвлөрүүлнэ.

16.5.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 16.4-т заасныг баримтлан ногдол ашгийн дунг тооцсоныг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлд санал өгөх чиглэл гэж үзнэ.

16.6.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани ногдол ашиг хуваарилах асуудлаар энэ хуулийн 16.5-д заасан чиглэлийг баримтлаагүй, эсхүл ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар, эсхүл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, эцэслэн шийдвэрлэнэ.

48 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн нөөц сан

48.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн компани жил бүр татварын дараах цэвэр ашгийн 10 хувь хүртэл хэмжээний хөрөнгийг ногдол ашиг хуваарилахаас өмнө компанийн нөөц сан байгуулан төвлөрүүлж болно.

48.2.Энэ хуулийн 48.1-д заасан нөөц сан байгуулахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

48.3.Энэ хуулийн 48.1-д заасан нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

Түүнчлэн ногдол ашиг хуваарилах хүрээнд хувьцаа эзэмшигчээс гадна компанийн бизнесийн тогтвортой ажиллагаа, шаардах эрх бүхий этгээдийн эрх ашгийн харгалзах шаардлагатай байдаг. Шаардах эрх бүхий этгээдийн эрх ашгийг Компанийн тухай хууль нийтлэг байдлаар хамгаалдаг. Харин компанийн бизнесийн

тогтвортой ажиллагааг хангах зорилгоор хуулийн төсөлд цэвэр ашгийн тодорхой хувиар нөөцийн сан бурдүүлсэний дараа ногдол ашиг хуваарилахаар зохицуулсан нь ач холбогдолдотой болжээ.

Нөгөө талд компани ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрийг хувьцаа эзэмшигчийн хувийн шинж байдлаас үл хамаарч, хувьцаа эзэмшигчдийн хурал эсхүл төлөөлөн удирдах зөвлөл гаргах нь компанийн засаглалын нийтлэг зарчим байдаг. Эдгээр органы гаргасан шийдвэр нь Компанийн хуульд заасны дагуу хүчин төгөлдөр бусад тооцогдохоос бусад тохиолдолд эцсийн байна.

Энэхүү зарчим нь Иргэний хууль дахь хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар, Компанийн тухай хууль дахь компанийн хуулийн этгээдийн эрхийн чадварт суурилах бөгөөд өөрийн хөрөнгийн эрхийг өөрийн дотоод орган, бүтцийн хүрээнд шийдвэрлэх агуулгыг илэрхийлнэ. Гэсэн хэдий ч, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар, эсхүл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, эцэслэн шийдвэрлүүлэхээр зохицуулсан нь оновчгүй байна. Ялангуяа, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд Засгийн газар болон ИТХ нь статусын хувьд хувьцаа эзэмшигчдийн нэг байх тул компанийн эрх зүйн үүднээс хүлээн зөвшөөрөгдөхгүй.

Иймээс хуулийн төслийн зохицуулалтыг ногдол хуваарилаагүй үндэслэлийн талаар Засгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал /цаашид "ИТХ" гэх/ зэрэг хувьцаа эзэмшигчид тайлбарлах байдлаар өөрчлөн найруулах нь зүйтэй. Энэ тохиолдолд дээрх хувьцаа эзэмшигчийн хурал буюу Засгийн газар, ИТХ-ын хуралдаанд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хамтаар компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд оролцож болно.

Хуулийн төслийн заалт

16.6. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани ногдол ашиг хуваарилах асуудлаар энэ хуулийн 16.5-д заасан чиглэлийг баримтлаагүй, эсхүл ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар, эсхүл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, эцэслэн шийдвэрлэнэ.

Судлаачийн санал

16.6. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани ногдол ашиг хуваарилах асуудлаар энэ хуулийн 16.5-д заасан чиглэлийг баримтлаагүй, эсхүл ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар, эсхүл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлбарлана.

16.7. Энэ зүйлийн 16 дугаар зүйлийн 16.6-д заасан хуралдаанд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг оролцуулж болно.

Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх

Компанийн засаглал нь өргөн хүрээнний ойлголт боловч, товчондоо хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага зэрэг компанийн удирдлагын орган горимын дагуу ажиллахад чиглэсэн механизмыг хэлнэ. Энэхүү механизмын цөм нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийг сонгож, чөлөөлөх, ТУЗ-өөс хувьцаа эзэмшигчдийн өмнө тайлагнах, ТУЗ-өөс гүйцэтгэх захирлыг сонгож, чөлөөлөх, гүйцэтгэх захирал ТУЗ-ийн өмнө тайлагнах асуудал байдаг.

Мөн хувьцаа эзэмшигч төрийн байгууллагаас эхлээд олон тооны төлөөллийн этгээдээр дамжуулан компанийн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд мэдээллийн ил тод байдал чухлаар тавигдана. Онолын хувьд хувьцаагаа нээлттэй зах зээлд арилжаалдаг нээлттэй ХК-тай адил түвшний ил тод байдлыг бүрдүүлэх ёстой хэмээн үзэх хандлага түгээмэл байдаг.

Улмаар уг үнэлгээний хүрээнд долоодугаар бүлгийн компани, албан тушаалтны гүйцэтгэлийг үнэлэх, есдүгээр бүлгийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээллийн ил тод байдлын талаар зохицуулалтыг сонгон авч үзлээ.

Бизнес төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээ

Хуулийн төсөлд ТУЗ нь компанийн бизнес төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлд хяналт тавих, гүйцэтгэлийн тайлан, гүйцэтгэх захирлын гэрээний хэрэгжилтийн тайланг бэлтгэсний үндсэн дээр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид тайлагнахаар зохицуулжээ. Улмаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь эдгээр тайланд тулгуурлан компанийн гүйцэтгэлийг үнэлэх бөгөөд үнэлгээний шалгуурыг тодорхой тусгасан байна.

Хуулийн төслийн зохицуулалт нь компанийн засаглалын суурь зарчмын дагуу байх бөгөөд хуулийн төслийн зорилгод бүрэн нийцсэн байна. Харин долоодугаар бүлгийн гарчиг нь “Долоодугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчит компани, түүний албан тушаалтны гүйцэтгэлийг үнэлэх” байгаа нь бүлгийн агуулгад нийцэхгүй байна.

Нэгдүгээрт долоодугаар бүлэг нь компанийн бизнес төлөвлөгөөг батлах, хяналт тавих, үнэлэх асуудалд төвлөрч байна.

Хоёрдугаарт компани болон албан тушаалтны гүйцэтгэлийн үнэлгээ гэсэн томьёоллоор бичигдсэн байх боловч, агуулга нь компанийн орган буюу "төлөөлөн удирдах зөвлөл", "гүйцэтгэх удирдлага"-ын үнэлгээнд хамаарч байна.

Өөрөөр хэлбэл, Компанийн эрх зүйд "эрх бүхий албан тушаалтан" гэсэн томьёолол нь бүтцийн хувьд гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл зэрэг компанийн "орган"-д харьялагдах хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллаж буй бодгаль албан тушаалтнуудад хамааралтай ойлголт болохыг анхаарах шаардлагатай. Харин хуулийн төслийн агуулга нь компанийн бизнес төлөвлөгөө болон түүнийг батлах, хяналт тавих, хэрэгжүүлэхэд чиглэсэн органд хамааралтай байна.

Судлаачийн санал

Долоодугаар бүлэг. *Бизнес төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн үнэлгээ*

Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээллийн ил тод байдал

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээллийн ил тод байдлыг нарийвчлан зохицуулж өгсөн байна. Ингэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн компани болон төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанийн зохицуулалтыг бие даасан байдлаар тусгасан нь оновчтой болжээ.

Харин төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй ХК-ийн мэдээллийн ил тод байдлын онцлогийг харгалзаж үзээгүй байна. Тухайлбал, хуулийн төслийн дараах зохицуулалт нь төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй ХК-д үйлчлэхээр зохицуулсан байна.

49 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдал

49.1. Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8-д заасан болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг өөрийн цахим хуудсанд ил тод байршуулна:

49.1.1. хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;

49.1.2. хуулийн этгээдийн зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ, биет, биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;

49.1.3. хуулийн этгээдийн сүүлийн таван жилд хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;

- 49.1.4.хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;
- 49.1.5.хуулийн этгээдийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;
- 49.1.6.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гэрээ, түүний гүйцэтгэлийг дүгнэсэн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;
- 49.1.7.хуулийн этгээдийн эсрэг, эсхүл хуулийн этгээдтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;
- 49.1.8.хуулийн этгээдийн дүрэм, хуулийн этгээдийн үйл ажиллагааны болон засаглалын дотоод журам;
- 49.1.9.тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын мэдээлэл, хэрэгжилтийн байдал;
- 49.1.10.бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын болон нийлүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал, хэрэгжилтийн явц;
- 49.1.11.Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;
- 49.1.12.байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;
- 49.1.13.тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;
- 49.1.14.төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан дэмжлэг, хандив, тусламж.
- 49.2.Энэ хуулийн 49.1-д заасан мэдээлэлд хяналт шалгалт хийх зорилгоор холбогдох баримт бичгийг хуулбарлахыг зөвшөөрнө.

Компанийн мэдээллийн ил тод байдал нь нэг талаас бүрэн, бодитой мэдээллийг хөрөнгө оруулагч зах зээлд түгээх замаар хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахаас гадна олон нийтийн хяналтыг бий болгодог үнэт цаасны зах зээлийн тулгуур механизм юм. Нөгөө талаас мэдээлллийн ил тод байдал нь компаниас их хэмжээний хөдөлмөр, цаг хугацаа, зардлыг шаардаж байдаг.

Нээлттэй ХК-ийн хувьд өмчийн хэлбэрээс үл хамаарч, СЗХ-ны хяналтад хамаардаг. Энэ ч утгаараа Компанийн тухай хуулийн мэдээлийн ил тод байдлын зохицуулалтаас гадна Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны дүрэм журам, тухайн зах зээлийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага болох Хөрөнгийн биржийн мэдээллийн ил тод байдлын журам нийтлэг байдлаар үйлчилнэ. Хуулийн төсөлд төрийн болон нутгийн өмчтөй компани ил тод болгохоор тусгасан зохицуулалт нь

нээлттэй хувьцаат компанийн хувьд төдийлөн ач холбогдолгүй бөгөөд үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжид заасан мэдээллийн ил тод байдалд бүрэн хамаарна.

Иймээс төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй ХК-д Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн Есдүгээр зүйл үйлчлэхгүй байхаар зохицуулах нь зүйд нийцнэ. Харин Үнэт цаасны зах зээлийн хууль болон тухайн салбарын холбогдох журамд заасны дагуу нийтэд ил тод болгох мэдээллийг тухай бурд Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлж байхаар зохицуулж болно.

Судлаачийн санал

49.3. Уг бүлгийн зохицуулалт нь Хөрөнгийн биржид бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчит хувьцаат компанийд үйлчлэхгүй бөгөөд эдгээр компани нь үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжоор нийтэд нээлттэй болгохоор заасан мэдээллийг тухайн бурд Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

Мөн нээлттэй ХК-ийн хувьд хувьцаагаа нийтэд худалдах замаар Хөрөнгийн биржийн бүртгэлд орсон тохиолдолд бусад компаниудтай нэгэн адил эрх зүйн орчны хүрээнд тэгш, шударгаар өрсөлдөх боломжоор хангагдах учиртай.

3.2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн бүрэн эрх

Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч гэдэг нь хувьцаа эзэмшигчийн эрхийг Засгийн газар, ИТХ зэрэг хувьцаа эзэмшигчийн өмнөөс төлөөлөн хэрэгжүүлэх Иргэний хуульд заасан төлөөлөгч юм. Энэ ч утгаараа, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьд чиг үүрэг бус, "төлөөлөх бүрэн эрх", түүний хүрээний асуудал яригдана.

Улмаар хуулийн төсөлд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн эдэлж болох бүрэн эрхийг тогтоож өгчээ. Гэсэн хэдий ч, хуулийн төслийн хүрээнд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна.

Нэгдүгээрт, Хуулийн төслийн 20.1-д "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаар төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ" хэмээн заажээ. Энэхүү хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн чиг үүрэг гэсэн нэр томьёо нь Иргэний

болон Компанийн хууль тогтоомжийн үүднээс авч үзвэл ойлгомжгүй байдлыг үүсгэхээр байна.

Хувьцаа эзэмшигч болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төлөөлүүлэгч болон төлөөлөгчийн харилцаанд байх тул Иргэний хуульд хэвшиж тогтсон “бүрэн эрх” хэмээн хууль зүйн нэр томьёог хэрэглэх нь зүйтэй. Улмаар төлөөлөх бүрэн эрхээ хэтрүүлсэн, урвуулан ашигласан зэрэг тохиолдолд Иргэний хуульд заасан хамгаалалын аргыг хэрэглэх боломж бүрдэнэ.

Судлаачийн санал

20.1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаар төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль нь захиргааны хууль тогтоомж бус, иргэний хууль тогтоомжид хамаарах буюу Компанийн тухай хуулийн тусгай хууль болно гэдгийг анхаарах шаардлагатай. Улангуяа, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн эрхийг компанийд хэрэгжүүлэх этгээд тул захиргааны байгууллагын “чиг үүрэг”-тэй ямар нэгэн хамаарал байхгүй хэмээн дүгнэж болно. Ингэснээр Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн холбогдох зохицуулалтыг Иргэний хууль, Компанийн тухай хуультай уялдуулан хэрэглэхэд хялбар болно.

Хоёрдугаарт, Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь 20.1.4-д заасан “төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд уг асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал хүргүүлэх”, 20.1.5-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирал хууль болон дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх саналаа төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Гэсэн хэдий ч, ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх захирал үүргээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, хариуцлага хүлээлгэх санал гаргах зохицуулалт нь ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл, Компанийн эрх зүйн үүднээс ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх захиралд хүлээлгэх хариуцлагын хувьд 1) компанийд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, 2) тухайн албан тушаалаас чөлөөлөх гэсэн хоёр төрлийн хариуцлага яригдах боломжтой.

Харин албан тушаалаас чөлөөлөх, чөлөөлөх саналыг хүргүүлэх асуудлыг хувьд хуулийн төслийн 20.1.2, 20.1.3-т тусгасан байх тул компанийд учирсан

хохирлыг нөхөн төлүүлэх хариуцлага хэмээн тодорхой хуульчлах нь зүйтэй байна. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхээс бие даасан байдлаар хэрэгжүүлэх боломж бүхий хувьцаа эзэмшигчийн эрхийн асуудал яригдах тул хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн бүрэн эрх байдлаар хуульчлах нь оновчтой.

Судлаачийн санал

20.1.4.төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд компанид учруулсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах, Компанийн тухай хуульд заасны дагуу шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах;

20.1.5.төрийн болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирал хууль болон дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд компанид учруулсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах, Компанийн тухай хуульд заасны дагуу шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах;

Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын чиг үүрэг

Хуулийн төслийн 21.1-т “Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын үйл ажиллагаа уялдуулан зохицуулах” чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Энэхүү “компанийн засаглалд оролцогч талууд” гэдэг нь компанийн засаглалын хүрээнд stakeholder буюу хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс эхлэн удирдлагын чиг үүрэг бүхий орган, шаардах эрх бүхий этгээд, бус нутаг зэргийг багтаасан өргөн агуулгыг илэрхийлнэ.

Иймээс Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын уялдуулан зохицуулах чиг үүргийг төрийн эзэмшлийн хувьцааны эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал сонгон шалгаруулах ажлын хэсэг, нөөц сангийн үйл ажиллагаагаар хязгаарлах нь зүйтэй.

Хуулийн төслийн заалт

21 дүгээр зүйл. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын чиг үүрэг

21.1. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Судлаачийн санал

21 дүгээр зүйл. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын чиг үүрэг

21.1. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал сонгон шалгаруулах ажлын хэсэг, нөөц сангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мөн Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийд төрийн эзэмшлийн хувийг төлөөлж буй ТУЗ-ийн гишүүн эсхүл гүйцэтгэх захиралд хяналт тавих этгээдийн хувьд тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлж болохоор зохицуулжээ. Үүнд ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, хариуцлага хүлээлгэх саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх асуудал хамаарна.

Гэсэн хэдий ч, эрх зүйн үр дагаварын хувьд компани болон ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал нь шууд хамааралтай болохыг анхаарах шаардлагатай. Харин хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь компанийн удирдлагын үйл ажиллагаанд гагцхүү хувьцаа эзэмшигчдын хурлаар дамжуулан оролцно. Мөн Компанийн тухай хуульд заасан дангаар болон бүлгээр хэрэгжүүлэх эрхийг компанийн өмнө эдэлж болно.

Иймээс эдгээр зүйл заалтын практикт хэрэгжилтийг тодорхой болгох үүднээс энэ хууль болон Компанийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх хэмээн өөрчлөн найруулах нь зохистой байна.

Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүн эсхүл гүйцэтгэх удирдлага нь компанийд хохирол учруулсан тохиолдолд хувьцаа эзэмшигч болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс авсан итгэмжлэлийн үндсэн дээр энэ хууль болон Компанийн тухай хуульд заасан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхийг тодотгох нь оновчтой.

Хуулийн төслийн заалт

21.2. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.2.4. ... хуульд заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, хариуцлага хүлээлгэх саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;

Судлаачийн санал

21.2. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.2.4. ... хуульд заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, энэ хууль болон Компанийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;

21.2.5. Хувьцаа эзэмшигч болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс авсан итгэмжлэлийн үндсэн дээр энэ хууль болон Компанийн тухай хуульд заасан нэхэмжлэлийг шуухэд гаргах

Хувьцаа эзэмшигч ба хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн эрх

Хуулийн төсөлд төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрийн эзэмшлийн хувийг Засгийн газар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг ИТХ эзэмшихээр зохицуулсан байна. Харин төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Засгийн газрыг төлөөлж, тодорхой этгээд дангаар, орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг ИТХ-ыг төлөөлж, Засаг дарга хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

Гэсэн хэдий ч, хувьцаа эзэмшигчийн эрх нь нийтлэг байдлаар компанийн тухай хуулиар зохицуулагдана. Улмаар хуулийн төслийн практик хэрэгжилтийг ойлгомжтой болгож, Компанийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах үүднээс хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь Компанийн хууль болон төрийн өмчит компанид хамаарах тусгай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн удирдлагын эрх, мэдээлэл авах эрх, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хэрэгжүүлэх асуудлыг тодорхой тусгах нь зүйтэй.

Хуулийн төслийн заалт

20.1.7. хуульд заасан бусад.

Судлаачийн санал

20.1.7. хуульд заасан хувьцаа эзэмшигчийн эрх.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Хуулийн төслийн 24.4.-д Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь есөн гишүүнтэй байна”, 24.6.-д “Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь мэргэжлийн хараат бус гишүүн байна” хэмээн заажээ. Мөн 24.7-т “Энэ хуулийн 37.6-д заасан шалгуураас доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл таваас илүүгүй сондгой тооны гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр хүртэлх гишүүн нь төрийн захиргааны байгууллагын төлөөлөл байж болно” хэмээн зохицуулжээ.

Гэсэн хэдий ч, 23.2.-д “Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 82.1-д заасан хороодтой байх бөгөөд хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байна” хэмээн зохицуулсан байна.

Улмаар хуулийн төслийн 24.7-т заасны дагуу төрийн захиргааны байгууллагын төлөөлөл 2 байх тохиолдолд 5 гишүүн бүхий ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТУЗ-ийн бүх хороод харьялагдах нөхцөлийг бүрдүүлж, ачаалал үүсгэхээр байна. Мөн 3 гишүүн бүхий ТУЗ-ийн хувьд хуулийн төслийн 23.2-т заасан шаардлагыг хангах боломжгүй болно. ТУЗ нь 5 болон түүнээс доош гишүүнээс бүрдэх тохиолдолд хороод байгуулах замаар бүрэн эрхийг хуваарилахаас илүүтэйгээр ТУЗ-ийн бүтцэд анхаарах нь зохистой байдаг.

Иймээс 3 гишүүн бүхий ТУЗ-ийн дэргэд хороод байгуулахгүй байх, 5 гишүүн бүхий ТУЗ нь сайн дурын байдлаар байгуулах зохицуулалтыг тусгах нь зүйтэй. Харин хуулийн төслийн 24.7-т заасны дагуу ТУЗ дэх төрийн захиргааны байгууллагын төлөөлөл 2 байх тохиолдолд ТУЗ-ийн бие даасан байдлын асуудал хөндөгдөх тул төрийн захиргааны байгууллагын төлөөллийн тоо 1 илүүгүй байхаар зохицуулах шаардлагатай.

Хуулийн төслийн заалт

23 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

23.2. Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 82.1-д заасан хороодтой байх бөгөөд хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байна.

Судлаачийн санал

23 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

23.2. Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 81.2-д заасан хороодтой байх бөгөөд хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байна.

23.3. Төлөөлөн удирдах зөвлөл таван гишүүнтэй бол Компанийн тухай хуулийн ...-д заасан хороодыг сайн дураар байгуулах бол гурван гишүүнтэй бол хороод байгуулахгүй.

24.7. Энэ хуулийн 37.6-д заасан шалгуураас доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл таваас илүүгүй сондгой тооны гишүүнтэй байх бөгөөд төрийн захиргааны байгууллагын төлөөлөл 1-ээс илүүгүй байна.

Мөн Компанийн тухай хуулийн эш татсан заалт нь 82.1 бус, 81.2 байх тул өөрчлөх замаар хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

3.3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Ойлгомжтой байдлын сайжруулах хүрээнд найруулгын болон тогтсон нэр томьёог хадгалах, Компанийн хууль тогтоомжтой уялдуулахад анхаарсан болно. Үүнд дараах зүйл заалтууд хамаарна /*хүснэгтэд шинэ томьёоллыг тайлбарын хамт тусгасан болно/*.

№	Хуулийн зүйл заалт	Тайлбар
1	<p>3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>3.1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ</p> <p><u>3.1. Энэ хуульд тусгайлан зааснаас бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.</u></p> <p><u>3.2. Энэ хуульд тусгайлан зааснаас бусад өмчийн харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.</u></p>	Хуулийн үйлчлэх хүрээ нь хууль хэрэглээний эрэмбийг зохицуулахад чиглэсэн тул ерөнхий болон тусгай хуулийн харилцаанд төвлөрч тодотгох шаардлагатай.
2	<p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>4.1.1. "төрийн өмчит компани" гэж төр хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл хяналтын эрхийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг;</p> <p>4.1.2. "орон нутгийн өмчит компани" гэж орон нутаг хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл хяналтын эрхийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг;</p> <p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>4.1.1. "төрийн өмчит компани" гэж төр хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл <u>хяналтын багцыг эзэмшиж</u> байгаа хуулийн этгээдийг;</p> <p>4.1.2. "орон нутгийн өмчит компани" гэж орон нутаг хувьцааг нь эзэмшиж байгаа, эсхүл <u>хяналтын багцыг эзэмшиж</u> байгаа хуулийн этгээдийг;</p>	Ерөнхий хууль болох Компанийн тухай хууль нь хяналтын багц гэдэг нэр томьёог хэрэглэсэн. Мөн компанийн эрх зүйд "хяналтын эрх" гэсэн бие даасан ойлголт байхгүй болно.
3	<p>6 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрөл, хэлбэр</p> <p>6.1. Төрийн болон орон нутгийн өмчит компани нь хувьцааны эзэмшлээс хамаарч дараах төрөлтэй байна:</p> <p>6 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн <u>ангилал</u></p> <p>6.1. Төрийн болон орон нутгийн өмчит <u>компанийг</u> хувьцааны эзэмшлээр нь дараах байдлаар ангилна:</p>	Компанийн хэлбэр, төрөл гэдэг нь Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн дагуу тогтсон томьёолол тул

		өөр агуулга илэрхийлэх тохиололд “ангилал” гэсэн томьёоллыг ашиглах. Мөн өмчийн хэлбэр нь компанийн хэлбэр, төрөлд хамаарахгүй.
4	8.4.Энэ хуулийн 8.1.4-т заасан үндэслэлээр үйл ажиллагаа явуулах компани нь төрийн өмчийн компани байна. 8.4.Энэ хуулийн 8.1.4-т заасан <u>үйл ажиллагааг зөвхөн төрийн өмчийн компани явуулна.</u>	Найруулгыг засах
5	10 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн дүрэм 10.1.Засгийн газар төрийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийн хамт компанийн дүрмийг батална. 10.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийн хамт компанийн дүрмийг батална. 10 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн дүрэм 10.1.Засгийн газар төрийн өмчийн компани үүсгэн байгуулах <u>шийдвэрийг гаргахдаа компанийн дүрмийг хэлцэж шийдвэрлэнэ.</u> 10.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах <u>шийдвэрийг гаргахдаа компанийн дүрмийг хэлэлцэж шийдвэрлэнэ.</u>	Найруулгыг зассанаас гадна Компанийн тухай хуулийн томьёололтой уялдуулав.
6	13 дугаар зүйл.Алтан хувьцаа 13.1.Засгийн газар төрийн өмчит компанийн төрд ногдох хувьцааг бүхэлд нь худалдах тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй алтан хувьцааг гаргахаар зааж болно. 13 дугаар зүйл.Алтан хувьцаа 13.1. Засгийн газар төрийн өмчит компанийн хувьцааг бүхэлд нь <u>хариу төлбөртэйгээр шилжүүлэх тухай</u>	Найруулгыг зассанаас гадна худалдахаас бусад арилжих зэрэг “хариу төлбөртэй шилжүүлэх” аргыг багтаасан болно.

	<u>шийдвэрийг гаргахдаа тодорхой хугацаанд алтан хувьцаа эзэмшихээр зааж болно.</u>	
	29.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хууль, Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид энэ тухай нотлох баримтын хамт бичгээр мэдэгдэл хүргүүлж, холбогдох арга хэмжээ авна.	Хэрэгжүүлэх субъект нь тодорхой бус байх тул тодотгож оруулав.
	29.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хууль, Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн <u>тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга</u> хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид энэ тухай нотлох баримтын хамт бичгээр мэдэгдэл хүргүүлж, холбогдох арга хэмжээ авна.	

3.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусад нь нарийвчлан заасан байна. Энэ нь өнөөг хүртэлх олон нийт, иргэдийн зүгээс төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаарх шүүмжлэл дагуулсан олон асуудлыг шийдвэрлэх зорилготой болох нь хуулийн төсөл болон түүний үзэл баримтлалаас тодорхой харагдаж байна.

5.1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:
5.1.1. хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх;
5.1.2. монополь, эсхүл давамгай байдлаа урвуулан ашиглахгүй байх;
5.1.3. бусад аж ахуйн нэгжээс давуу эрх эдлэхгүй байх;
5.1.4. компанийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;
5.1.5. улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх;
5.1.6. компани төрийн болон орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх;
5.1.7. санхүүгийн үр ашигтай байх;
5.1.8. ил тод, нээлттэй байх.
5.2. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд энэ хуулийн 5.1-д зааснаас гадна дараах зарчмыг баримтална:
5.2.1. Засгийн газрын бүрэн эрх, орон нутгийн эрх хэмжээ компанийн удирдлагын бүрэн эрхээс тусгаарлагдсан байх;

- 5.2.2.компанийн бүх хувьцаа эзэмшигч эрх тэгш байх;
- 5.2.3.хараат бус хөндлөнгийн хяналттай байх;
- 5.2.4.мэргэжлийн байх;
- 5.2.5.үр ашиггүй зардал гаргахгүй байх;
- 5.2.6.санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллах;
- 5.2.7.хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх.

Өөрөөр хэлбэл, төрийн болон орон нутгийн өмчит компани нь үйл ажиллагаа явуулах, түүний удирдлагыг хэрэгжүүлэхдээ дээрх зарчмуудыг мөрдлөг болгон ажиллах үүрэгтэй. Харин эдгээр зарчмууд нь бодитоор хэрэгжихийн тулд тухайн зарчмуудыг амилуулах процессын зохицуулалтыг зайлшгүй тусгах шаардлагатай. Тиймээс дээрх зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тус хуулийн төслийн бусад хэсгүүдэд хэрхэн зохицуулсан, тэдгээрийн харилцан хамаарлыг тодорхойлох учиртай.

Нэгдүгээрт, хуулийн төслийн 5.1.1-д “хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх” гэсэн зарчим нь төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаандaa мөрдлөг болгох зарчимд нийцэхгүй байна. Учир нь тус хуулийн төслийн үзэл баримтлалд төрийн өмчит компаниуд нь үр ашиггүй зардал ихээр гаргадаг, санхүүгийн сахилга батгүй гээд тэгдээрийг зайлшгүй засаж сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн.⁸ Өөрөөр хэлбэл, үр ашиггүй ажилладаг төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулахгүй бөгөөд төрийн болон орон нутгийн өмчит компани нь “санхүүгийн үр ашигтай байх” зарчмыг хуулийн төслийн 5.1.7-д тусгасан нь компани нь төрийн өмчийн болон орон нутгийн өмчит байхаас үл хамаараад “ашгийн төлөөх зорилго”-ыг хангахад чигэлсэн үндсэн зарчим юм.

Иймд 5.1.1-д “хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх” зарчим нь үйл ажиллагаанд мөрдлөг болгох зарчим бус анхнаасаа төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах эсэхтэй холбоотой зарчим болно. Энэ утгаараа хуулийн төслийн 8.1.1-д “хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй зах зээлд оролцох” үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулах талаар зохицуулсан. Тиймээс 5.1.1-д “хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх” заалтыг хуулийн төслөөс хасах нь зүйтэй бөгөөд хувийн хэвшилтэй өрсөлдөхгүйгээр санхүү, эдийн засгийн хувьд ашигтай ажиллаж, компанийн ашгийн төлөөх үндсэн зорилготой⁹ зөрчилдөж байна.

⁸ Хуулийн төслийн үзэл баримтлал 3-4 тал.

⁹ Иргэний хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д компанийн тодорхойлолтыг заасан бөгөөд компанийн үндсэн шинж нь 1.хувьцаа эзэмшигчтэй байх, 2. Оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагддаг байх, 3. Төрийн тусгайлсан эд хөрөнгөтэй байх, 4. Ашгийн төлөө үндсэн зорилготой байх ёстай. Өөрөөр хэлбэл, компани нь төрийн болон орон нутгийн өмчийн байх, оролцоотой байх эсэхээс үл хамаарч компани гэх хуулийн этгээдийн төрөл учир зайлшгүй ашгийн төлөөх зорилготой байхыг шаардана.

Хоёрдугаарт, Хуулийн төслийн 5.1.2-т “монополь, эсхүл давамгай байдлаа урвуулан ашиглахгүй байх” зарчим нь Өрсөлдөөний тухай хуульд¹⁰ заасны дагуу угаас хууль бус үйлдэл юм. Тодруулбал, Өрсөлдөөний тухай хуулийн 6 дугаар зүйл “Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах”, 7 дугаар зүйл “Давамгай байдлаа хууль бусаар ашиглах”-ыг хориглох тохиолдлууд, 12 дугаар зүйл “Өрсөлдөөний хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа”-нд хамаарах үйлдлүүдийг тодорхой заасан. Иймд төрийн болон орон нутгийн өмчит байхаас үл хамаарч бүх төрийн аж ахуй эрхлэгчид нэгэн адил ногдох үүрэг бөгөөд үүнд төрийн эрх бүхий байгууллагын зүгээс чөлөөт өрсөлдөөнийг хангах чиглэлээр хяналт тавьж ажилладаг. Тиймээс Хуулийн төслийн 5.1.2-т “монополь, эсхүл давамгай байдлаа урвуулан ашиглахгүй байх” зарчим нь нэгэнт хуулиар хориглогдсон үйл ажиллагаа боловч бодит хэрэгжилт хангалтгүй байгаа нөхцөлийг харгалзан үзвэл хүлээн зөвшөөрөгдхө боловжтой гэж дүгнэв.

Гуравдугаарт, Хуулийн төслийн 5.1.3 “бусад аж ахуйн нэгжээс давуу эрх эдлэхгүй байх” зарчим нь дээр дурдсанчлан Өрсөлдөөний тухай хуулиар төрийн захиргааны байгууллага болон нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох үйлдэл буюу тус хуулийн 13.2.7 “аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн” буюу хориглосон үйлдэлд хамаарах юм. Тиймээс хуулийн төслийн 5.1.2, 5.1.3 дахь заалтууд нь зарчим гэхээс илүүтэй хуулиар хориглосон үйлдлүүд юм. Иймд судлаачийн зүгээс дээрх 5.1.1-5.1.3 заасан зарчмуудыг нийлүүлээд дараах байдлаар тусгах нь оновчтой гэж дүгнэв.

Хуулийн төслийн заалт
5.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: <ul style="list-style-type: none">5.1.1.хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх;5.1.2.монополь, эсхүл давамгай байдлаа урвуулан ашиглахгүй байх;5.1.3.бусад аж ахуйн нэгжээс давуу эрх эдлэхгүй байх;
Судлаачийн санал
5.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: <ul style="list-style-type: none">5.1.1.хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх;5.1.2.мөнөөяль, эсхүл давамгай байдлаа урвуулан ашиглахгүй байх;5.1.3.бусад аж ахуйн нэгжээс давуу эрх эдлэхгүй байх; <p>5.1.1. Зах зээлд шудрагаар өрсөлдөх, аливаа хэлбэрээр давуу эрх эдлэхгүй байх;</p>

¹⁰ Өрсөлдөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2010 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

Дөрөвдүгээрт, Хуулийн төслийн 5.1.4 “компанийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх”, 5.1.5 “компани улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх” зарчмууд нь утгаа төрийн болон орон нутгийн өмчит компанийг цэвэр бизнесийн зарчмаар ажиллуулах замаар ашгийн төлөөх зорилгыг хангах, аливаа улс төрч, гуравдагч этгээд нь компанийн шийдвэр гаргалт, үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байхад чиглэсэн нэг зорилго бүхий зарчмууд юм. Тиймээс дээрх зарчмуудыг хууль хэмнэлттэй бөгөөд ойлгомжтой байх зарчмын дагуу дараах байдлаар нэгтгэх боломжтой.

Хуулийн төслийн заалт

5.1.4.компанийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;

5.1.5.улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх;

Судлаачийн санал

5.1.2.Компанийн удирдлага, үйл ажиллагаа улс төрийн болон хөндлөнгийн нөлөөлөөс ангид, бие даасан байх;

Тавдугаарт, Хуулийн төслийн 5.1.6 “компани төрийн болон орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх”, 5.1.7 “санхүүгийн үр ашигтай байх”, 5.1.8 “ил тод, нээлттэй байх” зарчмууд нь төрийн болон орон нутгийн өмчит компанийг үр ашигтай ажиллуулах, олон нийтийг мэдээллээр хангах замаар хяналтыг сайжруулах нэн чухал зарчмууд бөгөөд хуулийн төслийн бусад хэсгүүдэд холбогдох зохицуулалтыг тусгасан нь тухайн зарчмууд бодитоор хэрэгжих, хүлээн зөвшөөрөгдөх боломжтой гэж дүгнэж байна.

Зургадугаарт, Хуулийн төслийн 5.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим”-г 5.1-д заасан зарчмуудаас тусад нь тусгасан. Үүнээс 5.2.2-т “компанийн бүх хувьцаа эзэмшигч эрх тэгш байх” буюу хувьцаа эзэмшигчийн тэгш эрхийн зарчим (principle of shareholder equality)-г манай улсын Компанийн эрх зүйд хэм хэмжээний төвшинд тусгасан байна. Өөрөөр хэлбэл, онолын хувьд хувьцаа эзэмшигчийн тэгш эрхийн зарчим нь бүх хувьцаа эзэмшигч эзэмшиж буй хувьцааны хэмжээнээс үл хамаарч саналын тэгш эрхтэй гэсэн утга бус тухайн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны тоо, төрөлдөө тохирсон буюу эрх тэгш байна гэж тайлбрлаж ойлгох нь зүйтэй.¹¹ Өөрөөр

¹¹ Энэ талаар Япон улсын Компанийн тухай хуулийн 109.1-д “Хувьцаат компани нь түүний хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоо хэмжээ, төрөлд нийцүүлэн тэгш байдлаар хандана” гэж заасан бөгөөд ингэхдээ хувьцааны тоо хэмжээ, төрөл гэдгийг тодорхойлон заасан нь бүх хувьцаа эзэмшигчийн хувьцааны эзэмшлээс үл хамаарч тэгш хандах бус хувьцаа эзэмшигч болохынх нь хувьд тэгш хандах гэх агуулгаар тайлбарлах шаардлагатай талаар судлаачид дүгнэсэн байдаг. 村田敏一「株主平等原則と株主権の動態」（2021、法律文化社）p.3

хэлбэл, төр өөрөө компанийн хувьцаа эзэмшигч болохын хувьд компанийн сайн засаглалыг хөгжүүлэх үүднээс төр болон аж ахуйн нэгжүүд бүх хувьцаа эзэмшигчид, тэр дундаа цөөнх болон гадаадын хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүлээн зөвшөөрч, хувьцаа эзэмшигчидтэй тэгш харьцаж, компанийн мэдээлэлд тэгш хүртээмжтэй хандах ёстай. Энэ талаар OECD-ийн Компанийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг тулд 1. Төр болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах ёстай, 2. ТӨХК нь ижил, нэгэн зэрэг ил тод байдлыг хангаж бүх хувьцаа эзэмшигчдэд хамгийн сүүлийн үеийн мэдээллийг ил тод болгох, 3. ТӨХК нь бүх хувьцаа эзэмшигчидтэй харилцах, зөвшилцөх идэвхтэй бодлого боловсруулах ёстай, 4. Цөөнх хувьцаа эзэмшигчдийг оролцуулан удирдах зөвлөлийг сонгох зэрэг компанийн үндсэн шийдвэрт оролцох боломжийг олгох, санал өгөх болон бусад эрхээ хэрэгжүүлэх оролцоо, оролцоог хувь нийлүүлэгчдийн зардлыг хөнгөвчлөх, бууруулах арга хэрэгсэл болгон хууль эрх зүйн хүрээнд зөвшөөрсөн байх ёстай, 5. Төр болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хоорондын гүйлгээ нь зах зээлд нийцсэн нөхцөлөөр явагдах ёстай гэсэн зарчмуудыг тогтоосон¹². Үүнээс энхий зарчим болох төр болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах ёстай гэсэн зарчимтай хуулийн зохицуулалт нийцэж байна.

Ялангуяа, хуулийн төсөлд заасан нэр томьёогоор хэлбэл, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд Засгийн газар, ИТХ хувьцаа эзэмшигч болсон гэдэг утгаараа бусад ердийн хувьцаа эзэмшигчээс давуу эрх эдлэхгүй, өөрийн эзэмшиж буй хувьцааны тоо, төрөлдөө тохирсон санал өгч, шийдвэр гаргах ажиллагаанд оролцох болохыг тодотгож өгснөөрөө давуу талтай.

Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэл

Тус хуулийн төслийн 7 дугаар зүйлд Засгийн газрын зүгээс төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэл баталж хэрэгжүүлэх, тайлагнах тухай зохицуулжээ. Хуулийн төслийн 7.1-д “Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийг баталж, Улсын Их Хуралд танилцуулна”, 7.5-д “Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газарт хүргүүлэх”-ээр, мөн 7.6-д “Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлсэн энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг Улсын Их Хурлын төсвийн болон эдийн засгийн асуудал эрхэлсэн Байнгын хороонд хүргүүлж танилцуулна.” гэж заасан.

¹² Энэ талаар Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын 2024 оны “Төрийн өмчит компанийн засаглалын удирдамж”-н 4 дэх хэсэгт тодорхой заасан байдаг. OECD (2024), *OECD Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises 2024*, p.18, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/18a24f43-en>.

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын зүгээс төрийн өмчит компанийн талаар үндсэн чиглэлээ тогтоож, түүнийг хэрэгжилтийг хангаж, Улсын Их хуралд тайлагнах нь зүй ёсны хэрэг юм. Гэвч хуулийн төслийн 7.6-д зааснаас үзвэл Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлсэн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг УИХ-д хүргүүлж танилцуулах тухай боловч ямар хугацаанд буюу тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлоогүй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна”, 40.2-т “Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно” гэж заасан. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын 4 жилийн бүрэн эрхийн хугацааны дотор шинэ Ерөнхий сайд томилогдох тохиолдолд хэдэн ч удаа Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, шинэ Засгийн газар байгуулагдах боломжтой. Тиймээс хуулийн төслийн 7.6-д заасан зохицуулалтыг Үндсэн хуулийн 40.1-д заасан утгаар тайлбарлавал зөвхөн дөрвөн жилд 1 удаа үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг УИХ-д хүргүүлж танилцуулахаар ойлгогдох тул нэгэнт хуулийн төслийн 7.5-д төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр тус үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үнэлгээ хийж байгаа тул жил бүр УИХ болон холбогдох байнгын хороодод хүргүүлж танилцуулдаг байхаар тодорхой болгох нь зүйтэй.

Хуулийн төслийн заалт

7 дугаар зүйл. Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэл
7.5. Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газар,
7.6. Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлсэн энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг Улсын Их Хурлын төсвийн болон эдийн засгийн асуудал эрхэлсэн Байнгын хороонд хүргүүлж танилцуулна.
7.7. Үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн тайланг Засгийн газар болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулна.

Судлаачийн санал

7 дугаар зүйл. Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэл
7.5. Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газарт хүргүүлж танилцуулна.
7.6. Засгийн газар жил бүр энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг Улсын Их Хурлын төсвийн болон эдийн засгийн асуудал эрхэлсэн Байнгын хороонд хүргүүлж танилцуулна.
7.7. Үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн жил бурийн тайланг Засгийн газар болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулна.

Үнэт цаас гаргах, зээл авах

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд төрийн болон орон нутгийн өмчит компани үнэт цаас гаргах, зээл авах талаар зохицуулсан. Ингэхдээ 15.1-д “Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу үнэт цаас гаргана.” гэж заасан нь одоогийн хучин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн¹³ 21 дүгээр зүйлийн 21.16-д “Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана.” гэсэн зарчмыг хадгалж, ийнхүү үнэт цаас гаргахдаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлахыг тодотгосон нь оновчтой байна.

Тодруулбал, хуулийн төслийн 6 дугаар зүйлд төр болон орон нутаг нийт гаргасан хувьцааг нь дангаар эзэмшдэг төрийн болон орон нутгийн өмчийн компани, төр болон орон нутаг компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 34-өөс дээш хувийг эзэмшдэг боловч бусад хувьцаа эзэмшигчийн оролцоо бүхий төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн ангиллыг тусгасан нь компани үнэт цаас гаргах тухай шийдвэрийг тухайн компанийн ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэдэг байх Компанийн тухай хуулийн зохицуулалтыг дагаж мөрдөх учиртай. Иймд хэдийгээр төрийн болон орон нутгийн өмчит компани нь үнэт цаас гаргах тухай зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллагаас авах ч эцсийн шийдвэрийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргах учир хүлээн зөвшөөрөгдөх боломжтой зохицуулалт гэж үзнэ.

15 дугаар зүйл. Үнэт цаас гаргах, зээл авах

- 15.1. Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу үнэт цаас гаргана.
- 15.2. Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн

¹³ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр урт хугацааны зээл авч болно.

15.3. Гүйцэтгэх захирал зээлийн гэрээний дагуу төлбөл зохих хуваарь болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг төлж барагдуулах төлөвлөгөө, хуваарийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан төлөөлөн удирдах зөвлөлд, төлөөлөн удирдах зөвлөл байхгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн онцлог нь тухайн компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлсон байна. Хуулийн төслийн үзэл баримтлалын 1-д “....төрийн бодлогыг уялдуулах нэрийн дор төрийн өмчит компанийн бизнесийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж оролцох, төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага олон улсад тогтсон шаардлагаас доогуур, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь төрийн захиргааны албан хаагч байх болзлыг хуульчилсантай холбогдуулан төрийн захиргааны албан хаагч, улс төрийн албан тушаал хашиж байсан этгээдийг төлөөлөн удирдах зөвлөлд томилох, томилуулахаар нэр дэвшигчийг байгаа нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг мэргэжлийн бус болгож, компанийн сайн засаглалын тогтолцоо бүрдэх нөхцөлийг хааж байна” гэдгийг тодотгож төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, компанийн удирдлага мэргэжлийн байх зарчмыг баримталж байгаагаас харж болно. Тиймээс хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн зохицуулалт нь зүй ёсны шаардлага болно. Гэвч тухайн шаардлагуудаас нэр томьёо оновчгүй, утга найруулгыг засах шаардлагатай байгаа хэсгүүдэд дүгнэлт хийе.

Нэгдүгээрт, хуулийн төслийн 24.1.4-т “эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болж дампуурсан нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон”, 24.1.5 “эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгосон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон” гэсэн шаардлагыг тогтоосон. Тухайн заалтуудыг нарийвчлан үзвэл, хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болж дампуурах үйлдэл нь Эрүүгийн хуулийн 18.10 дугаар зүйл “Зориуд, зохиомлоор дампуурах”, 18.11 дүгээр зүйлд заасан “Хууль бусаар дампууруулах” гэмт хэргээс бусад тохиолдолд иргэний эрх зүйн харилцаа бөгөөд тухайн хуулийн этгээд дампуурах болсон шалтгаан нөхцөлийг дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бүрэн тогтоох хүндрэлтэй

байдаг. Үүнтэй адил хуулийн төслийн 24.1.5-д заасан эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээдийн ААН үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл цуцлагдсан нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон гэдийг шүүхийн шийдвэрийг үндэслэх үү, эсхүл нэр дэвшигч ямар нэгэн хэлбэрээр өөрийн гэм буруугүй гэдгийг нотлох уу гэдэг төвөгтэй асуудал үүснэ.

Нэгтгэвэл, 24.1.4-т заасан үндэслэл болох ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч урьд нь эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан нь өөрөөс шалтгаалаагүй, 24.1.5-д заасан тусгай зөвшөөрөл цуцлагдсан нь өөрөөс нь шалтгаалаагүй болохыг нотолсон нотлох баримтыг гаргаж өгөхдөө өөрийн гэм буруугүй нь нотолсон шүүхийн шийдвэр, холбогдох байгууллагын лавлагааг гаргаж өгөх үү, одоогийн хууль эрх зүйн орчны хүрээнд энэ төрлийн нотлох баримтыг хэн, ямар байгууллага гаргаж өгдөг нь тодорхой эсэх зэрэг асуудлууд үүснэ. Иймд хуулийн төслийн доорх заалтуудыг өөрчлөн найруулж, нэтгэх нь зүйтэй гэж үзэв.

Хуулийн төслийн заалт

24 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага

24.1.4.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болж дампуурсан нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

24.1.5.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгосон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

Судлаачийн санал

24 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага

24.1.4. тухайн нэр дэвшигч нь эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болж дампуурсан, эсхүл аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болсон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй байх;

24.1.5.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй бөягсөн нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

Хоёрдугаарт, хуулийн төслийн 24.1.3 “сүүлийн хоёр жил улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байгаагүй, эсхүл улс төрийн албан тушаал хашдаггүй байх” шаардлагыг тусгасан. Хууль зүйн техникийн үүднээс үзвэл “эсхүл” гэх холбоос нь ижил төвшний 2 нөхцөлийн аль нэгийг нь хангах буюу хоёр нөхцөл зэрэг хангагдахгүй байх утгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, 24.1.3-т заасан шаардлага нь төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь

сүүлийн хоёр жил улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байсан боловч улс төрийн албан тушаал хашдаггүй бол нэр дэвших боломжтой, эсэргээрээ улс төрийн албан тушаал хашдаг боловч сүүлийн хоёр жил улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байгаагүй бол нэр дэвших боломжтой гэсэн утгыг илрэхийлнэ. Гэтэл тус нөхцөлүүдийн аль аль нь төрийн болон орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах зүй ёсны шаардлага тул аль аль нөхцөлийг зэрэг хангасан байхаар өөрчлөн найруулах нь зүйтэй. Мөн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хуулийн¹⁴ 10 дугаар зүйлд төрийн албан тушаалыг “улс төрийн албан тушаал” бус “төрийн улс төрийн албан тушаал” гэж тодорхойлсон тул Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн “төрийн улс төрийн албан тушаал” гэж өөрчлөх нь зүйтэй.

Хуулийн төслийн заалт

24 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага

24.1.3. сүүлийн хоёр жил улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байгаагүй, эсхүл улс төрийн албан тушаал хашдаггүй байх;

Судлаачийн санал

24 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага

24.1.3. сүүлийн хоёр жил улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байгаагүй;

24.1.4. төрийн улс төрийн албан тушаал хашдаггүй байх;

3.5. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

1. Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

Энэ хуулиар төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журмыг тогтоох, компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлага зохион байгуулалт, хяналт, ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна. Энэ хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь авч үзвэл хуулийн зорилттой нийцэх боловч хуулийн төслийн 5 дугаар зүйлд заасан зарим зарчмууд

¹⁴ Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

нь компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим биш байх тул тэдгээрийг засаж сайжруулах шаардлагатай. Энэ талаарх дэлгэрэнгүйг 3.4 “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” хэсгийг үзэх.

2. Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;

Хуулийн төслийн 2.1-д “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ” гэж заасан ба тухайн хуулиуд нь бүгд тус хуулийн харилцаанд хамаарах хуулиуд мөн болно.

3. Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;

Хуулийн төсөл болон хуулийн төслийг дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсглийг шалгаж үзэхэд зарим нэр томьёо нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн нэр томьёотой нийцүүлэх шаардлагатай байна. Тус зохицуулалтуудыг дараах хүснэгтээр нэгтгэв.

№	Хуулийн зүйл заалт	Тайлбар
1	<p>6.1.1.компанийн гаргасан бүх энгийн хувьцааг төр дангаараа эзэмшдэг бол төрийн өмчийн компани, эсхүл энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг эзэмшдэг бол төрийн өмчийн оролцоотой компани;</p> <p>6.1.2.компанийн гаргасан бүх энгийн хувьцааг орон нутаг дангаараа эзэмшдэг бол орон нутгийн өмчийн компани, эсхүл энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг эзэмшдэг бол орон нутгийн өмчийн оролцоотой компани.</p> <p>6.1.1.компанийн <u>нийт</u> гаргасан бүх энгийн хувьцааг <u>бүхэлд нь</u> төр дангаараа эзэмшдэг бол төрийн өмчийн компани, <u>эсхүл-нийт гаргасан</u> энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг эзэмшдэг бол төрийн өмчийн оролцоотой компани;</p> <p>6.1.2.компанийн <u>нийт</u> гаргасан бүх энгийн хувьцааг <u>бүхэлд нь</u> орон нутаг дангаараа эзэмшдэг бол орон нутгийн өмчийн компани,</p>	KтХ-ийн 6.1-д хэрэглэсэн нэр томьёотой нийцүүлж, найруулгыг засав.

	эсжүя <u>нийт гаргасан</u> энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг эзэмшдэг бол орон нутгийн өмчийн оролцоотой компани.	
2	<p>7.2. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газрын гишүүдийн саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.8-д заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.</p> <p>7.2. Төрийн өмчийн <u>бодлого, зохицуулалтын</u> асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газрын гишүүдийн саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.8-д заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.</p>	Хуулийн төслийн 7.2, 7.5, 17.2, 21.1, 21.2, 25.3, 25.4, 27.1, 30.8, 39.3, 40.7, 42.3, 46.2, 47.6, 47.7 дугаар заалтуудад “төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэсэн нэр томьёог ашигласан бөгөөд тус хуулийг дагалдан өөрчлөлт оруулах хуулийн төслөөс “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-д оруулах өөрчлөлтөд ямар нэгэн нэр томьёоны өөрчлөлт оруулахаар тусгаагүй байна. Иймд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэсэн нэр томьёонд нийцүүлэн дээрх зүйлүүдийг өөрчлөх шаардлагатай.
3	<p>44 дүгээр зүйл. Нэмэлт хувьцаа гаргаж, үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох</p> <p>44.1. Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана.</p>	Компанийн тухай хуульд “нэмэлт хувьцаа гаргах” гэсэн нэр томьёог ашигладаггүй бөгөөд тус хуулийн 38 дугаар зүйл, 62 дугаар зүйл болон холбогдох хэсгүүдэд “нэмж хувьцаа гаргах”, “хувьцаа

	<p>44.2.Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.</p> <p>44.3.Дараах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчит компани нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгоно:</p> <p>44.3.1.компани үйлдвэрлэлээ өргөжүүлэх, техник технологийн шинэчлэл хийх, компанийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт татах;</p> <p>44.3.2.компанийн засаглалыг сайжруулах;</p> <p>44.3.3.зах зээл дэх төрийн оролцоог багасгах;</p> <p>44.3.4.компанийн дүрэмд заасан бусад.</p> <p>44.4.Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгоход шаардлагатай зардлыг тухайн компанийн төсөвт тусган санхүүжүүлнэ.</p>	<p>нэмж гаргах" гэсэн нэр томьёог ашигладаг тул тус нэр томьёотой нийцүүлж, найруулгыг засав.</p>
	<p>44 дүгээр зүйл.Нэмэлт хувьцаа гаргах, үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох</p> <p>44.1. Нэмэлт Хувьцаа <u>нэмж</u> гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана.</p> <p>44.2.Нэмэлт Хувьцаа <u>нэмж</u> гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, <u>Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлана.</u> ы-дагуу хэрэгжүүлнэ.</p> <p>44.3.Дараах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчит компани нэмэлт хувьцаа <u>нэмж</u> гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгоно:</p> <p>44.3.1.компани үйлдвэрлэлээ өргөжүүлэх, техник технологийн шинэчлэл хийх, компанийн</p>	

	<p>өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт татах;</p> <p>44.3.2.компанийн засаглалыг сайжруулах;</p> <p>44.3.3.зах зээл дэх төрийн оролцоог багасгах;</p> <p>44.3.4.компанийн дүрэмд заасан бусад.</p> <p>44.4.Нэмэлт Хувьцаа <u>нэмж</u> гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгоход шаардлагатай зардлыг тухайн компанийн төсөвт тусган санхүүжүүлнэ.</p>	
4	<p>49 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдал</p> <p>49.1.Төрийн өмчит компани Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ:</p> <p>49.1.1.хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;</p> <p>49.1.2.хуулийн этгээдийн зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ, биет, биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;</p> <p>49.1.3.хуулийн этгээдийн сүүлийн таван жилд хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;</p> <p>49.1.4.хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;</p> <p>49.1.5.хуулийн этгээдийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;</p> <p>49.1.6.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гэрээ, түүний гүйцэтгэлийг дүгнэсэн мэдээлэл,</p>	<p>Тус зүйлийн гарчиг нь “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдал” бөгөөд нэгэн төрийн болон орон нутгийн өмчит компани гэх субъектийг тодорхойлсон учир “хуулийн этгээд” гэх нэр томьёог хэрэглэх нь ойлгомжгүй байна. Тиймээс шууд субъектийг тодорхой заасан гарчигт нийцүүлж “компани” гэсэн нэр томьёонд нийцүүлэв.</p>

гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;

49.1.7.хуулийн этгээдийн эсрэг, эсхүл хуулийн этгээдтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;

49.1.8.хуулийн этгээдийн дүрэм, хуулийн этгээдийн үйл ажиллагааны болон засаглалын дотоод журам;

49 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдал

49.1.Төрийн өмчит компани Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бурд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ:

49.1.1.хуулийн этгээдийн компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;

49.1.2.хуулийн этгээдийн компанийн зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ, биет, биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;

49.1.3.хуулийн этгээдийн компанийн сүүлийн таван жилд хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;

49.1.4.хуулийн этгээдийн компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;

49.1.5.хуулийн этгээдийн компанийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

49.1.6.хуулийн этгээдийн компанийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гэрээ, түүний гүйцэтгэлийг дүгнэсэн

	<p>мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;</p> <p>49.1.7.—хуулийн <u>этгээдийн компанийн</u> эсрэг, эсхүл <u>хуулийн</u> <u>этгээдийн</u> <u>компанитай</u> холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;</p> <p>49.1.8.—хуулийн <u>этгээдийн</u> <u>компанийн</u> дүрэм, хуулийн этгээдийн үйл ажиллагааны болон засаглалын дотоод журам;</p>	
--	---	--

4. Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;

Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн зүйл, заалт агуулгатай нийцүүлэх шаардлагатай хэсгийг дараах хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хуулийн төслийн заалт	Бусад хуулийн заалт
<p>29 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэг хариуцлага</p> <p>29.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй:</p> <p>29.1.2.төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд оролцож, шийдвэр гаргахад саналаа өгөх;</p> <p>29.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр бүх гишүүдийн дийлэнх олонхын саналаар хүчин төгөлдөр болно.</p>	<p>Компанийн тухай хууль</p> <p>80.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.</p> <p>80.6.Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл компанийн дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.</p>

Хуулийн төслийн 29.1-д ТУЗ-ийн гишүүний үүргийг заасан бөгөөд 29.1.1-д ТУЗ-ийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд заавал ТУЗ-ийн хуралд оролцож санал өгөх үүргийг заасан. Энэ тохиолдолд ТУЗ-ийн гишүүн өвчтэй байх, байгалгийн гамшиг давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй, эсхүл ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэх асуудлаар сонирхлын

зөрчилтэй байх зэрэг шалтгаанаар хуралд оролцохгүй, оролцсон ч санал өгөхгүй байх шаардлага үүсдэг нь зүй ёсны хэрэг.

Гэтэл хуулийн төслийн 29.2-т төрийн болон орон нутгийн өмчийн компанийн ТУЗ-ийн шийдвэр бүх гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болохоор заасан нь 29.1.2-т заасантай зөрчилдөх, нөгөө талаар аль нэг ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцохгүй байхад ТУЗ-ийн шийдвэр гарах боломжгүйд хүрнэ. Жишээлбэл, 9 ТУЗ-ийн гишүүнтэй төрийн өмчийн компанийн хамгийн багадаа 6-аас дээш тооны гишүүн ТУЗ-ийн хуралд оролцож, бүх гишүүн санал нэгтэйгээр шийдвэр гаргах шаардлагай. Өөрөөр хэлбэл, ийнхүү ТУЗ-ийн гишүүнийг заавал хуралд оролцож санал өгдөг байх хатуу үүргийг ногдуулах нь төрийг төлөөлж тухайн компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа этгээдийн хувьд зүй ёсны үүрэг байж болох ч бизнесийн зарчмын хувьд ТУЗ тодорхой шийдвэр гаргах боломжгүй нөхцөлд хүргэх эрсдэлтэй. Ийнхүү ТУЗ нэн шаардлагатай асуудлаа шийдвэрлэх боломжгүй болох нь эргээд төрийн өмчийн компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тооцож ТУЗ-ийн хурлын шийдвэр гаргах хувийг Компанийн тухай хуулийн 80.5, 80.6-д заасныг баримтлах нь зохистой гэж үзэж байна.

Хуулийн төслийн заалт	Бусад хуулийн заалт
<p>37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа нягтлан шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, санхүүгийн баримтыг хянуулан хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор хөндлөнгийн аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр аudit хийлгүүлнэ.</p> <p>39.3.Гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшилийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.</p>	<p>Төсвийн тухай хууль</p> <p>8.9.8.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аudit хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьялагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.</p> <p>Аудитын тухай хууль</p> <p>10.2.Энэ хуулийн 10.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн аудитыг дараах хугацаанд хийлгэсэн байна:</p> <p>10.2.1.хувьцаат компани нь тайлангийн жилийн эцсийн санхүүгийн тайланг хэлэлцэх хувьцаа</p>

41.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.	<p>эзэмшигчдийн хурлаас хоёр ба түүнээс доошгүй долоо хоногийн өмнө;</p> <p>10.2.3. банк жилийн эцсийн санхүүгийн тайланг дараагийн санхүүгийн жилийн 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор;</p> <p>10.2.4. бусад аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн жилийн тайланг дараагийн санхүүгийн жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор.</p> <p>10.3. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх хугацааны асуудлыг Төсвийн тухай хууль болон бусад хуулиар зохицуулна.</p>
--	--

Одоогийн хууль тогтоомжийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компанийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит бус Төсвийн тухай хуулийн 8.9.8-д зааснаар төрийн аудит хийхээр заасан. Тиймээс Аудитын тухай хуулийн 10.3-т энэ талаар мөн адил заасан. Гэсэн хэдий ч ямар хугацаанд төрийн аудит хийх талаар тодорхой зохицуулалт байхгүй бөгөөд төрийн болон орон нутгийн өмчит компани жилийн эцсийн санхүүгийн тайлан гарсны дараа буюу дараа жилийн 2 дугаар сарын 15-ны өдөр төрийн аудитын байгууллагад хүргүүлж аудитын тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьялагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх зохицуулалттай. Эндээс үзвэл төрийн болон орон нутгийн өмчит компанийн санхүүгийн тайланд аудит хугацаа нь 2 дугаар сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны өдөр хүртэл байх учиртай.

Харин хуулийн төслийн 37.4-т “Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа нягтлан шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засаг, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаа, санхүүгийн баримтыг хянуулан хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор хөндлөнгийн аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр аудит хийлгүүлнэ” гэж зааснаар төрийн болон орон нутгийн өмчит компанийн санхүүгийн тайланд төрийн аудит бус хөндлөнгийн аудит хийлгэдэг байхаар зохицуулсан. Энэ тохиолдолд Төсвийн тухай хуульд заасан төрийн аудит хийх хугацаа бус Аудитын тухай хуульд заасан аудит хийх хугацаа үйлчилнэ. Тодруулбал, төрийн болон орон нутгийн өмчит компани нь ХК-ийн хэлбэртэй байх тохиолдолд Аудитын тухай хуулийн 10.2.1-т заасан

"хувьцаат компани нь тайлангийн жилийн эцсийн санхүүгийн тайланг хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн хурлаас хоёр ба түүнээс доошгүй долоо хоногийн өмнө", ХХК хэлбэртэй байх тохиолдолд 10.2.4 "бусад аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн жилийн тайланг дараагийн санхүүгийн жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор" хөндлөнгийн аудит хийлгэсэн байх шаардлагатай.

Дүгнэвэл, хуулийн төслийн 39.3-т "Гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ" гэж заасан нь жилийн эцсийн санхүүгийн тайланда аудитын дүгнэлт хийгдээгүй байхад гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг гаргах шаардлага үүснэ. Хэрвээ хөндлөнгийн аудитын дүгнэлтээр санхүүгийн тайлан алдаа дутагдалтай, зөрчилтэй зэрэг асуудал үүсвэл компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, гэрээний хэрэгжилтийн тайлан мөн адил алдаатай гарах эрсдэлтэй. Энэ талаар тус хуулийн төслийг дагалдан өөрчлөлт орох бусад хуулийн төсөлд аливаа өөрчлөлт, нийцүүлэлт хийгдээгүй байх тул хууль хоорондын зөрчилдөөнийг үүсгэх асуудалтай. Тиймээс хуулийн төслийн дээрх зохицуулалтыг дор дурдснаас өөрчлөх нь зүйтэй. Үүнтэй мөн адил хуулийн төслийн 41.4-т заасан зохицуулалтыг нийцүүлж өөрчлөх шаардлагатай.

Судлаачийн санал

39.3 "Гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор хүргүүлнэ."

41.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор хүргүүлнэ." дараа-өнө 03 дугаар сарын 01-ний өдрийн дөтөр хүргүүлнэ.

5. Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;

Хуулийн төслийн зарим зүйл заалт нь Компанийн тухай хуулийн заалттай давцаж байгаа тул хуулийн төслийг ойлгомжтой, давхцалгүй байх үүднээс холбогдох

зохицуулалтыг шууд ишлэж заах нь зохимжтой. Иймд давхцал бүхий заалтыг дараах байдлаар засварлав.

Хуулийн төслийн заалт	Тайлбар
6.2. Төрийн болон орон нутгийн өмчтэй компани нь хязгаарлагдмал хариуцлагатай, эсхүл хувьцаат компанийн хэлбэртэй байна.	КтХ-ийн шууд холбогдох заалтыг ишлэв.
6.2. Төрийн болон орон нутгийн өмчтэй компани нь хязгаарлагдмал хариуцлагатай, эсхүл хувьцаат компанийн Компанийн тухай хуулийн 3.4-т заасан хэлбэртэй байна.	

6. Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;

Хуулийн төсөлд заагдсан эрх, үүрэг, чиг үүргийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.

7. Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдвуулсан эсэх;

Тийм зохицуулалт байхгүй.

8. Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;

Ийм агуулга төсөлд тусгагдаагүй.

9. Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;

Ийм агуулга төсөлд тусгагдаагүй.

10. Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

Энэ хуулиар дурдсан харилцааг шинээр бий болгож зохицуулаагүй байна.

11. Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;

Энэ хуулиар зохицуулаагүй.

12. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын

гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;

Хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захиралд нэр дэвшигчид тавигдах шаардлагуудыг тусгасан бөгөөд энэ нь тухайн албан тушаалд ажиллах этгээд нь мэргэжлийн ур чадвартай байх, ашиг сонирхлын зөрчилгүй байх, төрийн болон орон нутгийн өмчит компанийг үр ашигтай ажиллуулахын тулд тавигддаг зохих ёсны шаардлага юм. Тиймээс тухайн шаардлагууд нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлах үндэслэлд хамаarahгүй.

13.Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;

Жендерийн эрх тэгш байх зарчмыг хөндөөгүй гэж үзсэн. Хуулийн төслийн 28.6 “Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилох, эсхүл томилуулахаар санал болгоходоо жендерийн эрх тэгш байдал буюу төлөөлөн удирдах зөвлөл дэх хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалзана.” гэж заасан нь жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн дэвшилтэй зохицуулалт байна.

14.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх

Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна. Харин хуулийн төсөлд шинээр төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл шаардлагыг тодорхой болгосноор төр, орон нутаг бизнесийн аль ч салбарт бизнес эрхлэх замаар хувийн хэвшилтэй өрсөлдөх, шударга бус өрсөлдөөн үүсгэх байдлыг хязгаарласан нь шударга өрсөлдөөнийг дэмжихэд чиглэсэн ач холбогдолтой байна.

15.Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

Ийм агуулга хуулийн төсөлд тусгагдаагүй.

16.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Хуулийн төслийн 50 дугаар зүйлд хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгасан бөгөөд үүнийг дагалдуулан Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийг зохих ёсоор боловсруулсан байна.

Харин ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирлын хууль болон гэрээнд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтад тодорхой засвар өөрчлөлтийг оруулсан болно. Дэлгэрэнгүйг өмнөх хэсгүүдээс харна уу.

Дөрөв. Дүгнэлт, санал

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн үр нэлөөний судалгаагаар тус хуулийн төслийн боловсруулалт, агуулга, зүйл заалтын утга найруулга, бусад хууль тогтоомжтой уялдаатай байдал зэргийг бүхэлд нь дүгнэлт өгөхийг зорив. Энэ хүрээнд холбогдох хэсгүүдэд хуулийн төслийн талаар нарийвчилсан дүгнэлтийг хийсэн тул дүгнэлт хэсэгт нь ерөнхий дүгнэлт хийв.

Ийнхүү Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг ерөнхийд нь дараах байдлаар товч дүгнэв.

1. Хуулийн төслийн үзэл баримтлалаас үзвэл төрийн болон орон нутгийн өмчит компанийг байгуулах үндэслэл шаардлагыг тодорхойлж, хувийн хэвшлийн зүгээс гүйцэтгэх боломжтой салбаруудад төр өөрийн өмчлөл, эзэмшилийн компани байгуулах замаар чөлөөт өрсөлдөөнд харш үйлдэл хийхгүй байхад чиглэгдсэн байна. Энэ утграараа хуулийн төсөл нь үзэл баримтлалд нийцэж боловсруулагдсан гэж дүгнэж болохоор байна.
2. Зүй ёсны шаардлага, үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулсан тохиолдолд тухайн компаниуд нь эдийн засаг, санхүүгийн үр ашигтай, компанийн удирдлага нь улс төрийн болон хөндлөнгийн этгээдийн зүй бус нэлөөллөөс ангид, бие даасан үйл ажиллагаа явуулах зорилтыг агуулж байна. Үүний тулд компанийн ТУЗ болон гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах журмыг тогтоож, тэдгээр удирдлагууд нь мэргэшсэн ур чадвартай байхын тулд нэр дэвшигчдэд тавигдах шаардлагыг нарийвчлан тогтоосон нь оновчтой байна.
3. Түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагын зүгээс компанийг оновчтой менежмент, удирдлагаар хангах замаар компанийн эдийн засаг, санхүүгийн үр ашигтай удирдах шаардлагатай бөгөөд үүний тулд компанийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн гүйцэтгэлд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, компанийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтэд гүйцэтгэлийн үнэлгээ хийх замаар үнэлгээ хангалтгүй байгаа компанийн удирдалгуудыг чөлөөлөх, компанийн эрх эүйд хүлээн зөвшөөрөгдсөн хүрээнд хариуцлага тооцох зохицуулалтыг тусгасан нь оновчтой байна.

Харин хуулийн төслийн талаарх засаж сайжруулах шаардлагатай судалгааны хэсгүүдэд тусгагдсан саналуудыг нэгтгэж хуулийн төсөлд word програмын trackchange-н хэрэглэгдүүнийг ашиглаж шаардлагатай өөрчлөлтүүдийг нэгтгэсэн болно. Тиймээс хуулийн төсөлд хамаарах судлаачдын саналын дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Эх сурвалж

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Аудитын тухай хууль
3. Компанийн тухай хууль
4. Иргэний хууль
5. Төвсийн тухай хууль
6. Төрийн албаны тухай хууль
7. Төрийн аудитын тухай хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
10. Өрсөлдөөний тухай хууль

Бусад

1. Г.Давааням, Компанийн эрх зүйн онол, практикт, (2023).
2. Г.Давааням, М.Түвшинжаргал, Төрийн өмчтөй болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөл: олон улсын туршлага ба Монгол улс, 42-43 (ННФ., 2022).
3. 村田敏一「株主平等原則と株主権の動態」（2021、法律文化社）.
4. OECD (2024), *OECD Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises 2024*, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/18a24f43-en>.

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

УЛААНБААТАР

2024

АГУУЛГА

I. УДИРТГАЛ	3
II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	4
2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	14
2.2. Хүний нөөцийг тодорхойлох	18
2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	26
2.4. Үр дүнг тооцох	27
2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	28
ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО	28
2.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох	29
2.2. Зардал тооцох	43
2.3. Тоон үзүүлэлтийг тооцох	52
2.4. Зардлын дүнг тооцож гаргах	55
2.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	57
2.6. Нэмэлт зардлыг тооцох	58
ДҮГНЭЛТ, САНАЛ	59

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

(ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ)

I. УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, мөн хөгжлийн төлөвлөлтийн урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, олон улсын жишиг хандлагыг баримтлан компанийн сайн засаглалыг бүрдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчит компанитай холбоотой тухайлсан харилцааг зохицуулах анхдагч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулжээ.

Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно" гэж заасан. Үүний дагуу, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал" /цаашид "аргачлал" гэх-/ыг баримтлан тооцож, судалгаа хийх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тулгарсан.

Судалгааны зорилго. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, хялбарчлах болон бууруулах боломжит хувилбар бүхий санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү судалгааны зорилго чиглэгдэнэ.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу тооцоолсон бөгөөд тус аргачлалд заасан дараах нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- Төрийн байгууллагад шинээр хүлээлгэсэн үүргийг оновчтой тодорхойлох;²
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;³
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;⁴
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.⁵

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг:

¹ "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, <https://legalinfo.mn/mn/detail/11119> (сүүлд үзсэн:2023.09.09)

² Зардлын тооцоог хийх аргачлалын 2.3, 4.3 дахь зохицуулалт

³ Зардлын тооцоог хийх аргачлалын 2.4.4, 4.4 дэх зохицуулалт.

⁴ Зардлын тооцоог хийх аргачлалын 4.4.3.1 дэх зохицуулалт.

⁵ Зардлын тооцоог хийх аргачлалын 2.1, 4.1 дэх зохицуулалт.

1.төрийн байгууллагын зардал;

2.хуулийн этгээдийн зардал;

3.иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус хуулийн төслөөр хувь хүнд ямар нэгэн нэмэлт үүрэг хүлээлгээгүй тул энэхүү тооцооллын хүрээнд гагцхүү хуулийн этгээд, төрд үүсэх зардлыг тооцсон болно.

Мөн төрийн байгууллагын хувьд шинээр хүлээлгэсэн зарим чиг үүрэгтэй холбоотой үүсэх тодорхой зардлыг тогтоож, хялбарчлах хувилбарыг санал болгоно. Өөрөөр хэлбэл, өөрчлөгдөөгүй буюу өмнө нь байсан чиг үүрэгтэй холбогдох аливаа зардлыг тус судалгааны хүрээнд тооцоогүй болно.

Судалгааны үр дунд үндэслэн, тус хуулийн төсөлт батлагдсанаар үүсэх зардлыг тооцон, зардал ба үр өгөөжийн харьцааг дүгнэж тайлан боловсруулав.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцно. Уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг тус тооцоонд тусгаагүй. Үүнд:

- 7.1.Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийг баталж, Улсын Их Хуралд танилцуулна.
- 7.2.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газрын гишүүдийн саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.8-д заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.
- 16.2.Төрийн өмчийн компаниас төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн нийт дүнгийн доод хэмжээг Улсын Их Хурал жил бүрийн төсөвт тусган батална.
- 16.3.Тухайн төсвийн жилд баримтлах энэ хуулийн 16.1-д заасан хувь болон ногдол ашиг төлөх үүргээс тухайн жилд чөлөөлөгдхөк компанийн жагсаалтыг төрийн өмчийн компанийн хувьд Улсын Их Хурал, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсөвтэй хамт батална.18.2.Төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байх бөгөөд Засгийн газрын шийдвэрээр тогтооно.
- 19.1.Засгийн газар төрийн өмчит компанийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 18.1.2.энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийг баталж, Улсын Их Хуралд танилцуулах;
- 25.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон нэр дэвшигчийн нөөц сангийн журмыг Засгийн газар батална.

- 21.1.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 42.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлалыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.
- 40.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, аргачлал, үнэлгээний журмыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар батална.
- 47.6...Илтгэл бэлтгэх загварыг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

Мөн дараах чиг үүргийг шинээр нэмэгдээгүй гэж үзэж энэхүү зардлын тооцоонд хамруулаагүй болно. Үүнд:

Хүснэгт 1. Төсөлд дурдагдсан одоогийн хүчин төгөлдөр зохицуулалт

Холбогдох байгууллага	Гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох төслийн зохицуулалт	Одоогийн зохицуулалт
Засгийн газар	<p>9.5.Төрийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийг Засгийн газар, төрийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах шийдвэрийг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, бусад хувьцаа эзэмшигч хамтран Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргана.</p> <p>18.1.3.энэ хуулийн 8.1.6-д заасан үндэслэлээр төрийн өмчит компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг Улсын Их Хурлын зөвшөөрлийн үндсэн дээр гаргах;</p> <p>18.1.4.энэ хуулийн 8.1.6-д зааснаас бусад үндэслэлээр төрийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах;</p> <p>18.1.5.төрийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох;</p> <p>18.1.Засгийн газар төрийн өмчит компанийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>18.1.1.төрийн өмчит компанийд төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг томилох;</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (цаашид "ТБОНӨтХ" гэх)</p> <p>9.5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;</p> <p>ТБОНӨтХ 21.3/энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг</p>

		хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газар тогтоох.
	18.1. Засгийн газар төрийн өмчит компанийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.6. төрийн өмчийн компанийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах;	ТБОНӨтХ 9.3/ төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх тухай шийдвэр гаргах;
	11.1. Төрийн өмчийн компани охин компани байгуулах тохиолдолд Засгийн газар, орон нутгийн өмчийн компани охин компани байгуулах тохиолдолд тухайн шатны иргээдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 9.3-т заасан баримт бичгийг үндэслэн тус тус шийдвэр гаргана.	ТБОНӨтХ 9. 6/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах талаар тухайн хуулийн этгээдээс гаргасан саналыг хэлэлцэж шийдвэрлэх;
Тухайн шатны ИТХ	9.6. Орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах шийдвэрийг тухайн шатны иргээдийн Төлөөлөгчдийн Хурал гаргах бөгөөд орон нутгийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах шийдвэрийг орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, бусад хувьцаа эзэмшигч хамтран Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргана. 19.1.1. орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, орон нутгийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах; 19.1.2. орон нутгийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох;	ТБОНӨтХ 77.4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.
Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	21.2.5. төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт тайлагнах;	ТБОНӨтХ 60.2. Татан буулгах хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого хийж дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн энэ хуулийн 30 дугаар зүйлд зааснаар бусдад шилжүүлэх, эсхүл

	<p>Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p> <p>47.5. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийт төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдалд хяналт тавина.</p>	<p>дуудлагаар худалдаа ажлыг Засгийн газрын шийдвэрийг үндэслэн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.</p> <p>ТБОНӨТХ</p> <p>21.15. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчтэй болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дунд хяналт тавина.</p>
--	--	--

Харин хуулийн төсөл дэх дараах зүйл, заалт нь төрийн байгууллагын зардалд нөлөө үзүүлнэ гэж үзлээ.

Хүснэгт 2. Зардалд нөлөөлөх зүйл, заалт

Холбогдох байгууллага	Гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Нөлөөлөх зүйл, заалт
Засгийн газар	<p>44.1. Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана.</p> <p>16.6. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани ногдол ашиг хуваарилах асуудлаар энэ хуулийн 16.5-д заасан чиглэлийг баримтлаагүй, эсхүл ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар, эсхүл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, эцэслэн шийдвэрлэнэ.</p>	

	<p>7.4.Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газарт хүргүүлнэ.</p> <p>7.5.Үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн тайланг Засгийн газар болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулна.</p>	
Асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	<p>9.1.Төрийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт хүргүүлнэ.</p>	<p>9.3.Энэ хуулийн 9.1, 9.2-т заасан төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах саналд дараах баримт бичгийг хавсаргана:</p> <p>9.3.1.компанийн дүрмийн төсөл; Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхойлсон мэдээлэл</p> <p>9.3.2.энэ хуулийн 8.1-д заасан компани байгуулах үндэслэл болон энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлд нийцсэн талаарх төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрын гаргасан дүгнэлт.</p> <p>10.5.Энэ хуулийн 10.1-д заасан компанийн дүрмийн төслийг боловсруулахад төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авна.</p>
Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга	<p>9.2.Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.</p>	
Тухайн шатны ИТХ	<p>19.1.3.орон нутгийн өмчийн компанийн үл хөдлөх эд хөрөнгө, газар зээмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах;</p> <p>44.1.Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгох шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана.</p> <p>11.1....орон нутгийн өмчийн компани охин компани байгуулах тохиолдолд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 9.3-т заасан баримт бичгийг үндэслэн тус тус шийдвэр гаргана.</p>	

	<p>16.6.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани ногдол ашиг хуваарилах асуудлаар энэ хуулийн 16.5-д заасан чиглэлийг баримтлаагүй, эсхүл ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар, эсхүл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, эцэслэн шийдвэрлэнэ.</p>	
Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	<p>21.2.1.төрийн өмчит компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлаар дүгнэлт гаргаж, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;</p>	<p>9.4.Энэ хуулийн 9.3.2-т заасан дүгнэлтийг дараах мэдээлэлд үндэслэн гаргана:</p> <p>9.4.1.төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах хэрэгцээ, шаардлага, зах зээлийн эрэлт, хүлээлт, тухайн компаниас гаргах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт, бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх байдлын талаарх зах зээлийн судалгаа, байршил;</p> <p>9.4.2.хөрөнгө оруулалтын хэмжээ, төрөөс, эсхүл орон нутгаас оруулах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, хөрөнгө оруулалтыг бүрэн хийж дуусгах хугацаа, хөрөнгө оруулалтыг нөхөх болон эргэлтийн эх үүсвэр бүрдүүлэх талаар хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд тавигдах шаардлага;</p> <p>9.4.3.бүтээгдэхүүн, үйлчилгээнд шаардагдах түүхий эд, эрчим хүч, ажиллах хүч болон бусад шаардлагатай хүчин зүйлийг хангах эх үүсвэр, чадамж;</p> <p>9.4.4.салбарын хөгжлийн төлөвлөгөө, бодлогод нийцсэн байдал, нийгэм, эдийн засгийн үр ашгийн тооцоолол.</p>
	<p>21.2.2.төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх;</p>	

<p>21.2.4.төрийн өмчийн компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах талааршаардлага, зөвлөмж өгөх, хуульд заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, хариуцлага хүлээлгэх саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;</p>	
<p>21.2.6.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;</p>	<p>25.3.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг 30 хоногийн дотор зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид санал болгоно.</p>
	<p>25.4.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус байгууллага, мэргэжлийн нэгдсэн холбооны төлөөлөл бүхий ажлын хэсгийг байгуулна.</p>
	<p>25.5.Энэ хуулийн 25.3-т заасны дагуу санал болгосон нэр дэвшигчээс бусад нэр дэвшигчийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэр дэвшигчийн нөөцийн сан үүсгэн бүртгэнэ. Нөөцийн санд орсон нэр дэвшигчийг 2 жил тутам шинэчилнэ.</p>
	<p>25.6.Энэ хуулийн 25.5-д заасан нөөцийн санд бүртгэгдсэн нэр дэвшигчээс төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний шаардлага хангаж байгаа хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах</p>

	зөвлөлийн гишүүнд санал болгож болно.
	25.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нэр дэвшигч тус бүрийн үнэлгээний оноо, нэр дэвшигчийн нөөцийн сангийн мэдээллийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудаст нээлттэй, ил тод байршуулна.
	27.3.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн шүүхээр гэм буруутай нь тогтоогдож байсан эсэх талаарх лавлагааг эрх бүхий байгууллагаас хариуцан авна.
21.2.7.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацаа, гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;	
21.2.8.төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг жил бүр хүлээн авч хянах;	
44.11.Энэ хуулийн 44.10-т заасан нэгдсэн тайлан, саналыг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудас болон төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдсэн цахим хуудсанд олон нийтэд ил тод, нээлттэй байршуулна.	
46.3.Энэ хуулийн 46.1-д заасан мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдсэн цахим хуудсанд байршуулна. Нэгдсэн цахим хуудсыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хөтөлнө.	
7.4.Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр	

	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газарт хүргүүлнэ.	
	7.5.Үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн тайланг Засгийн газар болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулна.	
Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгж	<p>21.2.1. орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлаар дүгнэлт гаргаж, төрийн эзэмшилийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;</p>	<p>9.4.Энэ хуулийн 9.3.2-т заасан дүгнэлтийг дараах мэдээлэлд үндэслэн гаргана:</p> <p>9.4.1.төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах хэрэгцээ, шаардлага, зах зээлийн эрэлт, хүлээлт, тухайн компаниас гаргах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт, бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх байдлын талаарх зах зээлийн судалгаа, байршил;</p> <p>9.4.2.хөрөнгө оруулалтын хэмжээ, төрөөс, эсхүл орон нутгаас оруулах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, хөрөнгө оруулалтыг бүрэн хийж дуусгах хугацаа, хөрөнгө оруулалтыг нехөн болон эргэлтийн эх үүсвэр бүрдүүлэх талаар хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд тавигдах шаардлага;</p> <p>27.1.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 25.2-т заасан захиалга ирүүлснээс хойш ажлын тав өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг өөрийн цахим хуудас, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.</p> <p>9.4.3.бүтээгдэхүүн, үйлчилгээнд шаардагдах түүхий эд, эрчим хүч, ажиллах хүч болон бусад шаардлагатай хүчин зүйлийг хангах эх үүсвэр, чадамж;</p> <p>9.4.4.салбарын хөгжлийн төлөвлөгөө, бодлогод нийцсэн байдал, нийгэм, эдийн засгийн үр ашгийн тооцоолол.</p>

<p>21.2.4.... компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах талаар шаардлага, зөвлөмж өгөх, хуульд заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, хариуцлага хүлээлгэх саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх;</p>	
<p>21.2.5. компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнгтайлагнах;</p>	
<p>21.2.9.. компанийн орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих;</p>	
<p>21.2.6.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;</p>	<p>26.2.Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасныг баримтална.</p>
	<p>25.3.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг 30 хоногийн дотор зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид санал болгоно.</p>
	<p>25.4.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус байгууллага, мэргэжлийн нэгдсэн холбооны төлөөлөл бүхий ажлын хэсгийг байгуулна.</p>
	<p>25.6.Энэ хуулийн 25.5-д заасан нөөцийн санд бүртгэгдсэн нэр дэвшигчээс төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний шаардлага хангаж байгаа хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн</p>

	болов орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд санал болгож болно.
	25.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нэр дэвшигч тус бүрийн үнэлгээний оноо, нэр дэвшигчийн нөөцийн сангийн мэдээллийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудаст нээлттэй, ил тод байршуулна.
	27.1.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 25.2-т заасан захиалга ирүүлснээс хойш ажлын тав өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг өөрийн цахим хуудас, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.
	27.3.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн шүүхээр гэм буруутай нь тогтоогдож байсан эсэх талаарх лавлагааг эрх бүхий байгууллагаас хариуцан авна.
21.2.7.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацаа, гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;	

2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгоходоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Хэрэгжүүлэх, хэмжих боломжтой чиг үүргийг хамруулах.

Чиг үүргийг тодорхойлоходоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлоходоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Холбогдох байгууллага	Гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Стандарт үйл ажиллагаа
Засгийн газар	Төрийн өмчийн компани нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлээр нийтэд санал болгох шийдвэрийг гаргах	Саналыг хэлэлцэж шийдвэрлэх Шийдвэрийг албажуулж, хүргүүлэх
	Төрийн өмчийн компанийн ногдол ашгийг хуульд заасан журмын дагуу хуваарилахгүй байх үндэслэлийг хянаж шийдвэр гаргах	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн саналыг хэлэлцэх Шийдвэрийг албажуулж, хүргүүлэх
	Үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн тайланг цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулах	Цахим хуудсанд байршуулах
Асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Төрийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг Засгийн газарт хүргүүлэх	Төрийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, шаардлагыг судлах Төрийн өмчит компани үүсгэн байгуулах шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг бэлтгэх Төрийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэлтэй эсэх талаарх төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас дүгнэлт авах Компанийн дүрмийн төслийг бэлтгэх Дүрмийн төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авах Хуульд заасан бүрдүүлэх материалыг албажуулж, Засгийн газарт хүргүүлэх
Засаг дарга	Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх	Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, шаардлагыг судлах Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг бэлтгэх Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэлтэй эсэх талаарх орон нутгийн өмчийн асуудал хариуцсан захиргааны нэгжээс дүгнэлт авах Компанийн дүрмийн төслийг бэлтгэх

		Дүрмийн төсөлд холбогдох байгууллагаас санал авах Хуульд заасан бүрдүүлэх материалыг албажуулж, ИТХ-д хүргүүлэх
Тухайн шатны ИТХ	Компанийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах	Холбогдох асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх Шийдвэрийг албажуулж хүргүүлэх
	Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлээр нийтэд санал болгох шийдвэрийг гаргах	Саналыг хэлэлцэж шийдвэрлэх Шийдвэрийг албажуулж, хүргүүлэх
	Ногдол ашгийг хуульд заасан журмын дагуу хуваарилахгүй байх үндэслэлийг хянаж шийдвэр гаргах	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн саналыг хэлэлцэх Шийдвэрийг албажуулж, хүргүүлэх
	Охин компани байгуулах шийдвэрийг гаргах	Холбогдох асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх Шийдвэрийг албажуулж хүргүүлэх
Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Төрийн өмчит компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх	Холбогдох асуудлаар судалж, дүгнэлт гаргах Дүгнэлтийг албажуулан хүргүүлэх
	Төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх	Холбогдох асуудлаар судалж, дүгнэлт гаргах Дүгнэлтийг албажуулан хүргүүлэх
	Төрийн өмчийн компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлж, хэрэгжилтийг хангах талаар шаардлага, зөвлөмж өгөх	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх Шаардлага, зөвлөмж боловсруулан хүргүүлэх Нэгдсэн дүнг Засгийн газарт танилцуулах
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг солих, хариуцлага тооцох саналыг орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлэх Чөлөөлөх, хариуцлага тооцох саналыг бэлтгэж хүргүүлэх
	Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, санал болгох	Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар ажлын хэсэг байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ил тод мэдээлэх
		Сонгон шалгаруулах журмыг нийтэд мэдээлэх

		Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүнг гаргах
		Нэр дэвшигч тус бүрийн үнэлгээ болон бусад шаардсан мэдээллийг нийтэд мэдээлэх Саналыг албажуулж хүргүүлэх
	Нэр дэвшигчийн нөөцийн сан үүсгэн бүртгэх	Нэр дэвшигчийн нөөц сан үүсгэх
		Бусад нэр дэвшигчийг нөөц санд бүртгэх 2 жилд 1 удаа нөөц санг шинэчлэх
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацаа, гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих	Холбогдох асуудлаар хяналт тавих Зөрчил илэрсэн тохиолдолд мэдэгдэл хүргүүлэх
	Төрийн болон орон нутгийн хувьцааг эзэмших зорилго, хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг жил бүр хүлээн авч хянах	Илтгэлийг хүлээн авах Илтгэлийг нэгтгэж, төрийн болон орон нутгийн эзэмшиж байгаа хувьцааг шилжүүлэх үр дүнтэй хувилбарын талаарх нэгдсэн тайлан, санал бэлдэх Тайланг албажуулж ЗГ-т хүргүүлэх Тайланг байгууллагын цахим хуудсанд нийтлэх
	Төрийн болон орон нутгийн өмчit компанийн нэгдсэн цахим хуудсыг хөтлөх	Холбогдох компанийн цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах Хуулийн 46.1-д заасан мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд байршуулах Шинэчлэл, өөрчлөлтийг тухай бүр байршуулах, хөтлөх
	Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газарт хүргүүлэх, нийтлэх	Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх Тайланг албажуулж, Засгийн газарт хүргүүлэх Цахим хуудаст хэрэгжилтийн тайланг байршуулах
Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгж	Орон нутгийн өмчit компанийн үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, орон нутгийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх	Холбогдох асуудлаар судалж, дүгнэлт гаргах Дүгнэлтийг албажуулан хүргүүлэх
	Оорон нутгийн өмчit компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан	Шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах

	буулгах шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;	Үр дүнг ИТХ-д тайлагнах
	Компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлж, хэрэгжилтийг хангах талаар шаардлага, зөвлөмж өгөх	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх Шаардлага, зөвлөмж боловсруулан хүргүүлэх Нэгдсэн дүнг ИТХ-д танилцуулах
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг солих, хариуцлага тооцох саналыг орон нутгийн эзэмшилийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлэх Чөлөөлөх, хариуцлага тооцох саналыг бэлтгэж хүргүүлэх
	Орон нутгийн өмчит компанийн орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих;	Холбогдох асуудлаар хяналт тавих Шаардлагатай бол шаардлага, зөвлөмж хүргүүлэх
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацаа, гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих	Холбогдох асуудлаар хяналт тавих Зөрчил илэрсэн тохиолдолд мэдэгдэл хүргүүлэх
	Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, санал болгох	Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар ажлын хэсэг байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ил тод мэдээлэх Сонгон шалгаруулах журмыг нийтэд мэдээлэх Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүнг гаргах Нэр дэвшигч тус бүрийн үнэлгээ болон бусад шаардсан мэдээллийг нийтэд мэдээлэх Саналыг албажуулж хүргүүлэх

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /цаашид “тохиолдлын тоо” гэх, шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авах бөгөөд тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтооно. Гэвч адил үйлчилгээ байхгүй шалтгаанаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын хавсралт жишиг хугацааг баримтлав.

Аргачлалын 4.4.3 дахь хэсэгт зааснаар тохиолдлын тоог тогтоох боломжтой, тогтоох боломжгүй гэж 2 ангилана. Статистикийн мэдээлэл, түүнчлэн судалгаагаар тогтоож болох ажил, үйлчилгээг тогтоох боломжтой тохиолдлын тоонд хамааруулна.

Харин үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх ажил, үйлчилгээг тогтоох боломжгүй тохиолдлын тоонд хамааруулна. Тухайлбал, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хэдэн жилээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд шаардагдах хүний нөөцийг шууд баримжаалж тооцно.

"2023 оны Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, здийн засгийн үндсэн үзүүлэлтүүд"-д зааснаар⁶ төрийн өмчийн хуулийн этгээдийн тоо 99 байх бөгөөд түүний 71⁷ нь ТӨХК, ТӨХХК, ТӨОК байна. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлд холбогдох мэдээнүүд зэрүүтэй байх боловч хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар 13 хувьцаат, 31 хязгаарлагдмал хариуцлагатай компани, нийт 44 байна.

УИХ-ын 2022 оны "Төрийн өмчийн хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" 16 дугаар тогтоолын дагуу 2022 оны 07 сарын 05-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор нэмэлт хувьцаа гаргаж, олон нийтэд нээлттэй арилжих 25 төрийн өмчийн хуулийн этгээдийн жагсаалтыг гаргасан байна.⁸ Гэвч эхний ээлжинд олон нийтэд хувьцааг нь нээлттэй арилжих 25 компанийн жагсаалтыг аль хэдийн баталсан бөгөөд одоогоор дээрх шийдвэр бүрэн хэрэгжээгүй байгаа бөгөөд цаашид нэмэлт хувьцаа гаргах асуудлаар шийдвэр гаргах тохиолдлын тоог тогтоох боломжгүй байгаа тул 1 гэж үзлээ. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн компани байгуулах тохиолдлын тоог дунджаар баримжаалах боломжгүй байгаа тул 1 гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, дурдсан чиг үүргүүд нь үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх шинжтэй байх тул тохиолдлын тоог 1 гэж авч үзсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн компани байгуулах тохиолдлын тоог тогтоох боломжгүй тул аргачлалын дагуу жилд дунджаар 1 байна гэж тооцох талаар дээр өгүүлсэн. Хуулийн төслийн 23.4-т "Энэ хуульд өөреөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь есөн гишүүнтэй байх ба сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилогдсон гишүүдээс бүрдэнэ." гэж заасан. Дээрхэд үндэслэн ТҮЗ-ийн гишүүнийг сонгох шалгаруулах тохиолдлын тоог 1 гэж, 1 удаагийн сонгон шалгаруулалтаар 5-9 гишүүнийг⁹ сонгон шалгаруулах боломжтой гэж үзэв.

Орон нутгийн өмчийн компанийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах тохиолдлын тоог баримжаалан жилд дунджаар 10 гэж тооцлоо.

Хүснэгт 4. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Холбогдох байгууллага	Гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Засгийн газар	Төрийн өмчийн компани нэмэлт	Саналыг хэлэлцэж шийдвэрлэх	60	1	60

⁶ https://pcsp.gov.mn/files/statistic/FR_BOOK_2023_Final.pdf

⁷ Үнд охин компанийг оруулаагүй болно.

⁸ 2022 оны 07 сарын 05-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол https://old.pcsp.gov.mn/toqtool/2022-07-05_87_336.PDF

⁹ Хуулийн төслийн 36.7-д заасан шаардлагыг хангаагүй компанийн төлөөлөн удирдах зөвлөл 5 гишүүнээс бүрдэнэ.

	хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлээр нийтэд санал болгох шийдвэрийг гаргах	Шийдвэрийг албажуулж, хүргүүлэх	60	1	60
	Төрийн өмчийн компанийн ногдол ашгийг хуульд заасан журмын дагуу хуваарилахгүй байх үндэслэлийг хянаж шийдвэр гаргах	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн саналыг хэлэлцэх	20	71	1420
		Шийдвэрийг албажуулж, хүргүүлэх	60	1	60
	Үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн тайланг цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулах	Цахим хуудсанд байршуулах	10	1	10
					1610
Асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Төрийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг Засгийн газарт хүргүүлэх	Төрийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, шаардлагыг судлах	960	1	960
		Төрийн өмчит компани үүсгэн байгуулах шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг бэлтгэх	240	1	240
		Төрийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэлтэй эсэх талаарх төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас дүгнэлт авах	60	1	60
		Компанийн дүрмийн төслийг бэлтгэх	480	1	480
		Дүрмийн төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авах	60	1	60
		Хуульд заасан бүрдүүлэх материалыг албажуулж, Засгийн газарт хүргүүлэх	60	1	60
					1860
Засаг дарга	Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах саналыг тухайн	Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, шаардлагыг судлах	960	1	960

	шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх	Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг бэлтгэх Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэлтэй эсэх талаарх орон нутгийн өмчийн асуудал хариуцсан захиргааны нэгжээс дүгнэлт авах Компанийн дүрмийн төслийг бэлтгэх Дүрмийн төсөлд холбогдох байгууллагаас санал авах Хуульд заасан бүрдүүлэх материалыг албажуулж, ИТХ-д хүргүүлэх	240 60 480 60 60	1 1 1 1	240 60 480 60 60
					1860
ИТХ	Компанийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах	Холбогдох асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх Шийдвэрийг албажуулж хүргүүлэх	120 60	10 10	1200 600
	Нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлээр нийтэд санал болгох шийдвэрийг гаргах	Саналыг хэлэлцэж шийдвэрлэх Шийдвэрийг албажуулж, хүргүүлэх	120 60	1 1	120 60
	Ногдол ашгийг хуульд заасан журмын дагуу хуваарилахгүй байх үндэслэлийг хянаж шийдвэр гаргах	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн саналыг хэлэлцэх Шийдвэрийг албажуулж, хүргүүлэх	120 60	44 44	5280 2640
	Охин компани байгуулах шийдвэрийг гаргах	Холбогдох асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх Шийдвэрийг албажуулж хүргүүлэх	120 60	1 1	120 60
					10080
Төрийн өмчийн	Төрийн өмчит компани үүсгэн	Холбогдох асуудлаар судалж, дүгнэлт гаргах	480	1	480

асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх	Дүгнэлтийг албажуулан хүргүүлэх	60	1	60
	Төрийн өмчит компанийн төрийн эзэмшилийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх	Холбогдох асуудлаар судалж, дүгнэлт гаргах	480	1	480
		Дүгнэлтийг албажуулан хүргүүлэх	60	1	60
	Төрийн өмчийн компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлж, хэрэгжилтийг хангах талаар шаардлага, зөвлөмж өгөх	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх	240	71	17040
		Шаардлага, зөвлөмж боловсруулан хүргүүлэх	480	71	34080
		Нэгдсэн дүнг Засгийн газарт танилцуулах	120	1	120
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг солих, хариуцлага тооцох саналыг орон нутгийн эзэмшилийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлэх	480	71	34080
	Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, санал болгох	Чөлөөлөх, хариуцлага тооцох саналыг бэлтгэж хүргүүлэх	120	1	120

		Нэр дэвшигч тус бүрийн үнэлгээ болон бусад шаардсан мэдээллийг нийтэд мэдээлэх	30	9	270
		Саналыг албажуулж хүргүүлэх	60	1	60
Нэр дэвшигчийн нөөцийн сан үүсгэн бүртгэх		Нэр дэвшигчийн нөөц сан үүсгэх	960	1	960
		Бусад нэр дэвшигчийг нөөц санд бүртгэх	60	9	540
		2 жилд 1 удаа нөөц санг шинэчлэх	480	0.5	240
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацаа, гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих		Холбогдох асуудлаар хяналт тавих	96000	1	96000
		Зөрчил илэрсэн тохиолдолд мэдэгдэл хүргүүлэх			
Төрийн болон орон нутгийн хувьцааг эзэмших зорилго, хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг жил бүр хүлээн авч хянах		Илтгэлийг хүлээн авах	5	71	355
		Илтгэлийг нэгтгэж, төрийн болон орон нутгийн эзэмшиж байгаа хувьцааг шилжүүлэх үр дүнтэй хувилбарын талаарх нэгдсэн тайлан, санал бэлдэх	2400	1	2400
		Тайланг албажуулж ЗГ-т хүргүүлэх	60	1	60
		Тайланг байгууллагын цахим хуудсанд нийтлэх	20	1	20
		Холбогдох компанийн цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах	60	1	60
		Хуулийн 46.1-д заасан мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд байршуулах	96000	1	96000
Төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдсэн цахим хуудсыг хөтлөх		Шинэчлэл, өөрчлөлтийг тухай бүр байршуулах, хөтлөх			

	Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газарт хүргүүлэх, нийтлэх	Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх Тайланг албажуулж, Засгийн газарт хүргүүлэх Цахим хуудаст хэрэгжилтийн тайланг байршуулах	2400 30 10	1 1 1	2400 30 10
					288845
Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгжүүд	Орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, орон нутгийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх Оорон нутгийн өмчит компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, УР дүнг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;	Холбогдох асуудлаар судалж, дүгнэлт гаргах Дүгнэлтийг албажуулан хүргүүлэх	240 60	1 1	240 60
		Шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах ҮР дүнг ИТХ-д тайлагнах	96000	1	96000
	Компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлж, хэрэгжилтийг хангах талаар шаардлага, зөвлөмж өгөх	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх Шаардлага, зөвлөмж боловсруулан хүргүүлэх Нэгдсэн дүнг ИТХ-д танилцуулах	240 480 120	44 44 1	10560 21120 120
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлыг солих, хариуцлага тооцох саналыг орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлэх Чөлөөлөх, хариуцлага тооцох саналыг бэлтгэж хүргүүлэх	480 120	44 1	21120 120

	Орон нутгийн өмчтөй компанийн орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих	Холбогдох асуудлаар хяналт тавих	96000	1	96000
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацаа, гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих	Шаардлагатай бол шаардлага, зөвлөмж хүргүүлэх Холбогдох асуудлаар хяналт тавих Зөрчил илэрсэн тохиолдолд мэдэгдэл хүргүүлэх	96000	1	96000
	Орон нутгийн өмчтөй компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, санал болгох	Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар ажлын хэсэг байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ил тод мэдээлэх Сонгон шалгаруулах журмыг нийтэд мэдээлэх Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүнг гаргах	480 30 10 2400	1 1 1 1	480 30 10 2400
	Нэр дэвшигч тус бүрийн үнэлгээ болон бусад шаардсан мэдээллийг нийтэд мэдээлэх Саналыг албажуулж хүргүүлэх	30 60	5		150 60
Нийт					344470¹⁰ 646865

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200×8) 1.600 ажлын цаг буюу (1.600×60) 96.000 минут ажиллана.

¹⁰ Нийслэлд холбогдох үзүүлэлт 344470 минут байх бол орон нутагт харьцангуй бага буюу 300 мяняган минут орчим байна. Гэвч аль алинд нь дунджаар 3 албан хаагч шаардлагатай байх тул ерөнхийлөн тооцоолов.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Засгийн газар, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд ачаалал тодорхой хэмжээгээр нэмэгдэх боловч хуулийн төсөл дээрх төрийн байгууллагын үйл ажиллагаанд төдийлөн нөлөө үзүүлэхгүй. Харин төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн нэгжийн ачаалал дор зааснаар нэмэгдэх төлөвтэй байна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	288845	96.000	3
Аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн нэгж тус бүр	344470	96.000	3

2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцоходоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг эхэлж тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцоходоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулалт зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын 128 дугаар тоот Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээг үндэслэвэл, төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчийн дундаж цалин ¹¹ 1,864,222 төгрөг, бусад захиргааны байгууллагын албан хаагчийн дундаж цалин ¹² 1,620,889 төгрөг байна. Тэдгээрийн дунджаар буюу 1 албан хаагчийн сарын дундаж цалинг 1,742,556 төгрөг гэж тооцов.

Хүснэгт 6. Нэг албан хаагчид ногдох хүний нөөцийн зардал

Нэгж	Жилийн дундаж цалин	Ажил олгогчийн НДШ-ын зардал	Нийт
Нийт	20,910,672	2,613,834	23,524,506

Нэгж зардлыг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

¹¹ Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089709806371&showType=1>

¹² Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089709836701&showType=1>

Хүснэгт 7. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн жилийн цалингийн зардал	Нийт албан хаагчийн жилийн цалингийн зардал
Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	3	23,524,506	70,573,518
Аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн нэгж тус бүр	3	23,524,506	70,573,518

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал болон холбогдох бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

"Материаллаг зардал" гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Материаллаг зардлыг тооцоходоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн ажлын байранд оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 8. Нэг албан хаагчид оногдох материаллаг зардал/

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	200,000
Нэг албан хаагчид оногдох		3,840,923

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 9. Нийт зардал

Нэгж	Материаллаг зардал	Нийт	
Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	70,573,518	3,840,923*3	82,096,287
Аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал	70,573,518	3,840,923*3	82,096,287

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 3, аймаг, нийслэл дэх орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн нэгж тус бүрт 3 албан хаагч нэмэгдэхээр байна. Албан хаагч бүрийн хүний нөөцийн болон материаллаг зардалд 27,365,429 төгрөг зарцуулагдана.

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

2.5.1. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Аргачлалын 4.4.3 дахь хэсэгт зааснаар тохиолдлын тоог тогтоох боломжтой, тогтоох боломжгүй гэж 2 ангилна. Хуулийн төсөлд шинээр нэмэгдсэн төрийн байгууллагын чиг үүргийн дийлэнх нь үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх шинжтэй байх тул тохиолдлын тоог 1 гэж авч үзсэн. Иймд тохиолдлын тоог багасгах боломжгүй гэж үзэв.

2.5.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Мэдээллийг тухай бүр хүргүүлэх нь үр дүнтэй байх тул давтамжийг багасгах чиглэл баримтлах зохимжгүй.

2.5.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс мэдээллийн агуулгыг хязгаарлалгүйгээр мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангахад чиглэх нь зүйтэй. Гэвч төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээрийн өмчийн оролцоотой компанийн бизнес төлөвлөгөө, бусад холбогдох баримт бичгийн стандарт загварыг урьдаас баталж, нэгдсэн байдлаар мөрдүүлэх нь тайлан мэдээ бүрэн бус, дутуу, шаардлага хангаагүй зэрэг шалтгаанаар буцаагдах эрсдэлийг багасгахаас гадна гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж өгөхөд зарцуулах хугацааг бууруулах ач холбогдолтой.

2.5.4. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах, цаашлаад гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ажлын гүйцэтгэлийг хянах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхдээ цахим системд ашиглах нь төрд үүсэх зардал, ачааллыг бууруулахад нөлөөтэй.

2.5.5. Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог хамгийн багаар тогтоосон байх тул дахин багасгах боломжгүй гэж үзэв.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

2.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд дараах төрлийн мэдээллийг хуулийн этгээд¹³ гүйцэтгэхээр зохицуулжээ.

Төрийн өмчийн, ялангуяа орон нутгийн өмчит компани, аж ахуйн нэгж бүрийн дүрэм харилцан адилгүй, төлөөлөл хэрэгжүүлэгч этгээдийг томилох, гүйцэтгэх захирлыг томилох, гэрээ байгуулах, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах, бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг дүгнэх, үйл ажиллагаа, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах асуудал нь харилцан адилгүй янз бүрийн байдлаар хэрэгжих байгааг зогсоож, нэгдсэн стандарттай болгох нь Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн нэг зорилт юм. Иймд бизнес төлөвлөгөөг боловсруулах, үнэлэх, хянах зэрэг зарим чиг үүргийг гүйцэтгэж буй одоогийн практик өөрчлөгдхө тул холбогдох өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцох нь зүйтэй гэж үзэж энэхүү зардлын тооцоонд тусгасан.

Хүснэгт 10. Хуулийн этгээдийн гаргаж өгөх мэдээллийн жагсаалт буюу гүйцэтгэх чиг үүрэг

Хуулийн төслийн хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт
15.1. Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу үнэт цаас гарана.	15.2. Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр урт хугацааны зээл авч болно. 15.3. Гүйцэтгэх захирал зээлийн гэрээний дагуу төлбөл зохих хуваарь болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг төлж барагдуулах төлөвлөгөө, хуваарийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан төлөөлөн удирдах зөвлөлд, төлөөлөн удирдах зөвлөл байхгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.
25.2. Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах шийдвэр гарсан, эсхүл сул орон гарснаас хойш ажлын таван өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах захиалгыг төрийн өмчийн	25.3. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг 30 хоногийн дотор зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид санал болгоно.

¹³ Төрийн болон орон нутгийн өмчийн компаний хувьцаа эзэмшигч нь Засгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал байх хэдий ч зардлын тооцооны энэхүү хэсэгт бие даасан хуулийн этгээдээс зардал гарна гэж үзэн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөл гэх мэт дотоод харилцаанд үүсэх зардлыг тооцлоо.

асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	<p>25.4.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус байгууллага, мэргэжлийн нэгдсэн холбооны төлөөлөл бүхий ажлын хэсгийг байгуулна.</p> <p>25.5.Энэ хуулийн 25.3-т заасны дагуу санал болгосон нэр дэвшигчээс бусад нэр дэвшигчийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэр дэвшигчийн нөөцийн сан үүсгэн бүртгэнэ. Нөөцийн санд орсон нэр дэвшигчийг 2 жил тутам шинэчилнэ.</p> <p>25.6.Энэ хуулийн 25.5-д заасан нөөцийн санд бүртгэгдсэн нэр дэвшигчээс төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний шаардлага хангаж байгаа хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд санал болгож болно.</p> <p>25.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон нэр дэвшигчийн нөөц сангийн журмыг Засгийн газар батална.</p> <p>25.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нэр дэвшигч тус бүрийн үнэлгээний оноо, нэр дэвшигчийн нөөцийн сангийн мэдээллийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудаст нээлттэй, ил тод байршуулна.</p>
<p>26.1.Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар зохион байгуулна.</p> <p>26.2.Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасныг баримтална.</p>	
28.1.Энэ хуулийн 25.3, 25.6-д заасны дагуу санал болгосон нэр дэвшигчийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 24.1-д заасан шаардлага хангасан	28.3.Энэ хуулийн 28.1, 28.2-т заасны дагуу томилогдсон төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх томилогдсон өдрөөс эхэлж, хуульд заасан үндэслэлээр

<p>тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гишүүнээр томилно.</p> <p>28.2.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд төрийн болон орон нутгийн эзэмшилийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал болгоно.</p>	<p>чөлөөлөгдсөн өдрөөс эхлэн дуусгавар болно.</p> <p>28.4.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг энэ хуулийн 24.1-д заасан шаардлага хангагүй үндэслэлээр томилохос татгалзсан тохиолдолд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар ажлын таван өдрийн дотор дараагийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг санал болгоно.</p> <p>28.5.Энэ хуулийн 28.4-т заасан хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн томилогдоогүйн улмаас төрийн болон орон нутгийн өмчит компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, компани болон хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна.</p> <p>28.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилох, эсхүл томилуулахаар санал болгоходо жендэрийн эрх тэгш байдал буюу төлөөлөн удирдах зөвлөл дэх хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалзана.</p> <p>28.7.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жилээс хэтрэхгүй байх бөгөөд нэг удаа улируулан томилж болно.</p> <p>28.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг албан тушаалаар томилохгүй.</p>
<p>30.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн цалин, урамшуулалт авч болно.</p> <p>30.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах журмаар тогтооно:</p>	<p>30.2.1.нийтийн дэд бүтцийн болон нийтийн үйлчилгээний салбарын төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал болон төрийн албан хаагчийн цалингийн жишигийг харгалzan;</p> <p>30.2.2.энэ хуулийн 30.2.1-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал болон тухайн компанийн хөрөнгийн хэмжээ, ашигт ажиллагаа, зах зээл дэх хувийн хэвшлийн цалингийн жишигийг харгалzan төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын хорооны санаалаар.</p> <p>30.3.Энэ хуульд өөреөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ адил байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь аудитын хороо болон төлөөлөн удирдах</p>

	<p>зөвлөлийн бусад хороонд ажилласан бол нэмэгдэл урамшуулал авч болно.</p> <p>30.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хуульд заасан цалин, урамшууллаас бусад тусгайлсан хангамж эдлэхгүй.</p> <p>30.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд нөхөн төлбөр, олговор зэрэг аливаа хэлбэрийн тэтгэмж олгохыг хориглоно.</p> <p>30.6.Энэ хуулийн 29.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол урамшуулал тогтоох эрх бүхий этгээдээс төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд урамшуулал олгохыг зогсоох, эсхүл үүргээ биелүүлээгүй, эсхүл хуралдаанд оролцоогүй тухайн хугацаанд хамаарах хувь хэмжээгээр урамшууллын хэмжээг бууруулна.</p> <p>30.7.Энэ хуулийн 30.6-д заасны дагуу урамшуулал олгохыг зогсоох, эсхүл бууруулах арга хэмжээ нь урамшуулал тогтоох эрх бүхий этгээдээс компанийн гүйцэтгэх захиралд хандан энэ тухай бичгээр гаргасан мэдэгдэлд үндэслэнэ.</p> <p>30.8.Төрийн болон орон нутгийн өмчийт компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж, урамшуулал олгох аргачлалыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.</p> <p>30.9.Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллын талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байна.</p>
31.1.Төрийн болон орон нутгийн эзэмшилийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, эсхүл чөлөөлөх санал гаргана.	<p>31.1.1.энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангахгүй болох нь нотлогдсон;</p> <p>31.1.2.хууль, компанийн дүрэмд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, үүргээ ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн, эс үйлдэл хийсэн, ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр удаа дараа хангалтгүй үнэлэгдсэн;</p> <p>31.1.3.гэмт хэрэг үйлдснийг шүүхээс тогтоож, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;</p> <p>31.1.4.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашигласан, компанийн хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцуулэн ашигласан;</p> <p>31.1.5.эрх бүхий байгууллагаас тухайн албан тушаалыг эрхлэхтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрхийг хүчингүй болгосон;</p> <p>31.1.6.үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл байдал бий болсон, өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.</p> <p>31.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн энэ хуулийн 31.1.1, 31.1.2, 31.1.3,</p>

	31.1.4-д заасан үйлдлийн улмаас компанийд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
32.2.Энэ хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигч нь гүйцэтгэх захирлын хэрэгжүүлэх зорилtot түвшний мэдэгдэл боловсруулж, сонгон шалгаруулах комисст хүргүүлнэ.	32.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захиралд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна: 32.1.1.энэ хуулийн 24.1-д заасан шаардлагыг хангасан байх; 32.1.2.бизнесийн удирдлага, хууль, санхүү эсхүл компанийн үйл ажиллагаанд хамаарах салбарын мэдлэг, туршлагатай байх; 32.1.3.өөрийн буруутай үйл ажиллагаанаас төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, захирал, дэд захирлын албан тушаалаас чөлөөлөгдөөгүй байх; 32.1.4.бусад компанийд гүйцэтгэх удирдлагын албан тушаал давхар эрхэлдэггүй байх; 32.1.5.компанийн дүрэмд заасан бусад шаардлага.
35.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлын цалин хөлс, урамшууллын хэмжээг энэ хуулийн 33.1-д заасан гэрээгээр тохиролцно.	35.2.Гэрээнд гүйцэтгэх захирлын нэмэлтээр гүйцэтгэсэн чиг үүргийн үр дүнд компанийн зорилгод нийцсэн нэмүү өртөг бий болсон, компанийн зах зээлд эзлэх байр суурь өсөн нэмэгдсэн бол цалин хөлс, урамшуулал олгохоор зааж болно. 35.3.Гүйцэтгэх захирал гэрээнд зааснаас бусад чиг үүргийг хэрэгжүүлсэн боловч тухайн чиг үүрэгт тохирсон цалин хөлс, урамшуулал олгохоор гэрээнд заагаагүй бол аливаа цалин хөлс, урамшуулал олгохгүй. 35.4.Гүйцэтгэх захирлыг гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө төлөөлөн удирдах зөвлөлийн санаачилгаар чөлөөлөхөөр шийдвэрлэсэн бол түүнд тэтгэмж олгож болно. Тэтгэмжийн хэмжээ гүйцэтгэх захирлын дөрвөн сартай тэнцэх цалин хөлснөөс хэтрэхгүй байна. 35.5.Гүйцэтгэх захирлын цалин хөлс, урамшууллын талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байна.
36.1.Дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлыг ажлаас нь чөлөөлж, гэрээг хугацаанаас нь өмнө цуцална:	36.1.1.үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд компанийг З жил дараалан алдагдал хулээлгэсэн, эсхүл гэрээнд заасан санхүүгийн зорилtot үзүүлэлтийг З жил дараалан хангаж чадахгүй болсон; 36.1.2.компанийн гүйцэтгэлийн үнэлгээ З жил дараалан хангалтгүй гэж үнэлэгдсэн; 36.1.3.компани төлбөрийн чадваргүй болсон талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдээгүй, дампуурлын өргөдөл гаргаагүй;

	<p>36.1.4.хууль болон компанийн дүрэм, гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, ноцтой зөрчсөн;</p> <p>36.1.5.компанийн санхүүгийн байдлын талаар худал мэдээлэл өгсөн;</p> <p>36.1.6.төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан компанийн төсвийг хүндэтгэн үзүүлэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн;</p> <p>36.1.7.гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;</p> <p>36.1.8.энэ хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй болох нь нотлогдсон;</p> <p>36.1.9.компанийн шинэ бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратеги бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, туршлага, чадвар хангалтгүй байх;</p> <p>36.1.10.албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашигласан, компанийн хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашигласан;</p> <p>36.1.11.эрх бүхий байгууллагаас тухайн гүйцэтгэх захирлыг хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрхийг хүчингүй болгосон;</p> <p>36.1.12.үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөл байдал бий болсон, өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;</p> <p>36.1.13.санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 жил дараалан хангалтгүй дүгнэлт авсан;</p> <p>36.1.14.компанийн олж авсан хөрөнгийг компанийн өмчид бүртгээгүй, бүртгэлгүй ашигласан.</p>
37.2.Энэ хуулийн 37.1-д заасан аудитын хорооны дарга нь санхүү, нягтлан бodoх бүртгэлийн мэргэжилтэй, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.	<p>37.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн аудитын тогтолцоо нь төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, дотоод аудитын нэгж, дотоод аудитор, хөндлөнгийн аудитаас бүрдэнэ.</p> <p>37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа нягтлан шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засаг, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаа, санхүүгийн баримтыг хянуулан хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор хөндлөнгийн аудитын</p>
37.3.Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална. Журамд аудитын хороо, гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийн хороонд тогтмол мэдээлэл солилцох арга хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг тусгасан байна.	

37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа нягтлан шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, санхүүгийн баримтыг хянуулан хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор хөндлөнгийн аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр аудит хийлгүүлнэ.

37.10.Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, аудиторын эрх, үүрэг, шалгалт зохион байгуулах хэлбэр, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, дүгнэлт гаргахтай холбогдсон харилцааг хуульд нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын журмаар тогтооно.

хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр аудит хийлгүүлнэ.

37.6.Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр дараах гурван үзүүлэлтийн хоёроос доошгүйг хангаж байвал төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дотоод аудитын нэгжтэй байна:

37.6.1.нийт ашгийн хэмжээ нь 200 сая төгрөгөөс дээш байх;

37.6.2.борлуулалтын орлогын хэмжээ хоёр тэрбум төгрөгөөс дээш байх;

37.6.3.нийт ажилтны тоо 75-аас дээш байх

37.7.Энэ хуулийн 37.6-д заасан нөхцөлөөс доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын нэгжтэй байх нь эдийн засгийн хувьд оновчтой гэж дүгнэсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн зөвшөөрлөөр энэ тухай шийдвэр гаргаж болно.

37.8.Дотоод аудитын нэгж нь компанийн үйл ажиллагааны цар хүрээ, эдийн засгийн үр ашгаас хамааран төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тооны бүтцэд хамаарах тодорхой тооны аудитороос бүрдэнэ.

37.9.Дотоод аудитын нэгж нь тухайн компанийн нэгжийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус шалгалт хийж, дүгнэлт гаргах ба дүгнэлтээ гүйцэтгэх удирдлагад танилцуулж, төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх аудитын хороонд тайлагнана.

37.11.Энэ хуулийн 37.6-д зааснаас доош үзүүлэлттэй төрийн болон орон нутгийн өмчийн компани нь дотоод аудитын нэгжгүй байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн харьяанд дотоод аудитор ажиллана.

38 дугаар зүйл.Компанийн дотоод аудитын чиг үүрэг

38.1.Компанийн дотоод аудитын нэгж, дотоод аудитор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

38.1.1.компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартад нийцэж байгаа эсэх, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээлэл үнэн зөв эсэхийг хянан шалгаж, дүгнэлт өгөх;

38.1.2.компанийн хэтийн зорилго, бизнес төлөвлөгөө, урт хугацааны төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, засаглалын үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах замаар компанийг зорилтоо биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

	<p>38.1.3.компанийн бүх нэгжийн үйл ажиллагаанд ээлжит болон ээлжит бус шалгалт хийж, дүгнэлт гаргах ба дүгнэлтээ төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захиралд танилцуулах;</p> <p>38.1.4.төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>38.1.5.компанийн төсөв, хөрөнгө, нөөцийн ашиглалт, зарцуулалт хэмнэлттэй, үр ашигтай, үр өгөөжтэй байгаа эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;</p> <p>38.1.6.компанийн дүрэм болон компанийн дотоод аудитын дүрэмд заасан бусад.</p>
39.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор энэ хуулийн 33.1-д заасан хугацаанд хэрэгжүүлэх компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлнэ.	
39.2.Гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлийн хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.	
39.3.Гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.	
40.1.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гүйцэтгэх захирлын гэрээний хэрэгжилтийн тайланд үндэслэн жил бүр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлнэ.	40.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 40.1-д заасны дагуу компанийн гүйцэтгэлийн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг ирүүлэхийг компанийн удирдлагаас шаардах эрхтэй.
40.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж, үнэлгээний тайланг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	

<p>41.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн бизнес төлөвлөгөө батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор бизнесийн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.</p> <p>41.2.Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн компанийн хувьд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн компанийн хувьд орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт хүргүүлнэ.</p>	
<p>41.4.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.</p>	
<p>42.1.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.</p> <p>42.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд шаардлагатай бусад мэдээллийг ирүүлэхийг шаардах эрхтэй.</p>	
<p>47.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлнэ.</p>	
<p>49.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8-д заасан болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг өөрийн цахим хуудсанд ил тод байршуулна:</p>	<p>49.1.1.хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;</p> <p>49.1.2.хуулийн этгээдийн зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ, биет, биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;</p> <p>49.1.3.хуулийн этгээдийн сүүлийн таван жилд хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;</p>

49.1.4.хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;
 49.1.5.хуулийн этгээдийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;
 49.1.6.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гэрээ, түүний гүйцэтгэлийг дүгнэсэн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;
 49.1.7.хуулийн этгээдийн эсрэг, эсхүл хуулийн этгээдтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;
 49.1.8.хуулийн этгээдийн дүрэм, хуулийн этгээдийн үйл ажиллагааны болон засаглалын дотоод журам;
 49.1.9.тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын мэдээлэл, хэрэгжилтийн байдал;
 49.1.10.бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын болон нийлүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал, хэрэгжилтийн явц;
 49.1.11.Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;
 49.1.12.байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;
 49.1.13.тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;
 49.1.14.төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан дэмжлэг, хандив, тусламж.

Тус хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн зүйл заалтад өөрчлөлт орсон болон нэмж туссан, хуулийн этгээдийн зардалд нөлөөлөх зүйл заалтыг дээрх хүснэгтээр харуулав.

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцоходоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтахгүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг судалгааны арга ашиглан тухайн үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно.

Хүснэгт 11. Хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэг, стандарт үйл ажиллагаа

Гүйцэтгэх хуулийн этгээд	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
--------------------------	----------------------	------------------------

	<p>Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу үнэт цаас гаргана.</p>	<p>1. Үнэт цаас гаргах үйл ажиллагаа зохион байгуулах</p>
Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	<p>Орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан тохиолдолд энэ хуулийн 21.3-т заасан мэдээллийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.</p>	<p>1. Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, бэлтгэх 2. Мэдээллийг хүргүүлэх</p>
	<p>Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах шийдвэр гарсан, эсхүл сул орон гарснаас хойш ажлын таван өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах захиалгыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>1. Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх 2. Захиалгыг хүргүүлэх</p>
	<p>Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газар зохион байгуулна. Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасныг баримтална.</p>	<p>1. Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх 2. Захиалгыг хүргүүлэх</p>

	<p>Энэ хуулийн 25.3, 25.6-д заасны дагуу санал болгосон нэр дэвшигчийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 24.1-д заасан шаардлага хангасан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гишүүнээр томилно.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулхаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал болгоно.</p>	<p>1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгох үйл ажиллагааг зохион байгуулах</p>
	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн цалин, урамшууллын хэмжээний талаар журмын төслийг боловсруулах</p> <p>2. Журмын төслийг батлах</p>	
	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах журмаар тогтооно</p> <p>Төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, эсхүл чөлөөлөх санал гаргана.</p>	<p>1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх шийдвэр гаргах</p>
	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланд үндэслэн жил бүр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлнэ.</p>	<p>1. Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулах</p>
	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж, үнэлгээний тайланг тухайн компанийн төрийн, эсхүл орон нутгийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн</p>	<p>1. Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлсэн тайланг хариуцсан нэгжид хүргүүлэх</p>

	өмчийн асуудал хариуцсан нэгжид танилцуулна.	
	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гүйцэтгэх захирлын гэрээний хэрэгжилтийн тайланд үндэслэн жил бүр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлнэ. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.	1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх, хүргүүлэх
	Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгжид төр, эсхүл орон нутгийн хувьцаа эзэмших зорилго, хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг жил бүр хүргүүлнэ.	1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх 2. Хувьцааны талаар илтгэлийг хүргүүлэх
Төрийн болон орон нутгийн өмчит компани	Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа нягтлан шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, санхүүгийн баримтыг хянуулан хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор хөндлөнгийн аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр аудит хийлгүүлнэ. Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, аудиторын эрх, үүрэг, шалгалт зохион байгуулах хэлбэр, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, дүгнэлт гаргахтай холбогдсон харилцааг хуульд нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын журмаар тогтооно.	1. Аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах 2. Аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх
	Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлнэ.	1. Санхүүгийн тайлан гаргаж хүргүүлэх 2. Үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлэх

	<p>Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8-д заасан болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг өөрийн цахим хуудсанд ил тод байршуулна:</p>	<p>1. Компанийн тухай мэдээллийг цахим хуудсанд нийтлэх</p>
	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлын цалин хөлс, урамшууллын хэмжээг энэ хуулийн 33.1-д заасан гэрээгээр тохиролцоно.</p>	<p>1. Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах</p>
	<p>Дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлыг ажлаас нь чөлөөлж, гэрээг хугацаанаас нь өмнө цуцална:</p>	<p>1. Гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлөх</p>
	<p>Энэ хуулийн 37.1-д заасан аудитын хорооны дарга нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.</p>	<p>1. Аудитын хороог зохион байгуулах</p>
Төлөөлөн удирдах зөвлөл	<p>Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална. Журамд аудитын хороо, гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийн хороонд тогтмол мэдээлэл солилцох арга хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг тусгасан байна.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн бизнес төлөвлөгөө батлагдсанаас хойш ажлын 10 едрийн дотор бизнесийн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.</p> <p>Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн компанийн хувьд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн компанийн хувьд орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт хүргүүлнэ.</p>	<p>1. Аудитын хорооны журмыг боловсруулах</p> <p>2. Аудитын хорооны журмыг батлах</p> <p>1. Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулах</p> <p>2. Бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх</p> <p>3. Төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх</p>

	Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.	1. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг боловсруулах 2. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хүргүүлэх
	Энэ хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигч нь гүйцэтгэх захирлын хэрэгжүүлэх зорилтот түвшний мэдэгдэл боловсруулж, сонгон шалгаруулах комисст хүргүүлнэ.	1. Зорилтот түвшний мэдэгдлийг боловсруулах 2. Зорилтот түвшний мэдэгдлийг хүргүүлэх
	Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор энэ хуулийн 33.1-д заасан хугацаанд хэрэгжүүлэх компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлнэ.	1.Компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулах 2.Бизнесийн төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлэх
Гүйцэтгэх захирал	Гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлийн хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ. Гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.	1. Хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх 1.Компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг хүргүүлэх

2.2. Зардал тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана. Хуулийн этгээдийн зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тус бүрд зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

Зардлыг тооцоходо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
2. Тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох;
3. Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох.

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтахгүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг судалгааны арга ашиглан тухайн үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно. Цаг хугацааг тооцохдоо зарцуулах хугацааг минутаар тооцож гаргана. Өмнөх хэсэгт хуулийн төсөлд тусгагдсан үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлсон. Иймд энэхүү хэсэгт тус хэсэгт тухайн үйлдэлд зарцуулагдах хугацаа, ажлын хөлсийг тодорхойлж гарч болох зардлыг тооцно.

Хугацааг тооцох

Хугацааг тодорхойлохдоо өөрсдийн тогтоосон стандарт үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний цаг хугацаа зарцуулахыг минутаар тооцоолж гаргана. Тухайн судалгаанд стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг тооцохдоо Засгийн газрын 59-р тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын гарын авлага"¹⁴-д заасан жишиг хугацааг баримталлаа.

Хүснэгт 12. Хуулийн этгээдийн гүйцэтгэх стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа

Гүйцэтгэх байгууллага	Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/
	Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдэгдэж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу үнэт цаас гаргана.	Үнэт цаас гаргах үйл ажиллагаа зохион байгуулах	2400
Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	Орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан тохиолдолд энэ хуулийн 21.3-т заасан мэдээллийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.	Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах	1440
	Төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан тохиолдолд хувьцаа	Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, бэлтгэх	480

¹⁴ Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы хамтын ажиллагааны байгууллага (GIZ), Хууль тогтоомжийн тухай хууль аргачлал, гарын авлага, 243-244 дэх тал.

	эзэмшигчдийн хурлын шийдвэр, хурлын тэмдэглэлийн хуулбар, төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагаа хамаарах салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	Мэдээллийг хүргүүлэх	
	Орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан тохиолдолд энэ хуулийн 21.3-т заасан мэдээллийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.	Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, бэлтгэх	240
	Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах шийдвэр гарсан, эсхүл сул орон гарснаас хойш ажлын таван өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах захиалгыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх	480
	Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийг үүсгэн байгуулах шийдвэр гарсан, эсхүл сул орон гарснаас хойш ажлын таван өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах захиалгыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	Захиалгыг хүргүүлэх	240
	Энэ хуулийн 25.3, 25.6-д заасны дагуу санал болгосон нэр дэвшигчийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч энэ хуулийн 24.1-д заасан шаардлага хангасан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гишүүнээр томилно. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар	Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх	480
		Захиалгыг хүргүүлэх	240
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгох үйл ажиллагааг зохион байгуулах	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгох үйл ажиллагааг зохион байгуулах	1440

	хувьцаа эзэмшигчдийн хуралд санал болгоно.		
	Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн цалин, урамшуулалт авч болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах журмаар тогтооно	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээний талаар журмын төслийг боловсруулах	1440
	Төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, эсхүл чөлөөлөх санал гаргана.	Журмын төслийг батлах	480
	Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайландаа үндэслэн жил бүр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлнэ.	Төлөөлөн удирдах зөвлөлийн чөлөөлөх гишүүнийг шийдвэр гаргах	480
	Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж, үнэлгээний тайланг тухайн компанийн төрийн, эсхүл орон нутгийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгжид танилцуулна.	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулах	1440
	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч компанийн бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гүйцэтгэх захирлын гэрээний хэрэгжилтийн тайландаа үндэслэн жил бүр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийг үнэлнэ.	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлсэн тайланг хариуцсан нэгжид хүргүүлэх	480
	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг үнэлэх	480
	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх	1440

Төрийн болон орон нутгийн өмчтүүлэх компани	Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшилийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгжид төр, эсхүл орон нутгийн хувьцаа эзэмших зорилго, хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг жил бүр хүргүүлнэ.	Хувьцааны удирдлагын талаар илтгэлийг бэлтгэх	480
		Хувьцааны талаар илтгэлийг хүргүүлэх	240
	Төрийн болон орон нутгийн өмчийн компани нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлнэ. Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, аудиторын эрх, үүрэг, шалгалт зохион байгуулах хэлбэр, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, дүгнэлт гаргахтай холбогдсон харилцааг хуульд нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөл дотоод аудитын журмаар тогтооно.	Аудитын этгээдийг шалгаруулах	1440
		Аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх	2400
		Санхүүгийн тайлан гаргаж хүргүүлэх	1440
Төлөөлөн удирдах зөвлөл	Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлын цалин хөлс, урамшууллын хэмжээг энэ хуулийн 33.1-д заасан гэрээгээр тохиролцено. Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд түүний цалин хөлс, урамшууллын хэмжээ, түүнийг олгох журмыг тогтооно.	Үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлэх	480
		Компанийн тухай мэдээллийг цахим хуудсанд нийтлэх	480
	Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох журмыг боловсруулах	1440	
		Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох журмыг батлах	480
	Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах	480	

	Дараах тохиолддолд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлыг ажлаас нь чөлөөлж, гэрээг хугацаанаас нь өмнө цуцална: Энэ хуулийн 37.1-д заасан аудитын хорооны дарга нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.	Гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлөх	480
	Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална. Журамд аудитын хороо, гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийн хороонд тогтмол мэдээлэл солилцох арга хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг тусгасан байна.	Аудитын хорооны боловсруулах	480
	Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална. Журамд аудитын хороо, гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийн хороонд тогтмол мэдээлэл солилцох арга хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг тусгасан байна.	Аудитын хорооны боловсруулах	960
	Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн бизнес төлөвлөгөө батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор бизнесийн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ. Энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн компанийн хувьд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн компанийн хувьд орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газарт хүргүүлнэ.	Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулах	960
	Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.	Бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	240
	Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 41.1-д заасан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр гаргаж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.	Төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх	240
	Төлөөлөгөөний гүйцэтгэлийн тайланг боловсруулах	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хүргүүлэх	480
	Энэ хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигч нь гүйцэтгэх захирлын хэрэгжүүлэх зорилтот түвшний мэдэгдэл боловсруулж, сонгон шалгаруулах комисст хүргүүлнэ.	Зорилтот түвшний мэдэгдлийг боловсруулах	480
	Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор	Зорилтот түвшний мэдэгдлийг хүргүүлэх	240
Гүйцэтгэх захирал	Компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулах	Компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулах	480

энэ хуулийн 33.1-д заасан хугацаанд хэрэгжүүлэх компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлнэ.	Бизнесийн төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлэх	240
Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор энэ хуулийн 33.1-д заасан хугацаанд хэрэгжүүлэх компанийн бизнесийн төлөвлөгөөг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлнэ.	Хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	240
Гүйцэтгэх захирал компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.	Компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг хүргүүлэх	240

Ажлын хөлсийг тооцох

Ажлын хөлсийг тогтоохдоо аж ахуйн нэгжид ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсийг баримжаалан тооцох бөгөөд зарим тохиолдолд тусгай мэдлэг, мэргэжил, ур чадвар шаардсан үйл ажиллагаанд өндөр цалин, хангамж олгож буй тохиолдлыг анхаарч авч үздэг.

Мөн нэг сард ажиллах хугацааг тооцож гарган үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааснаар тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг тооцож гаргана.

Хүснэгт 13. Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин¹⁵

2024-II	
Аж ахуй нэгж байгууллагын сарын дундаж цалин	2,464,900

Аж ахуй нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол ёссэн үзүүлэлтэй байна. Тус судалгааны хувьд хамгийн сүүлийн үеийн үзүүлэлтээр ажиллагсдын сарын дундаж цалин хөлсийг 2,464,900 төгрөг байхаар тооцож, ажиллах хугацааг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байхаар тооцлоо. Үүнээс харахад нэг ажилтан нэг сард ажлын 22 өдөр /22*8=176 цаг, 176*60=10560 минут/ ажилладаг байна.

¹⁵ Аж ахуй нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0400_021V1&SOU=select_all=0&SOU=MSingleSelect=0&Gender=select_all=0&GenderSingleSelect=1&YearQ=select_all=0&YearQSingleSelect=202402&YearY=select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table

Үндсэн цалин / Ажиллах хугацаа = Ажлын хөлс /төгрөг/

2,464,900 / 176 цаг = 14,005 төгрөг /цагт/

2,464,900 / 10560 минут = 233 төгрөг /минт/

Хүснэгт 14. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны зардал буюу төрийн болон орон нутгийн өмчийт компанийн ажилтнуудын зардал

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /минт/	Ажлын хөлс	Зардал
Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	Үнэт цаас гаргах үйл ажиллагаа зохион байгуулах	2400	233	559,200
	Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах	1440	233	335,520
	Танилцуулгыг мэдэгдэх	480	233	111,840
	Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, бэлтгэх	480	233	111,840
	Мэдээллийг хүргүүлэх	240	233	55,920
	Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, бэлтгэх	480	233	111,840
	Мэдээллийг хүргүүлэх	240	233	55,920
	Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх	480	233	111,840
	Захиалгыг хүргүүлэх	240	233	55,920
	Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх	480	233	111,840
	Захиалгыг хүргүүлэх	240	233	55,920
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгох үйл ажиллагааг зохион байгуулах	1440	233	335,520
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээний талаар журмын төслийг боловсруулах	1440	233	335,520
	Журмын төслийг батлах	480	233	111,840
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх шийдвэр гаргах	480	233	111,840
	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулах	1440	233	335,520
	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлсэн тайланг хариуцсан нэгжид хүргүүлэх	480	233	111,840
	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг үнэлэх	480	233	111,840

	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх	1440	233	335,520
	Хувьцааны удирдлагын талаар илтгэлийг бэлтгэх	480	233	111,840
	Хувьцааны талаар илтгэлийг хүргүүлэх	240	233	55,920
	Аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах	1440	233	335,520
	Аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх	2400	233	559,200
Төрийн болон орон нутгийн өмчit компани	Санхүүгийн тайлан гаргаж хүргүүлэх	1440	233	335,520
	Үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлэх	480	233	111,840
	Компанийн тухай мэдээллийг цахим хуудсанд нийтлэх	480	233	111,840
	Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох журмыг боловсруулах	1440	233	335,520
	Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох журмыг батлах	480	233	111,840
	Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах	480	233	111,840
	Гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлөх	480	233	111,840
	Аудитын хороог зохион байгуулах	480	233	111,840
	Аудитын хорооны журмыг боловсруулах	960	233	223,680
Төлөөлөн удирдах зөвлөл	Аудитын хорооны журмыг батлах	480	233	111,840
	Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулах	960	233	223,680
	Бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	240	233	55,920
	Төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх	240	233	55,920
	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг боловсруулах	480	233	111,840
	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хүргүүлэх	240	233	55,920
	Зорилтот түвшний мэдэгдлийг боловсруулах	480	233	111,840
	Зорилтот түвшний мэдэгдлийг хүргүүлэх	240	233	55,920
Гүйцэтгэх захирал	Компанийн бизнесийн төлөвлөгөөг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулах	480	233	111,840
	Бизнесийн төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлэх	240	233	55,920

Хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	240	233	55,920
Компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу бэлдэж хүргүүлэх	240	233	55,920

2.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хэчинээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцоходоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үргүүлнэ. Тоон үзүүлэлтийг тооцоходоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Дээрх чиг үүргийн тохиолдлын тоог тогтоох боломжтой гэж үзэж, энэхүү зардлын тооцооны тайлангийн 1 дэх хэсэгт заасан статистикийг ашиглан тогтоолоо.

Тохиолдлын тоо:

Тохиолдлын тоо гэдэг нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгаагаар илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл тусгай зөвшөөрлийн тоогоор тохиолдлын тоог гаргана. Мэдээлэл хүргүүлэх үүргийн тухайд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоогоор илэрхийлж гаргана.

1. "2023 оны Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд"-д зааснаар¹⁶ төрийн өмчийн хуулийн этгээдийн тоо 99 байх бөгөөд түүний 71¹⁷ нь ТӨХК, ТӨХХК, ТӨОК байна. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлд холбогдох мэдээнүүд зөрүүтэй байх боловч хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар 13 хувьцаат, 31 хязгаарлагдмал хариуцлагатай компани, нийт 44 байна. Харин төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч 21 байхаар тооцлоо.

Хүснэгт. 15 Хуулийн этгээдийн тохиолдлын тоо

№	Тохиолдол	Тохиолдлын тоо
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	21
2	Төрийн өмчит компани	71
3	Орон нутгийн өмчит компани	44

Давтамжийн тоо:

Давтамж нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуй нэгж, байгууллага нэг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг харуулсан тоо юм. Тооцооны нэгж нь нэг жил байна. Энэхүү хуулийн төслийн зохицуулалтын хүрээнд мэдээллийг хүргүүлж байх хугацааг заагаагүй ба тухай бүр гаргаж байхаар зохицуулсан байна. Тиймээс давтамжийг 1 гэж авна.

¹⁶ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, https://pcsp.gov.mn/files/statistic/FR_BOOK_2023_Final.pdf

¹⁷ Үүнд охин компанийг оруулаагүй болно.

Хүснэгт 16. Хуулийн этгээдийн гүйцэтгэх стандарт үйл ажиллагааны тоон
үзүүлэлт

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
	Үнэт цаас гаргах үйл ажиллагаа зохион байгуулах	21	1	21
	Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах	21	1	21
	Танилцуулгыг мэдэгдэх	21	1	21
	Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, бэлтгэх	21	1	21
	Мэдээллийг хүргүүлэх	21	1	21
	Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, бэлтгэх	21	1	21
	Мэдээллийг хүргүүлэх	21	1	21
	Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх	21	1	21
	Захиалгыг хүргүүлэх	21	1	21
	Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх	21	1	21
	Захиалгыг хүргүүлэх	21	1	21
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгох үйл ажиллагааг зохион байгуулах	21	1	21
Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээний талаар журмын төслийг боловсруулах	21	1	21
	Журмын төслийг батлах	21	1	21
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх шийдвэр гаргах	21	1	21
	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулах	21	1	21
	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлсэн тайланг хариуцсан нэгжид хүргүүлэх	21	1	21
	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг үнэлэх	21	1	21
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх	21	1	21

	Хувьцааны удирдлагын талаар илтгэлийг бэлтгэх	21	1	21
	Хувьцааны талаар илтгэлийг хүргүүлэх	21	1	21
Төрийн болон орон нутгийн өмчийт компани	Аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах	115	1	115
	Аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх	115	1	115
	Санхүүгийн тайлан гаргаж хүргүүлэх	115	1	115
	Үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлэх	115	1	115
	Компанийн тухай мэдээллийг цахим хуудсанд нийтлэх	115	1	115
	Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох журмыг боловсруулах	115	1	115
	Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох журмыг батлах	115	1	115
	Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах	115	1	115
	Гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлөх	115	1	115
	Аудитын хороог зохион байгуулах	115	1	115
Төлөөлөн удирдах зөвлөл	Аудитын хорооны журмыг боловсруулах	115	1	115
	Аудитын хорооны журмыг батлах	115	1	115
	Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулах	115	1	115
	Бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	115	1	115
	Төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх	115	1	115
Гүйцэтгэх захирал	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг боловсруулах	115	1	115
	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хүргүүлэх	115	1	115
	Зорилтот түвшний мэдэгдлийг боловсруулах	115	1	115
	Зорилтот түвшний мэдэгдлийг хүргүүлэх	115	1	115
	Компанийн бизнесийн төлөвлөгөөг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулах	115	1	115
	Бизнесийн төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлэх	115	1	115

Хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	115	1	115
Компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу бэлдэж хүргүүлэх	115	1	115

2.4. Зардлын дүнг тооцож гаргах

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

Хүснэгт 17. Хуулийн этгээдийн нийт зардлын дун

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Нэг бүрийн зардал	Нийт зардал
Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	Үнэт цаас гаргах үйл ажиллагаа зохион байгуулах	21	559,200	11,743,200
	Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах	21	335,520	7,045,920
	Танилцуулгыг мэдэгдэх	21	111,840	2,348,640
	Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, бэлтгэх	21	111,840	2,348,640
	Мэдээллийг хүргүүлэх	21	55,920	1,174,320
	Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, бэлтгэх	21	111,840	2,348,640
	Мэдээллийг хүргүүлэх	21	55,920	1,174,320
	Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх	21	111,840	2,348,640
	Захиалгыг хүргүүлэх	21	55,920	1,174,320
	Сонгон шалгаруулах захиалгыг бэлтгэх	21	111,840	2,348,640
	Захиалгыг хүргүүлэх	21	55,920	1,174,320
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгох үйл ажиллагааг зохион байгуулах	21	335,520	7,045,920
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээний талаар журмын төслийг боловсруулах	21	335,520	7,045,920
	Журмын төслийг батлах	21	111,840	2,348,640
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх шийдвэр гаргах	21	111,840	2,348,640

	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулах	21	335,520	7,045,920
	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийг үнэлсэн тайланг хариуцсан нэгжид хүргүүлэх	21	111,840	2,348,640
	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг үнэлэх	21	111,840	2,348,640
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх	21	335,520	7,045,920
	Хувьцааны удирдлагын талаар илтгэлийг бэлтгэх	21	111,840	2,348,640
	Хувьцааны талаар илтгэлийг хүргүүлэх	21	55,920	1,174,320
	Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн зардал		76,330,800	
Төрийн болон орон нутгийн өмчийн компани	Аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах	115	335,520	38,584,800
	Аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх	115	559,200	64,308,000
	Санхүүгийн тайлан гаргаж хүргүүлэх	115	335,520	38,584,800
	Үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлэх	115	111,840	12,861,600
	Компанийн тухай мэдээллийг цахим хуудсанд нийтлэх	115	111,840	12,861,600
	Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн зардал		167,200,800	
Төлөөлөн удирдах зөвлөл	Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох журмыг боловсруулах	115	335,520	38,584,800
	Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, сонгох журмыг батлах	115	111,840	12,861,600
	Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах	115	111,840	12,861,600
	Гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлөх	115	111,840	12,861,600
	Аудитын хороог зохион байгуулах	115	111,840	12,861,600
	Аудитын хорооны журмыг боловсруулах	115	223,680	25,723,200
	Аудитын хорооны журмыг батлах	115	111,840	12,861,600
	Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулах	115	223,680	25,723,200
	Бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	115	55,920	6,430,800

	Төлөвлөгөөний хувийг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх	115	55,920	6,430,800
	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг боловсруулах	115	111,840	12,861,600
	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хүргүүлэх	115	55,920	6,430,800
Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал				186,493,200
	Зорилтот түвшний мэдэгдлийг боловсруулах	115	111,840	12,861,600
	Зорилтот түвшний мэдэгдлийг хүргүүлэх	115	55,920	6,430,800
	Компанийн бизнесийн төлөвлөгөөг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулах	115	111,840	12,861,600
	Бизнесийн төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлд хянуулахаар хүргүүлэх	115	55,920	6,430,800
	Хянаж, баталсан бизнесийн төлөвлөгөөг хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлэх	115	55,920	6,430,800
	Компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гэрээний хэрэгжилтийн тайланг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу бэлдэж хүргүүлэх	115	55,920	6,430,800
Гүйцэтгэх захирлын зардал				51,446,400
Нийт зардал:				481,471,200

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд дунджаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааны зардалд **76,330,800**, төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны зардалд **167,200,800**, төлөөлөн удирдах зөвлөлийн зардалд **186,493,200**, гүйцэтгэх захирлын зардалд **51,446,400** төгрөг тус тус нэмэлтээр зарцуулагдахаар байгаа ба нийт хуулийн этгээдээс **481,471,200** /Дөрвөн зуун наян нэгэн сая дөрвөн зуун далан нэгэн мянга хоёр зуу/ төгрөгийн зардал гарахаар байна.

2.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Хялбарчлах боломжийг шалгах өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

2.5.1. Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх;

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын 2023 оны судалгаанаас үзэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч 21, төрийн өмчийн компани 71, орон нутгийн өмчийн компани 44 тус тус бүртгэгдсэн гэж авч үзсэн. Гэвч энэхүү тоо нь хэлбэлзэх боломжтой тул багасгах боломж байгаа гэж үзнэ.

2.5.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн тухай хуулийн төсөлд хуулийн этгээдийн чиг үүргийн давтамжийг тодорхой тусгаагүй байна. Тиймээс тус судалгаанд давтамжийн тоог нэгээр авч үзсэн тул мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломжгүй байна.

2.5.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх

Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн тухай хуулийн төсөлд хуулийн этгээдийн чиг үүргийг хавсруулах болон нэгтгэх байдлаар гүйцэтгэх боломжтой тул мэдээллийн агуулгыг багасгах боломжтой.

2.5.4. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн тухай хуулийн төсөлд тайлан, төлөвлөгөө, мэдээлэл зэргийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх зэрэг чиг үүргүүдийг цахимаар хүргүүлэх боломжтой тул зардал багасах боломжтой байна.

2.6. Нэмэлт зардлыг тооцох

Төрийн болон орон нутгийн өмчтэй компанийн тухай хуулийн төслийн хүрээнд компанийн тухай мэдээллийг цахим хуудсанд нийтлэх чиг үүргийг тусгасан ба энэхүү чиг үүргийг гүйцэтгэхэд төрийн болон орон нутгийн өмчтэй компани бүрт цахим тоног, төхөөрөмжтэй холбоотой материаллаг зардал гарж болзошгүй. Өөрөөр хэлбэл төрийн болон орон нутгийн өмчтэй компани нь өөрийн мэдээллийг цахим хуудсанд оруулах, цахим хуудас хөгжүүлэх зардал гарах боломжтой. Иймд тус зардалд дунджаар **3,000,000** төгрөг зарцуулна гэж үзвэл нийт 115 компанийд **345,000,000** төгрөгийн зардал гарах боломжтой байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн төсөлд зардлын тооцоо хийх нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох зорилготой байдаг. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төр, хуулийн этгээд, иргэдэд учрах зардлыг урьдчилан тодорхойлох, цаашид ачааллыг аль болох багасгах санал боловсруулах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Нэг. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Засгийн газар, ЗГХЭГ, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, ИТХ-ын ачаалал тодорхой хэмжээгээр нэмэгдэх боловч хуулийн төсөл дээрх төрийн байгууллагын үйл ажиллагаанд төдийлэн нөлөө үзүүлэхгүй. Харин төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн нэгжийн ачаалал дор зааснаар нэмэгдэх төлөвтэй байна. Тухайлбал, хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 3, аймаг, нийслэл дэх орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн нэгж тус бүрт 3 албан хаагч нэмэгдэхээр байх бөгөөд албан хаагч бүрийн хүний нөөцийн болон материаллаг зардалд 27,365,429 төгрөг зарцуулагдана. Гэвч дээрх байгууллагуудын одоо байгаа бүтэц, орон тоо, бусад нөөцийг үр дүнтэй зохион байгуулж, нэмэгдэх ачаалалтай холбогdon үүсэх зардлыг бууруулах боломжтой гэж үзэж байна.

Хоёр. Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд дунджаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааны зардалд 76,330,800, төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны зардалд 167,200,800, төлөөлөн удирдах зөвлөлийн зардалд 186,493,200, гүйцэтгэх захирлын зардалд 51,446,400 төгрөг тус тус нэмэлтээр зарцуулагдахаар байгаа ба нийт хуулийн этгээдээс 481,471,200 /Дөрвөн зуун наян нэгэн сая дөрвөн зуун далан нэгэн мянга хоёр зуу/ төгрөгийн зардал гарахаар байна. Гэвч дээрх зардал нь шууд үүсэх зардал биш бөгөөд гагцхүү хуулийн төсөлд заасан чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай хугацааг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдал гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хуулийн төсөл батлагдаж компаниудын үйл ажиллагаа жигдрэх тусам зарцуулах хугацаа багасаж, зардлын үзүүлэлт буурна.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн хүрээнд компанийн тухай мэдээллийг цахим хуудсанд нийтлэх чиг үүргийг тусгасан ба энэхүү чиг үүргийг гүйцэтгэхэд төрийн болон орон нутгийн өмчит компани бүрт цахим тоног, техөөрөмжтэй холбоотой материаллаг зардал гарж болзошгүй. Өөрөөр хэлбэл төрийн болон орон нутгийн өмчит компани нь өөрийн мэдээллийг цахим хуудсанд оруулах, цахим хуудас хөгжүүлэх зардал гарах боломжтой. Иймд тус зардалд дунджаар 3,000,000 төгрөг зарцуулна гэж үзвэл нийт 115 компанийд 345,000,000 төгрөгийн зардал гарах боломжтой байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны судалгааг үндэслэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч 21, төрийн өмчийн компани 71, орон нутгийн өмчийн компани 44 тус тус бүртгэгдсэн гэж үзэн судалгаанд тодорхойлсон. Гэвч энэхүү тоо нь хэлбэлзэх боломжтой тул багасгах боломж байгаа гэж үзнэ. Мөн хуулийн төсөлд хуулийн этгээдийн чиг үүргийн давтамжийг тодорхой тусгаагүй байна. Тиймээс тус судалгаанд давтамжийн тоог нэгээр авч үзсэн тул мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломжгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд хуулийн этгээдийн чиг үүргийг хавсруулах болон нэгтгэх байдлаар гүйцэтгэх боломжтой тул мэдээллийн агуулгыг багасгах боломжтой. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд тайлан, төлөвлөгөө, мэдээлэл зэргийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх зэрэг чиг үүргүүдийг цахимаар хүргүүлэх боломжтой тул зардал багасах боломжтой байна.

Гурав. Иргэнд үүсэх зардлын тооцоо

Удиртгал хэсэгт дурдсанаар тус хуулийн төсөл иргэнд аливаа зардал үүсгэхгүй.

Дөрөв. Зардал-үр өгөөжийн үнэлгээ

Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн зардал өндөр, эзэмшиж буй хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй харьцуулахад ашигт ажиллагаа, өгөөжийн түвшин бага, санхүүгийн сахилга бат сул, үр ашиггүй, ихээхэн хэмжээний алдагдалтай ажилладаг байдал нь холбогдох хуулийн төсөл боловсруулагдах практик шаардлагын нэгд зүй ёсоор хамаарна. Тухайлбал, 2023 онд л гэхэд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 43% нь алдагдалтай ажилласан, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьд 13 хувьцаат компани 21.6 тэрбум төгрөг, 31 хязгаарлагдмал хариуцлагатай компани 18 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан зэрэг дүн мэдээ гарсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зардал тодорхой хэмжээгээр нэмэгдэх боловч компанийг үүсгэн байгуулахдаа тооцоо, судалгаанд үндэслэх, хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн оролцоонд тулгуурлах, засаглалыг сайжруулах, ил тод байдлыг хангах, цаашлаад гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажлын гүйцэтгэл, компанийн бизнес төлөвлөгөө, үндэслэл, шаардлага, үр өгөөжийг үнэлэх, хянах тогтолцоог сайжруулах нь дээрх компаниудын үр өгөөжийг ихэсгэх, алдагдлыг бууруулахад чухал нөлөөтэй. Иймд дээр дурдсан зардлыг хуулийн төслийн үр өгөөжтэй харьцуулахад үр өгөөж нь илүү байна гэж үзэж хуулийн төслийн улмаас үүсэх нэмэлт зардлыг хүлээн зөвшөөрөгдөхүйц гэж дүгнэв.

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нь 1996 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан бөгөөд нийт 89 зүйл, 268 хэсэг, 270 заалттай болно. Өнгөрсөн 21 жилийн хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 27 удаагийн нэмэлт, өөрчлөлт орж, нийт 217 зүйл, хэсэг, заалт өөрчлөгдсөн байна.¹ Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг Улсын дээд шүүхээс тайлбарласан байна.²

Нэг. Үнэлгээ хийх болсон шалтгаан

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт дараах шалтгаанаар үнэлгээ хийлгээ:

-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхийг тодорхойлох;

-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон;

-терийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн өмчийн газраас төрийн өмчийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох талаар санал авах, үйл ажиллагаанд нь учирч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор санал авсан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ирүүлсэн саналыг нэгтгэн судалж үзэхэд, дараах асуудлыг хөндсөн байна:³

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн хяналтын тогтолцоог сайжруулах;

1.1. төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг Компанийн тухай хуультай нийцүүлэх, хяналтын тогтолцоотой болгох (ТҮЗ);

1.2. бусад хуультай нийцүүлэх;

¹ -Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон талаар хийсэн судалгаанаас дэлгэрүүлж үзнэ үү.

² -Улсын дээд шүүхийн 1997 оны 146, 237 дугаар, 1999 оны 79 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1, 56 дугаар зүйлийн 1, 28 дугаар зүйлийн 4, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус тайлбарласан байна.

³ -Төрийн өмчит хуулийн этгээдээс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад асуудлаар ирүүлсэн саналын тухай танилцуулга, материалыаас дэлгэрүүлж үзнэ үү.

1.3.төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, сонгон шалгаруулалтаар томилдог болох.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статус, үйл ажиллагаатай холбоотой;

2.1.төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статусыг тодорхой болгох, бэхжүүлэх, төрийн өмчийн удирдлагыг тогтвортой, нэгдмэл, төвлөрсөн байлгах;

2.2.төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах, хөрөнгийн харилцааг зохицуулж байгаа журам, дүрэм, эрх зүйн актыг шинэчлэх, боловсронгуй болгох

3.Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх зохицуулалтыг боловсронгуй болгох;

3.1.нэр томьёо, төлөөлөл хэрэгжүүлэх журмыг тодорхой болгох;

3.2.төлөөлөл хэрэгжүүлэх ажилтныг сонгон шалгаруулах.

Түүнчлэн орон нутгийн Өмчийн газраас ирүүлсэн саналыг судалж үзэхэд, дараах асуудлыг хамгийн ихээр хөндсөн байна:⁴

1.Орон нутгийн өмчийн газрын статусыг тодорхой, тогтвортой болгох;

2.Орон нутгийн өмчийн газрын ажилтан улсын байцаагчийн эрхтэй байх;

3.Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон өмчийн газрын хоорондын харилцааг тодорхой болгон зохицуулах;

4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас орон нутгийн шууд удирдлагаар хангадаг болох гэх мэт.

Төрийн өмчит хуулийн этгээд болон орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн саналд үндэслэн төрийн өмчит хуулийн этгээдийн хяналтын тогтолцоо, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статус, үйл ажиллагаа, орон нутгийн өмчийн асуудал, орон нутгийн өмчийн газрын статус, үйл ажиллагаа болон төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхийг тогтоохоор хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийлээ.

Хоёр. Үнэлгээний хүрээ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хийх үнэлгээний хүрээг дээр дурдсан үнэлгээ хийх зорилго, шалтгаанд тулгуурлан агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх байдлыг харгалзан:

-нэгдүгээр бүлэг нийтлэг үндэслэл;

⁴ -Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн саналын нэгтгэл материалыаас дэлгэрүүлж үзнэ үү.

- гуравдугаар бүлэг төрийн өмчийн удирдлага;
- дөрөвдүгээр бүлэг төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх;
- зургадугаар бүлэг төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах;
- есдүгээр бүлэг орон нутгийн өмчийн зүйлс гэсэн 5 бүлэг, түүний холбогдох зүйл, хэсэг, заалтаар тодорхойллоо.

Гурав. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хийх үнэлгээг зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтээр хийхээр тогтов. Учир нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш гарсан зардлыг тооцоолох боломжгүй тул зардлын өсөлт, бууралт болон зардал-үр өгөөжийн харьцаа гэсэн шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь үр дүнгүй юм. Түүнчлэн зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтээр хуулийг хэрэгжүүлэхтэй холбогdon үүсч байгаа асуудал, бэрхшээлийг тодорхойлох боломжтой гэж үзлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн нэгдүгээр бүлэг нийтлэг үндэслэл, зургадугаар бүлэг төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах гэсэн хэсгийг зорилгод хүрсэн түвшингээр, гуравдугаар бүлэг төрийн өмчийн удирдлага, дөрөвдүгээр бүлэг төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх хэсгийг практикт нийцэж байгаа байдлаар, есдүгээр бүлэг орон нутгийн өмчийн зүйлс хэсгийг хүлээн зөвшөөрөгдсөн байдал гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Дөрөв. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Үнэлгээний хамрах хүрээг дээр дурдсан үнэлгээний шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш болон тохиолдол судлах гэсэн харьцуулах хэлбэрээр харьцуулж үзэхээр тогтох, шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар томьёолов.

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох	Шалгуур үзүүлэлтийг томьёолох
Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл - Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаархи бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохад холбогдсон харилцааг зохицуулахад оршино. (§ 1)	Зорилгод хүрсэн түвшин Үндсэн зорилго: төрийн байгууллагын эрхийг тодорхойлох, Дагалдах зорилго: тухайн харилцааг зохицуулах -Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996 оноос эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш тавьсан зорилго, зорилтдоо хүрсэн эсэх, хүрсэн бол ямар үр дүн гарсан бэ?	Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш ⁵ Ямар нэмэлт, өөрчлөлт хийгдсэн бэ?	-төрийн болон орон нутгийн өмчийн эрхийг хуулиар тодорхойлж, холбогдох харилцааг бүрэн зохицуулж чадсан эсэх? -төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, холбогдох харилцааг бүрэн зохицуулж чадсан эсэх? - төрийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээг тодорхойлж, холбогдох харилцааг бүрэн зохицуулж чадсан эсэх? -төрийн өмчийн талаархи бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлж, холбогдох харилцааг бүрэн зохицуулж чадсан эсэх?

⁵ -Нехцел байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нехцел байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэнэ.

<p>Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсын эрдэнсийн сан, Ирээдүйн өв сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, захиран зарцуулалттай болон Монгол Улсын Хөгжлийн Банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Ирээдүйн өв сан корпорацийн болон Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулажад үйлчлэхгүй. (§ 2.2)</p>	<p>Зорилгод хүрсэн түвшин Хуулийн үйлчлэх хүрээ нь хуулийн зорилтод нийцэж байгаа байдал Практикт нийцэж буй байдал Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй этгээдийн зохицуулалт нь практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?</p>	<p>Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш Ямар нэмэлт, өөрчлөлт хийгдсэн бэ? Тохиолдол судлах Бусад улсад сан, даатгалын өмчийн харилцааг хэрхэн зохицуулдаг вэ?</p>	<p>Хуулийн үйлчлэлд хамаарахгүй этгээдийг нэр заасан нь хуулийн зорилтой нийцэж байгаа эсэх? Үйлчлэх хүрээтай холбоотой ямар асуудал практикт үүсч байна вэ? Тэдгээрийн зерэг, серөг үр дагавар юу байна вэ?</p>
<p>Гуравдугаар бүлэг. Төрийн өмчийн удирдлага Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлдгийн хувьд төрийн өмчийн өмчлөгч байх нь практикт хэрхэн нийцэж байна вэ? (§ 8.1.1)</p>	<p>Практикт нийцэж буй байдал⁶ УИХ бүх ард түмнийг төлөөлдгийн хувьд төрийн өмчийн өмчлөгч байх нь практикт хэрхэн нийцэж байна вэ?</p>	<p>Тохиолдол судлах УИХ төрийн өмчээс орон нутгийн өмчид эд хөренгэ шилжүүлэх шийдвэр гаргах нь өнөөдрийн нөхцөл байдалд нийцэж байгаа эсэх?</p>	<p>УИХ-ын статусыг Үндсэн хуульд хэрхэн тодорхойлсон бэ? Монгол Улсын төрийн байгууламжийн хэлбэрийн асуудал?</p>
<p>Улсын Их Хурал төрийн өмчийг барьцаалах шийдвэр гаргах эрхтэй (§ 8.1.4)</p>	<p>Практикт нийцэж буй байдал Төрийн өмчийг барьцаалах шийдвэрийг УИХ гаргах зохицуулалт нь практикт хэрхэн хэрэгждэг вэ? Ямар үр дагавар үүсгэдэг вэ?</p>	<p>Тохиолдол судлах Төрийн өмчийг барьцаалах шаардлага гардаг уу? УИХ-аар төрийн өмчийг барьцаалах шийдвэр гарч байсан эсэх?</p>	<p>Төрийн өмчит компани үйл ажиллагаагаа явуулахад банк, санхүүгийн байгууллагаас зээл авах шаардлага тулгардаг эсэх? Зээл авахад төрийн эрх бүхий байгууллагын барьцаалах шийдвэр шаарддаг эсэх? УИХ төрийн өмчийг барьцаалах шийдвэр гаргах нь зохистой</p>

⁶ -Тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний зерэг болон серөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

			эсэх?
Нийгэмчлэх шийдвэрийг гаргах Улсын Их Хурал гаргах эрхтэй. (§ 8.2)	Практикт нийцэж буй байдал Нийгэмчлэх нь өнөөгийн практикт нийцэж байна уу?	Тохиолдол судлах: Нийгэмчлэх шийдвэр гаргах хууль зүйн үндэслэл байгаа эсэх?	УИХ-аас нийгэмчлэх шийдвэр гаргасан эсэх? Үндсэн хуулийн зохицуулалтад нийцэх эсэх?
Улсын Их Хурал хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах эрхтэй. (§ 8.1.5)	Практикт нийцэж буй байдал УИХ хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах зохицуулалтыг хэрхэн хэрэгжиж байна вэ?	Тохиолдол судлах Бусад улсад хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт гаргадаг эсэх?	Хувьчилж үл болох эд хөрөнгийг нэрлэн жагсааж байгаа нь зохистой эсэх? Хувьчилж үл болох салбарыг тодорхойлох нь хувьчилж үл болох эд хөрөнгийг зааснаас үр дүнтэй эсэх?
Төрийн өмчийн талаархи Засгийн газрын бүрэн эрх (§ 9)	Практикт нийцэж буй байдал Засгийн газар төрийн өмчийн талаарх эрхээ бүрэн хэрэгжүүлж байна уу?	Тохиолдол судлах Засгийн газар хуулийн этгээд байгуулах, түүний дүрмийг батлах бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байна вэ?	Засгийн газар төрийн өмчийн талаарх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүсч байгаа ямар асуудал байна вэ? Эзрэг, сөрөг үр дагавар байгаа эсэх?
Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх (§ 11)	Практикт нийцэж буй байдал Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж чадаж байна уу? Ямар хүндрэл барьшээл байгаа вэ?	Тохиолдол судлах Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг бусад улсад хэрхэн тодорхойлсон байдаг вэ?	Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статусыг тодорхой болгох шаардага байна уу? Төрийн өмчит хуулийн этгээдийн өмчийн удирдлагыг ТӨБЗГ бүрэн хэрэгжүүлж байна уу? Холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эдлэх эрхэд өөрчлөлт оруулах шаардлага

			байгаа эсэх?
Төрийн өмчийн талаарх яам, тусгай газрын эрх хэмжээ (§ 12)	Практикт нийцэж буй байдал Төрийн өмчийн талаарх яам, тусгай газрын хуулиар тодорхойлсон эрх хэмжээ нь бодит байдалд нийцэж буй эсэх?	Тохиолдол судлах Төрийн өмчийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг бусад улс хэрхэн зохицуулсан байdag вэ?	Төрийн захирагааны байгууллагын үйл ажиллагааг аж ахуйн үйл ажиллагаанаас тусгаарлах хувь зүйн үндэслэл хангалттай бий эсэх? Төрийн захирагааны байгууллагын үйл ажиллагаанаас аж ахуйн үйл ажиллагааг салгаж чадсан эсэх?
Дөрөвдүгээр бүлэг. Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх Төрийн өмчит хуулийн этгээд (§ 13)	Практикт нийцэж буй байдал Төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт практикт нийцэж байгаа эсэх?	Тохиолдол судлах Төрийн өмчит хуулийн этгээдийг бусад улсад хэрхэн тодорхойлсон ба?	Төрийн 100 хувийн өмчит хувьцаат компани төрийн өмчит хуулийн этгээд мөн эсэх? Хэрвээ мөн бол төрийн өмчит хуулийн этгээдийн ямар ангилалд багтах вэ? Төрийн өмчит хуулийн этгээдийн ангилал нь төрийн өмчит хуулийн этгээдийг бүрэн хамарч чадаж байгаа эсэх?
Төрийн өмчит үйлдвэрийн газар (§ 15)	Практикт нийцэж буй байдал Төрийн өмчит үйлдвэрийн газар нь хуулийн этгээдийн ямар хэлбэрт хамаарах вэ? Төрийн өмчит үйлдвэрийн газар нь хуулийн этгээдийн хувьд холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх?	Тохиолдол судлах Төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагын шийдвэр гаргалтыг компанийн удирдлагын шийдвэр гаргалттай харьцуулах? Улсын төсөвт үйлдвэрийн газар бий эсэх?	Төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгийн харилцааг ямар хувь тогтоомжоор зохицуулдаг вэ?
Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирага	Практикт нийцэж буй байдал Аж ахуйн тооцоотой	Тохиолдол судлах	Үйлдвэрийн газрын захираптай байгуулах гэрээний асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь

(§ 18, § 19, § 20)	Үйлдвэрийн газрын захирлын эдлэх эрх бодит байдалтай хэр тохирч байна вэ? Үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээ	Үйлдвэрийн газрын удирдлагын асуудлыг бусад улс хэрхэн зохицуулсан байдаг вэ?	Үр дүнтэй вэ?
Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог (§ 21)	Практикт нийцэж буй байдал Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн эд хөрөнгийн харилцааг уг хуулиар бүрэн зохицуулж чадсан эсэх?	Тохиолдол судлах Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн харилцааг бусад улсад хэрхэн зохицуулж байна вэ?	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн эд хөрөнгийн харилцааг уг хуулиар бүрэн зохицуулж чадсан эсэх?
Зургадугаар бүлэг. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах (§ 32- § 65)	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж буй байдал Хувьчлал зохион байгуулахад ямар хүндрэл үүсдэг вэ? Хуульд заасан хувьчлалын зохицуулалт нь хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай зохицуулалт мөн эсэх?	Тохиолдол судлах Хувьчлалын асуудлыг бусад улсад хэрхэн зохицуулсан байдаг вэ?	
Есдүгээр бүлэг. Орон нутгийн өмчийн зүйлс (§ 74-§ 81)	Практикт нийцэж буй байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Тохиолдол судлах	

Тав. Үнэлгээний дүгнэлт

5.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зорилтыг 1 дүгээр зүйлд тодорхойлсон бөгөөд хуулийн үндсэн зорилтыг төрийн байгууллагын эрхийг тодорхойлох, дагалдах зорилгыг эд хөрөнгийн харилцааг зохицуулах гэж томъёолсон гэж үзэж болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996 онд хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 21 жилийн хугацаанд 27 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт гэсэн материалаас дэлгэрүүлж үзнэ үү.) 27 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөс 2 нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хамаарах өөрчлөлт, 3 нь холбогдох хуультай нийцүүлсэн өөрчлөлт, 4 нь тус хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй хуулийн этгээдийг нэмсэн өөрслөлт бөгөөд 20 удаагийн нэмэлт, өөрчлөлт нь төрийн өмчийн харилцааны зохицуулалт байна.

Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй хуулийн этгээдийг тухай бүр нэмснээр төрийн өөрийн өмч, түүний хөрөнгийн харилцааны зохицуулалтын ач холбогдол буурсан. Төрийн хөрөнгө, төсвийн санхүүжилтийн эх үүсвэр бүхий төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын хөрөнгө олж авах, зээмших, ашиглах, данснаас хасах харилцаа төрийн хяналтын гадна үлдэх боломжтой болсон.

Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Ирээдүйн өв сан корпораци зэргээр хуулийн үйлчлэлд хамаарахгүй этгээдийг нэрлэн заасан нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын нэгдмэл, төвлөрсөн байх зарчмыг хөндөж байгаа бөгөөд хуулийн зорилттой нийцэхгүй байна.

Судалгаанд хамрагдсан ихэнх улс нь Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн тухай хуультай бөгөөд уг хуулиар нийтийн ашиг сонирхлын төлөө үйлчилдэг хуулийн этгээдийн харилцааг зохицуулдаг байна. (Төрийн өмчийн талаарх бусад улсын хууль, эрх зүйн зохицуулалтын судалгаанаас дэлгэрүүлж үзнэ үү.)

5.2. Төрийн өмчийн талаарх Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлсон боловч өнөөдрийн нэхцэл байдалд хуулийн зохицуулалт тодорхой бус, хэрэглэхэд төвөгтэй байдал үүсгэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д "Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх" гэж заажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд "Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална" гэж, Хоёрдугаар зүйлийн 1-д "Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна" гэж тус тус заажээ.

Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн зөвхөн төрийн өмчийн өмчлөгч байх нь Үндсэн хуульд заасан "төрийн эрх барих дээд байгууллага" гэсэн статустай зарим талаар нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг төрийн эрх барих дээд байгууллага хэрэгжүүлэхгүй байгаа нь нэгдмэл төрийн байгууламтай манай улсад бүрэн тохирно гэж үзэх үндэслэл бага байна.

Судалгаанд хамрагдсан 26 нэгдмэл улсын хувьд Хятад, Швед, Норвеги, Итали, Финлянд гэсэн 5 улс төрийн өмчөөс гадна орон нутгийн өмчтэй гэсэн мэдээлэл олдсон бөгөөд үлдэх 21 улс нь орон нутгийн өмчтэй гэсэн мэдээлэл олдоогүй болно.

Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлдөг, төрийн эрх барих дээд байгууллага болохын хувьд, түүнчлэн Монгол Улс нь нэгдмэл улс тул төрийн өмчийн мөн орон

нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Иймд Улсын Их Хурлыг төрийн өмчийн, мөн орон нутгийн өмчийн өмчлөгч мөн гэж үзэж түүний бүрэн эрхэд өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Тухайлбал, өмчлөгч нь Улсын Их Хурал тул төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх шийдвэрийг Улсын Их Хурал өөрөө гаргах нь учир дутагдалтай юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т "Улсын Их Хурал төрийн өмчийг барьцаалах шийдвэр гаргах эрхтэй" гэж заасан. Барьцаалах шийдвэрийг өмчлөгч гаргах нь хууль ёсонд нийцнэ. Гэхдээ төрийн бүх өмчийг барьцаалах шийдвэрийг зөвхөн Улсын Их Хурал гаргахаар зохицуулсан нь аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд зарим нөхцөлд хүндрэл үүсэж байна.

Улсын төсвөөс санхүүжилт авдаггүй, аж ахуйн үйл ажиллагааг бие даан эрхэлж орлого олж, зохих хууль тогтоомжийн дагуу улсад татвар, хураамж, төлбөрөө төлдөг аж ахуй эрхлэгч хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад санхүүгийн асуудлаа шийдвэрлэх зорилгоор зээл авах шаардлага байнга биш ч үүсэх тохиодол байдаг.

Төрийн өмчит хуулийн этгээд нь зээл авахад хөрөнгөө барьцаалах шаардлага тулгардаг. Банк санхүүгийн байгууллага нь төрийн эрх бүхий байгууллагын хөрөнгө барьцаалахыг зөвшөөрсөн шийдвэрийг зайлшгүй шаарддаг. Иймд төрийн өмчийг барьцаалах шийдвэрийг гаргах субъектийг барьцаалах хөрөнгө, барьцааны хугацаа, зргэн төлөгдөх нөхцөл, нийтийн ашиг сонирхол зэрэг хүчин зүйлийг харгалzan үзэж тогтоох нь зүйтэй байна.

Улсын Их Хурал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хэрэгжих байгаа өнгөрсөн хугацаанд төрийн өмчийг барьцаалах шийдвэр гаргаж байгаагүй бөгөөд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын судалгаанаас үзэхэд төрийн өмчит хуулийн этгээд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан бичгийг үндэслэн автомашин, машин механизм зэрэг үндсэн хөрөнгө болон конторын барилга, гарааш зэрэг үл хөдлөх хөрөнгөө барьцаалж богино хугацаатай буюу 36 хүртэл сарын хугацаатай зээл авч байжээ.

Төрийн эрх бүхий байгууллага төрийн өмчийг барьцаалах шийдвэрийг барьцаалах хөрөнгө, барьцааны хугацаа, зээлийн зориулалт зэргээс хамааран гаргах нь төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд үүссэн богино хугацааны санхүүгийн хүндрэлийг даван туулахад зэрэг үр дүн авчирна гэж үзэж байна. Түүнчлэн хяналт хариуцлагын асуудлыг анхаарах нь зүйтэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2-т "Нийгэмчлэх шийдвэрийг гагцхүү Улсын Их Хурал гаргах эрхтэй" гэж заасан. Нийгэмчлэх шийдвэр Улсын Их Хурлаас мөн гарч байгаагүй бөгөөд Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавдугаар зүйлийн 2-т "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэж, 3-т "өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно" гэж тус тус заасан болно. Иймд хуульд

заагаагүй үндэслэлээр нийтийн болон хувийн өмчийг нийгэмчлэх шийдвэр гаргах нь Үндсэн хуулийн өмчлөгчийн эрхийг хүлээн зөвшөөрөх зарчимтай нийцэхгүй байна.

Төрийн өмчийн талаарх Засгийн газрын бүрэн эрхийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд тодорхойлохдоо, 5-д "хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дурмийг батлах" гэж заасан байна. Засгийн газраас төрийн өмчит хуулийн этгээд байгуулах шийдвэр гаргахдаа түүний дурмийг батлахыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад болон төрийн захиргааны холбогдох байгууллагад үүрэг болгодог. Энэ нь Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2-т заасан "компани үүсгэн байгуулах хурлаар компанийн дүрмийг хэлэлцэж шийдвэрлэнэ" гэснийг, 16 дугаар зүйлийн 16.1-д заасан "компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн" гэж заасныг, Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчиж байна.

Хуульд тусгайлан заасан бүрэн эрхийг хуульд зааснаас бусад үндэслэлээр буюу Засгийн газрын тогтоолоор шилжүүлж байгаа нь Захиргааны ерөнхий хуультай нийцэхгүй байна. Түүнчлэн негөө талаас төрийн захиргааны байгууллага хуульд заагаагүй бүрэн эрх хэрэгжүүлэх нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа хуульд үндэслэх ёсыг зөрчсөн асуудал болно. Иймд төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, түүний дурмийг батлах зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, өнөөгийн практикийг харгалзан дахин боловсруулах шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг хуульчилжээ. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд зарим хүндрэлтэй асуудал үүсч байна. Тухайлбал, төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий гэж заасан хэдий ч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байна гэж тодорхой заагаагүй. Иймд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (компани)-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж, газрын хуралдаан нь хувьцаа эзэмшигчдийн хурал, газрын хурлын шийдвэр нь хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр мөн гэж үзэхэд учир дутагдалтай байна. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигч байж хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхийг тодорхой зохицуулах шаардлагатай байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дарга, орон тооны бус найман гишүүнээс бүрдэнэ гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар агентлагт олгосон бүрэн эрхийг Засгийн газраас томилогдсон дарга, орон тооны бус найман гишүүн оролцсон хурал хэрэгжүүлдэг. Орон тооны бус найман гишүүн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагч биш бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын удирдах албан тушаалтан байдаг. Иймд хурлаас гаргаж буй хамтын шийдвэрийг "газрын тогтоол" гэх нь учир дутагдалтай бөгөөд "хорооны тогтоол" гэх нь шийдвэрийн агуулгад нийцэх төдийгүй шийдвэрийн ач холбогдлыг нэмэгдуулнэ. Түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн өмчийн газраас төрийн өмчийн бодлого, зохицуулалт нэгдмэл, төвлөрсөн байх, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг "Хороо"-ны түвшинд ажиллуулах санал хүсэлт цөөнгүй ирүүлдэг.

Төрийн өмчит хуулийн этгээд дэх төрийн өмчийн төлөөллийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан тоо баримтаас үзэхэд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хуулийн этгээдэд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хуулийн этгээдэд, Сангийн яам хуулийн этгээдэд, "Эрдэнэс Монгол" компани хуулийн этгээдэд тус тус төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байна. Энэ нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хэрэгжүүлэх төрийн өмчийн бодлого нэгдмэл бус байгааг харуулж байна. Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх бодлого төвлөрсөн байхад анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн төрийн өмчийн хөрөнгийн харилцааг зохицуулах зарим журмыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар баталж мөрдүүлэх шаардлагатай байдаг. Тухайлбал, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам, төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам, төрийн өмчит компанийн дүрмийн загвар, төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам, төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, дуудлагаар худалдах, данснаас хасах журам, төрийн өмчийн хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах журам, түрээсийн төлбөрийн доод жишиг үнэ тогтоох, түрээсийн гэрээний загвар батлах гэх мэт. Эдгээр харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулиар нарийвчлан зохицуулаагүй бөгөөд төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх нэгдсэн бодлого зохицуулалт үгүйлэгдэж байна. Иймд Захиргааны ерөнхий

хуульд нийцүүлэн дээр дурдсан харилцааг зохицуулах журам баталж мөрдүүлэх эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт олгох шаардлагатай байна.

Дээр дурдсанаас үзэхэд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрх зүйн статус, эрх, үүргийг тодорхой болгох нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чухал нелөө үзүүлнэ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн өмчийн талаарх яам, тусгай газрын эрх хэмжээг "эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж, холбогдох газарт оруулна" гэж заажээ. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг тодорхой бус байгаагаас нэг тайланг 2-3 байгууллагад хүргүүлэх, хяналт шалгалт давхардах, тухайн асуудлыг хэд хэдэн байгууллагад танилцуулж батлуулах зэрэг төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаа талаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс санал хүсэлт олноор тавьсан. (төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс ирүүлсэн саналын танилцуулга материалыаас дэлгэрүүлж үзнэ үү.) Төрийн захиргааны байгууллагын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүргийг аж ахуйн үүргээс бүрэн салгаж тусгаарласан зохицуулалт дутагдаж байна. Иймд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон яам, төрийн захиргааны бусад байгууллагын эрх, үүргийг оновчтой тогтоох, чиг үүргийн давхардал үүсгэхгүй байх асуудлыг судлан үзэж, зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

5.3. Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрхийн харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлгээр зохицуулжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ хэмээн тодорхойлж, төрийн өмчит хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг гэж 3 ангилсан байна. Энэ ангилал нь төрийн өмчид үндэслэн байгуулагдсан болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг бүрэн хамарч чадаагүй байна. Тухайлбал уг хуулийн дөрөвдүгээр бүлгийн 21 дүгээр зүйлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлогийн талаар зохицуулсан боловч төрийн өмчит хуулийн этгээд нь дээр дурдсан 3 ангилалд хамаарахгүй байна. Түүнчлэн төрийн өмчит хуулийн этгээдийн дээр дурдсан ангиллын шалгуур үзүүлэлт тодорхой бус байна. Учир нь төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлогоос хамааран төрийн байгууллага, албан газар

болон төрийн өмчит үйлдвэрийн газар хэмээн ангилж гэж үзэж болохоор байна. Гэтэл уг зүйлд "төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн энэлэг, нэгдсэн эмнэлэг" гэсэн нэмэлтийг 2016 онд оруулснаар төрийн өмчит хуулийн этгээдийн ангиллын шалгуур үзүүлэлт харагдахгүй болсон.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орно" гэж заасан бөгөөд уг хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ" гэж заажээ. Эндээс

өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ гэж тодорохойлсон байна. Албан газар нь төрийн байгууллагаас хэрхэн ялгагдахыг хуульд зааж өгөөгүй.

Түүнчлэн төрийн байгууллага гэдэг ойлголтыг улсын төсвөөс санхүүждэг гэдэг ойлголтоор хашиж, төрийн байгууллагыг төсвийн гэж явцуу утгаар ойлгогдохоор томьёлжээ. Өөрөөр хэлбэл төрийн өмч хөрөнгөөр үүсэн байгуулгадаж төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагыг орхигдуулсан байна. 100 хувь төрийн өмчит компани нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит хуулийн этгээд байтал төрийн байгууллагыг дээр дурдсанаар 2 ангилснаар аль ч ангилалд багтахааргүй болгосон атал хуулийн 21, 21¹ дүгээр зүйлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог болон үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг зохицуулсан.

Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг нь аж ахуй эрхлэх үйл ажиллагаа гэж ойлгохоор хуульд тусгасан нь Иргэний хуулийн дугаар зүйлд заасан хуулийн этгээдийн төрөл, хэлбэртэй нийцэхгүй байна. Ашгийн төлөө үйл ажиллагааг эрхэлсэн хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр зохион байгуулна гэж заасан байдаг.

Төрийн өмчит хуулийн этгээдийн талаарх зарим ойлголтоос энд оруулах

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс ирүүлсэн саналд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд ашиглагдаж байгаа аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компани гэсэн нэр томьёог сүүлд батлагдаж буй хуулийн нэршил, компаний тухай хуульд хэрэглэгдэж буй нэр томьёотой уялдуулах гэсэн санал цөөнгүй ирсэн байна. (Төрийн өмчит хуулийн этгээдээс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад асуудлаар ирүүлсэн саналын тухай танилцуулгаас дэлгэрүүлж үзнэ үү)



“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас боловсруулсан “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай” хуулийн төсөлд санал авч байна.

Саналаа turbat@cabinet.gov.mn [mailto:turbat@cabinet.gov.mn] хаягаар болон бичгээр
Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ үү. Холбоо барих утас: 323054

Төслийн файлыг татах

ТБОНӨКТХ-2...

1 / 52

100%

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

1

ФАЙЛЫН САН

Засгийн газрын Хэрэг эрхлэх
газраас 2023 онд зохион
байгуулан хэрэгжүүлсэн
онцлох ажлууд

Засгийн газрын Хэрэг эрхлэх
газрын 2023 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөний
төвч тайлан

Бутец зохион байгуулалтыг
оношлох арга зүйн гарын

МЭДЭЭНИЙ АНГИЛАЛ

ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ

“АЛСЫН ХАРАА-2050”

ШИНЭ МЭДЭЭ

ЗГХЭГ-ЫН ДАРГА Н.УЧРАЛ:
төрийн болон орон
нутгийн өмчит
компанийн бүтээмжийг
нэмэгдүүлэх, засаглалыг
сайжруулах хувьтай
болсноор улстөрийн
нөлөөллийг багасгана
2025-01-07

ЗГХЭГ-ЫН ДАРГА Н.УЧРАЛ
МОНГОЛ УЛС ДАХЬ НУБЫН
СУУРИН ЗОХИЛСУУЛАГЧ ТАПАН
МИШРАГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗВ
2024-12-17

ЗГХЭГ-ЫН ДАРГА Н.УЧРАЛ:
ХАЯГИЙН СИСТЕМИЙГ ГОЛОН
УЛСЫН ЖИШИГГ НИЙЦҮҮЛЭН
ХӨГЖКУУЛНЕ
2024-12-13

Бахрейны Хаант Улстай
харилцаа, хамтын ажиллагаагаа
цэвэрхүүлийн
2024-12-08

Бахрейны Хаант Улстай
харилцаа, хамтын ажиллагаагаа
цэвэрхүүлийн
2024-12-08

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах ажиллагааны хүрээнд:



▪ Хуулийн төсөлд санал авахаар 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2571 дугаар албан бичгийг Засгийн гишүүд, Засгийн газрын зарим агентлаг, УИХ-ын харьяа зарим байгууллага, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар болон "Эрдэнэс Монгол" ХХК, Улсын дээд шүүх, УЕПГ, холбогдох мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага зэрэг нийт 88 байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Түүнчлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2, 38.3-т заасны дагуу хуулийн төслийг ZGXEG-ын cabinet.gov.mn цахим хуудсанд 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр байршуулж санал авсан бөгөөд иргэн Д.Дулмаа, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Бэхбаяр нараас цахимаар санал ирүүлсэн.

- 2024.11.29-ний өдөр Туусин Соёмбо зочид буудлын танхимд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн шинэчлэл ба хөрөнгийн зах зээл" хэлэлцүүлэгт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Ажлын хэсгийн ахлагч Н.Учрал оролцож, төрийн өмчит компанийн хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн асуудлаар илтгэл тавьсан. Хэлэлцүүлэгт төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудын 200 орчим төлөөлөгч оролцсон бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын тогтолцоог төвлөрсөн загварт нийцүүлэн зохион байгуулах, Компанийн тухай хуультай хуулийн төслийг уялдуулах, давхардал уусгэхгүй байхад анхаарах, бие даасан хууль гаргах бодит хэрэгцээ, шаардлагыг тодорхой болгох, ТУЗ-ийн гишүүдийн бие даасан байдлыг хангах, хараат бусаар шийдвэр гаргах боломжийг бурдуулэх нь зүйтэй гэсэн санал, шүүмжлэл гарсан.



- Мөн 2024.12.04-ний өдөр СЭЗИС-ийн Ахисан түвшний сургуулиас зохион байгуулсан "Хараат бус гишигийн үүрэг оролцоо ба Төлөөлөн удирдах зөвлөлийн манлайлал" сэдэвт хэлэлцүүлэгт Ажлын дэд хэсгийн ахлагч Д.Цолмон оролцож, хуулийн төслийн танилцуулгыг хийсэн. Хэлэлцүүлэгт

оролцогчдын зүгээс ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулах, ТУЗ-д эзлэх хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх, цалин, урамшууллын ялгаатай бодлогыг хэрэгжүүлэх, мэргэжлийн, өндөр үр чадвартай, компанийн засаглалаар мэргэшсэн хүнийг сонгож ажиллуулах, тавих шаардлагыг өндөрсгөх, хараат бусаар ажиллах боломж, нөхцөлийг бурдуулэхэд анхаарах шаардлагатай зэрэг саналыг дэвшүүлж байв.



- 2025.01.07-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран төр, хувийн хэвшлийн компани, гишүүн байгууллагуудын төлөөлөл бүхий 100 гаруй оролцогчтой хэлэлцүүлгийг зохион байгуулж, хуулийн төслийн танилцуулга, төрийн өмчит компанийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Ажлын хэсгийн ахлагч Н.Учрал илтгэл тавьсан. Түүнчлэн, ажлын дэд хэсгийн зарим гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан хэлэлцүүлэгт оролцогчдын асуултад хариулж, санал, шүүмжийг авсан.

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН БУТЭЭМЖ, ИЛ ТӨД БАЙДАЛ,
ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН САНАЛЫН ТОВЬЁГ

2025.01.07

Нэг."Хуулийн төсөлд санал авах тухай" ЗГХЭГ-ЫН 2024.12.16-НЫ ӨДРИЙН ХЭГ/2571 ДУГЭРЭР АЛБАН БИЧГИЙН ХАРИУ АЛБАН БИЧГЭР ИРҮҮЛСЭН САНАЛ:

Д/А	Засгийн газрын гишүүн	Ирүүлсэн санал	Тайлбар
1.	Санхүүгийн зохицуулах хороо 2025.01.03 1/22	<p>1.Хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх Зөрчилт шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд "Зөрчилт шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар эзүйлийн 6.18 дахь заалтын "10.11," гэсний дараа "10.31," гэж нэмэхээр заасан буюу Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль зөрчсөн зөрчлийг шалган шийдвэрлэхэр тусгасан байна.</p> <p>Дээрх зохицуулалт нь Санхүүгийн зохицуулах хороо хуульд заасны дагуу санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулж, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд үнэт цаасны компани, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцолч, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоо, Ул хедлөх эд хөрөнгө зуучалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч зэрэг санхүүгийн үйлчилгээг зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхлэлдэг этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зохицуулдаг үндсэн чиг уграгчийн нийцэхгүй байна. Харин төрийн болон орон нутгийн өмчит компанийг хуульд нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг тогтолц хянах төрийн захирагааны байгууллагын чиг үүрэгт уг зөрчлийг шалган шийдвэрлэхээр тусгас боломжтой гэж үзж байна.</p> <p>2.Хуулийн төслийн 2.1 дэх хэсгийг "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Энэ хууль болон эдээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжкоос бууддэнэ" гэж өөрчлөх;</p> <p>3.Хуулийн төслийн 3.1 дэх хэсгийг "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн энэ хуулиар зохицуулнаас бусад харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулиар зохицуулна" гэж өөрчлөх;</p>	Саналыг тусгасан.

<p>4.Хуулийн төслийн 4.1.1, 4.1.2-т тус тус "тер...хяналтын эрхийг хэрэжүүлж байгаа" гэснийг хасаж, тодорхойллыг өөрчлөн нийруулах;</p>	<p>Саналыг тусгасан, төслийн холбогдох заалтыг "хяналт хэрэжүүлж байгаа" гээ өөрчилсөн. Энэ хурээнд тухайлбал, Засгийн газар алтан хувьцаа эзэмших компанийд хяналт хэрэжүүлэх боломжтой болно.</p>
<p>5.Хуулийн төслийн 5.1 дэх хэсгийг 7 дугаар зүйл рүү шилжүүлэх буюу төрийн өмчтөн компанийн талаар баримтлах үндсэн чиглэл рүү нэмэх;</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчтөн компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг нь хуулийг бүхэлд нь хамрах суурь шинжтэй зохицуулалт бол үндсэн чиглэл нь Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг болно. Иймд үндсэн чиглэлд зарчмын асуудлыг тусгах нь зохицуулалтын хүрээг хумих тул саналыг тусгаагүй.</p>
<p>6.Хуулийн төслийн 5.1, 5.2-т заасан зарчмуудын давхардлыг арилгаж, нэгтгэж найруулах;</p>	<p>Саналыг тусгасан.</p>
<p>7.Хуулийн төсөлд "6.3.Энэ хуулийн 9.5, 9.6-д заасан этгээд төрийн болон орон нутгийн өмчтөн компанийн үүсгэн шийдвэр гаргахдаа хувьцаат компани үүстэн байгуулахгүй" гэсэн хэсэг нэмэх;</p>	<p>Тайлбарт дурдсаны дагуу тухайн компанийн хувьцаагаа нийтэд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болж, үнэт цаасны арилжаяа эрхлэх байгууллагаар хувьцаа нь чөвөтэй арилжаалагддаг болсноор нээлттэй хувьцаат компанийн болдог тул үүнийг компани үүсгэн байгуулах шийдвэр гаргахтай холбоотой зохицуулалтад тусгах шаардлагагүй.</p>
<p>8.Хуулийн төслийн 10.5 дахь хэсэгт орон нутгийн өмчийн компанийн дурмийн төслийг боловсруулахад холбогдох этгээдээс санал авах талаар зохицуулалт нэмж тусгах;</p>	<p>Саналыг тусгасан.</p>
<p>9.Хуулийн төслийн 11 дугаар зүйлд төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани охин компани, салбар, төлөөлөгчийн газар байтуулах харилцааг хэрхэн зохицуулалт талаар тусгах;</p>	<p>Саналыг тусгасан.</p>
<p>10.Хуулийн төслийн 12.1 дэх хэсгээс "Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн дүрэмд хувь нийтийн хөрөнгийн хэмжээг тусгах" гэснийг хасах;</p>	<p>Саналыг тусгасан.</p>
<p>11.Хуулийн төслийн 14 дугаар зүйлийн гарчгийг "Төрийн болон орон нутаг нь төрийн болон орон нутгийн өмчтөн компанийн хувьцааг эзэмших" гэж өөрчлөх;</p>	<p>Саналыг тусгасан.</p>
<p>12.Хуулийн төслийн 14.2 дахь хэсгийн "хууль тогтоомжид заасны дагуу" гэснийг "хуульд тусгайлан заасны дагуу" гэж, "арилжааны гэрээний дагуу" гэснийг "Иргэний хуульд заасан арилжааны гэрээний дагуу" гэж тус тус өөрчлөх;</p>	<p>Саналыг тусгасан.</p>
<p>13.Хуулийн төслийн 14.3 дахь хэсгийг "Энэ хуулийн 14.2-т заасны дагуу хувьцааг олж авсан бол тэр, эсхүл орон нутаг тухайн хувьцааг олж авахад зарцуулсан хөрөнгийн зардал болон</p>	<p>Саналыг тусгасан.</p>

<p>хувьцааны бодит үнэлгээг тооцон, түүнээс доошгүй үнээр тухайн хувьцааг худалдана" гэж өөрчилж, "14.4. Төр болон орон нутаг энэ хуулийн 14.2-т заасны дагуу хувьцааг олж авсан компани нь хэзгаарлагдмал хариуцлагатай компани, эсхүл хаалттай хувьцаат компани байх тохиолдолд. Компанийн тухай хульд заасан журмын дагуу бусад хувьцаа эзэмшигчид тэргүүн эзлжид худалдаж авахыг санал болгоно", "14.5. Энэ хуулийн 14.4-т заасны дагуу санал болгосон хувьцааг тэргүүн эзлжид худалдаж аваагүй тохиолдолд нээлттэй дуудлага худалдааг зохион худалдах. Унэ энэ хуулийн 14.4-т зааснаас доошгүй байна", "14.6. Энэ хуулийн 14.2-т заасны дагуу хувьцааг олж авсан компани нь нээлттэй хувьцаат компани бол арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдана" гэсэн хэсэг нэмэх;</p> <p>14. Хуулийн төслийн 15.3 дахь хэсгийн "төлөөлөн удирдах зөвлөл байхгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хуралд" гэснийг хасах.</p>	<p>Саналыг тусгасан.</p>
<p>15. Хуулийн төслийн 16.1, 16.4 дэх хэсгийг өөрчлөн найруулах;</p> <p>16. Хуулийн төслийн 21.3 дахь хэсгийн "орон нутгийн өмчийт асуудал" гэснийг "орон нутгийн өмчийн асуудал" гэж өөрчлөх;</p> <p>17. Хуулийн төслийн 21.3-т "Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандaa Санхүүгийн зохицуулах хорооноос багасан "Компанийн засаглалын кодекс"-ийг дагаж мөрдөх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг үнэлгэх ба төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороо, дарга, гишүүдийнхээ ажлын гүйцэтгэгийг жил бүр үнэлэх" гэсэн заалт нэмэх;</p> <p>18. Хуулийн төслийн 24.1.6.а дэд заалтыг "тухайн компанийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн тав болон түүнээс дээш хувийг өөрөө, эсхүл нацмэл сонирхолтой этгээдтэй дангараа болон хамтран эзэмшигч" гэж өөрчлөн найруулах;</p> <p>19. Хуулийн төслийн 24.1.6.б, 24.1.6.в-д "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн" гэснийг "эрх бүхий албан тушаалтан" гэж тус тус өөрчлөх;</p> <p>20. Хуулийн төслийн 24.6 дахь хэсгийн "мэргэжлийн" гэснийг "Компанийн тухай хуулийн 79 дугээр зүйлд заасан шаардлагыг хангасан" гэж өөрчлөх;</p> <p>21. Хуулийн төслийн 27.2.3 дахь заалтыг "нэр давшигч өөрөө, эсхүл нацмэл сонирхолтой этгээд нь дангараа болон хамтран тав, түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл" гэж өөрчлөн найруулах;</p>	<p>Саналыг тусгасан.</p>
<p>Саналыг тусгасан.</p>	<p>Саналыг тусгасан.</p>

22.Хуулийн төслийн 28.1 дэх хэсгийн "компанийн гишүүнээр томилно" гэснийг "компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилно" гэж өөрчлөх;	Саналыг тусгасан.
23.Хуулийн төслийн 28.7 дахь хэсэгт "Улируулан томилох тохиолдодтгэдэгийн ажлын гүйцэтгэлийн үр дүн хангалттай гэж үнэлэгдсэн байна" гэж нэмэх;	Саналыг тусгасан.
24.Хуулийн төслийн 29.4 дэх хэсгийг өөрчлөн найруулах;	Саналыг тусгасан.
25.Хуулийн төслийн 29.6 дахь хэсэгт "29.6.4.энэ хуулийн 16.5-д заасны датгуу чиглэл өгөх" гэж нэмэх;	Саналыг тусгасан.
26.Хуулийн төслийн 30.3-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний чиг Ургээ хэрэгжүүлэхдээ цаг хугацаа, хүчин чармайлт гаргаснаар компанийн гүйцэтгэлийн үнэлгээнд тодорхой үр дүн гарсан тохиолдолд нэмэгдэл урамшуулалт олондоно" гэж нэмэх;	Саналыг тусгасан.
27.Хуулийн төслийн 30.8, 42.3-т заасан артаачлалуудыг баглахаас өмнө Санхүүгийн зохицуулах хсрээны саналыг авах зохицуулалтыг нэмж тусгах;	Саналыг тусгасан.
28.Хуулийн төслийн 31.1.2 дахь заалтын "Удаа дараа" гэснийг хасах;	Саналыг тусгасан.
29.Хуулийн төслийн 32.4 дэх хэсгийн "33.2-т" гэсний "32.2-т" гэж өөрчлөх;	Саналыг тусгасан.
30.Хуулийн төслийн 33.1 дэх хэсгийн "Сунгаж болно" гэснийг "сунгана" гэж өөрчлөх;	Саналыг тусгасан.
31.Хуулийн төслийн 35.2-т "Цалин хөлс" гэсний өмнө "нэмэлт" гэж нэмэх;	Саналыг тусгасан.
32.Хуулийн төслийн 37.3 дахь хэсгийн "хороонд" гэснийг "хороонд" гэж өөрчлөх;	Саналыг тусгасан.
33.Хуулийн төслийн 47.1-д заасан тайланг хаана хүргүүлэх талаар тусгах;	Саналыг тусгасан.
34.Төрийн болон орон нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2-т "13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5-д төрийн болон орон нутгийн өмчтөй компани" гэж нэмэхгүйзэр харин тус хэсгийн 2 дахь заалтад "төрийн өмчтөй үйлдвэрийн газар" гэснийг "төрийн болон орон нутгийн өмчтөй компани" гэж өөрчлөхөөр тусгах;	Төрийн болон орон нутгийн тухай хуулийн этгээдийн ангилаанд "төрийн болон орон нутгийн өмчтөй компани"-ийг нэмж тусгах бөгөөд аж ахуйн тооцоотой үйлдвэрийг газрыг компанийн хэлбэрт шилжүүлэх талаар хуулийн төслийн 51 дүгээр зүйлд тусгасан. Үүнийг шилжилтийн үеийн зохицуулалтын хурзэнд шийдвэрлэх бөгөөд төрийн өмчтөй үйлдвэрийг хуулийн этгээдийн амтийн хасах асуудлыг Төрийн болон орон нутгийн тухай хуулийн шинэчилсэн найрууллын төслийн хурээнд шийдвэрлэнэ.
35.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу 61.11 дэх хэсэгт "Хувьцааных нь шаардлагатай бапцаас багагүй хэмжээг нь төр зээмшиж төрийн" гэснийг "Төрийн" гэж өөрчлөх.	Саналыг тусгасан.

2.	Монголбанк 2024.12.27 А-1/980	<p>1.Хуулийн төслийн 4.1.1 дэх заалтыг "Төрийн өмчтүү компани" гэж тэр хувьцааг нь ззэмших замаар удирдлагын шийдвэрийг давамгайлан тодорхойлж байгаа, эсхүл хяналтын эрхийг хэрэгжүүлж байгаа компанийг" гэж өөрчлөх;</p> <p>2.Хуулийн төслийн 5.1 дэх хэсгийг "Төрийн болон орон нутгийн өмчтүү компанийн шийдвэр, үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтапна" гэж өөрчлөх;</p> <p>3.Хуулийн төслийн 7.1 дэх хэсгийг "Төрийн өмчтүү компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална" гэж өөрчлөх;</p> <p>4.Хуулийн төслийн 8.1.1 дэх заалтыг "Хувийн хавшиг дамгаардаа нийлүүлэх, хангах боломжгүй байгаа нийгмийн хэрэгцээт зах зээлд оролцох" гэж өөрчлөх;</p> <p>5.Хуулийн төслийн 8.1.2 дахь заалтыг "Тодорхой салбаргүй ёсны монополь үйл ажиллагаа эрхлэх" гэж өөрчлөх;</p> <p>6.Хуулийн төслийн 8.1.3 дахь заалтыг "Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор стратегийн ач холбогдолтой салбаргүй үйл ажиллагаа эрхлэх" гэж өөрчлөх;</p> <p>7.Хуулийн төслийн 8 дугаар зүйлд "8.4.Энэ хуульд зааснаас өөр үндэслэлээр компани байгуулахыг хорилно" гэсэн хэсэг нэмэх; Тухайлсан саналтуй болохыг уламжлж байна.</p>	Саналыг туслаагүй.
3.	Улсын дээд шүүхийн Тамын газрын дарга С.Заяадэлтэр 2025.01.06 05/30		Саналыг туслаасан. Саналыг туслаасан. Саналыг туслаасан. Саналыг туслаасан. Саналыг туслаасан. Саналыг туслаасан. Саналыг туслаасан.

-----00-----

Хоёр.ЗГХЭГ-ЫН ЦАХИМ ХУУДАС (cabinet.gov.mn)-НД БАЙРШУУЛСАН ХУУЛИЙН ТӨСӨЛД ЦАХИМААР ИРҮҮЛСЭН САНАЛ:

Д/А	Иргэн, хуулийн этгээдийн нэр өмчийн газрын дарга Ц.Бэхбаяр 2024.12.23	Ируулсан санал	Тайлбар
1.		<p>Төрийн болон орон нутгийн өмчин тухай хуулийн 77.4-т заасан "Хурлын дарга нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энд зүйлийн 2 дахь хэсэгт заасан буран эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөвлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийтийн хуулийн түүнийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлнэ.</p> <p>Төрийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 77.6-д "Монгол Улсын заасан эрхийг тухайн хот, тосгоны Зөвлөлт хөрөнгөйн эрхийн удирдлагын чиг Ургийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны Зөвлөлт хөрөнгөйн эрхийн гэж заасан.</p> <p>Харин хуулийн төслийн 17.5-д "орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшилийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь аймаг, сум нийспэл, дүүргийн Засаг Дарга байна" гэж заасан нь 2 хуулийн заалт Утга агуулга, чиг Ургийн хувьд өөр байгаа тул нэгдмэл байдлаар боловсрулахад анхаарах;</p> <p>Хуулийн төслийн "...37.7-д зааснаас доош узүүлэлтгэй төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөвлөн үзүүлэлтэй төрийн 2 хуртэлх гишүүн нь төрийн тооны гишүүнтэй байх бөгөөд тэдээрийн 2 хуртэлх гишүүн нь төрийн захиргааны байгууллагын төлөвлөлтөөний байж болно" гэж заасан нь орон нутгийн жижиг компаниудад Түзэйн зардал хөнгөнчлөх боломжийг бүрдүүлж өгч байгаа нь бидэнд маш эзлэх заалт болжээ. Харин 5 хуртэлх гишүүнтэй туз хороодтой байх эсэхийг заалтаяар тодотож өгвөл сайн байна.</p> <p>Хуулийн төслийн тавдугаар 32.2-т "...шаардлага хантасан нэр дэвшигч нь гүйцэтгэх захирлын хэрэгжүүлэх зорилгот түвшний мэдэгдэл боловсруулж, сонгон шалгаруулах комисст хургуулна" гэж заасан. Сонгон шалгаруулах комиссыг хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчээс Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл хуулийн төслийн 21 дүгээр зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагас томилох асуудлыг тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна.</p> <p>Төрийн өмчит компаниудыг хувьцаах хэрэгтэй</p>	<p>Аймаг, сум, нийспэл, дүүргийн Засаг дарга нь тухайн орон нутгийн өмчит компанийн хувьцаа эзэмшигч иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг төлөөлэн түүнийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлнэ.</p> <p>Саналыг тусгаж, хуулийн төслөд 5 хуртэл гишүүнтэй бол туз нь дэргэдээз аудитын хороотой байх зохицуулалтыг тусласан.</p> <p>Саналыг тусгасан.</p>
2.	Иргэн Д.Дулмаа 2024.12.18		<p>Хуулийн төслийн 7.1-д Засгийн газар төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлд "терийн өмчит компанийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах төлөвлөгөө"-г тусган боловсруулж, Улсын Их Хурлаар баттуулах талаар зохицуулсан.</p>

-----00-----

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг
 сайжруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслийг
 Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд бэлтгэх үүрэг бүхий
 Ажлын хэсгийн бүрэлдэхүүний мэдээлэл

Д/д	Нэр	Албан тушаал	Утасны дугаар
1.	Б.Солонгоо	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга	99997021
2.	Д.Цолмон	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	88101375
3.	Б.Ганбат	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх	91911366
4.	Д.Саруул	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	88098212
5.	Б.Төрбат	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын Ахлах шинжээч	88007383
6.	Б.Цэнгэл	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга	99114512
7.	Б.Тэлмүүн	Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга	99087638
8.	Н.Жамънхүү	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга	99187051
9.	Ц.Баяр-Эрдэнэ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга	88117950
10.	Б.Гэрлээ	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын Ахлах менежер	91910203
11.	Г.Давааням	МУИС-Хууль зүйн сургуулийн дэд профессор	91449191

---оо---